

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2008-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2010 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЪЁОГ

Зорилт 1: Хүн ам нийгмийн зохистой бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулах	1 - 18
Зорилт 2: Үйлдвэржүүлэлтийн бодлого хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангах	19 - 42
Зорилт 3: Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах	43 - 51
Зорилт 4: Эрх зүйт төрийг төлөвшүүлж, засаглалын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох	52 - 58
Зорилт 5: Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого	59 - 62

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн
2010 оны хэрэгжилтийн товч танилцуулга

2011.03.16

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Нийслэлийн Засаг даргад нэр заагдсан 169 ажлын хэрэгжилтэнд жилийн эцсийн гүйцэтгэлээр үнэлгээ хийлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан 169 ажлаас 2 ажил 100 хувийн, 10 ажил 90 хувийн, 15 ажил 70 хувийн, 135 ажил 50 хувийн, 7 ажил 30 хувийн, нийтдээ 53.9 хувийн хэрэгжилттэй байна. Тасарсан ажил байхгүй болно.

Засгийн газрын үйл ажиллаганы хөтөлбөрийг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилд хэрэгжүүлэх ажлыг Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн зорилтод тусгаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2009-2012 онд хамтарч ажиллах санамж бичгүүдийг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайд, Боловсрол соёл шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Батлан хамгаалахын сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон холбогдох мэргэжлийн байгууллага Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Жижиг дунд үйлдвэрийн газар, Монголын Хөрөнгийн бирж, Шинжлэх ухааны академи, Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, ОХУ-ын "Зарубежстрой" нээлттэй хувьцаат нийгэмлэгийн удирдлагуудтай байгуулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Засгийн газрын 2010 оны 11-р тогтоолын дагуу "Нутгийн захиргааны байгууллагуудаас иргэдэд үзүүлэх төрийн ажил үйлчилгээний бодлогын зорилтууд, удирдлагын шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн нэгдсэн тайлан мэдээ гаргах журам"-ыг боловсруулан мөрдлөг болгон ажиллаж байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах нутгийн захиргааны байгууллагуудын мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөгөө өгөх семинарыг 5 дугаар сард, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг болон дүүргүүдэд очиж төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилтийн явцтай танилцаж, хяналт-шинжилгээ хийх ажлыг 9 дүгээр сард тус тус зохион байгуулсан.

Хөтөлбөрт тусгагдсан нилээд ажлыг төрийн захиргааны төв байгууллага, олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс Нийслэлийн Засаг даргад нэр заагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангахын тулд салбарын яамдуудтай хамтарч зохион байгуулах асуудлаар 42, олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтарч зохион байгуулах асуудлаар 28, нийт 70 ажлыг хэрэгжүүлж, НИТХ-ын Тэргүүлэгчидийн 22 тогтоол, Нийслэлийн Засаг даргын 56 захирамж гарч, 15 удаагийн уулзалт зохион байгуулж ажиллаа.

Олон улсын байгууллагаас олгосон зээл, тусламж, хөрөнгө оруулалтаар 28, Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 32, Шадар сайдын багц болон яамдын хөрөнгө оруулалтаар 16, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 20, нийт 76 ажлыг хэрэгжүүллээ.

Хотын хүн амыг эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэх, хүний аюулгүй байдал, байгаль орчин, экологи, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах чиглэлд анхаарлаа хандуулж ажиллаа.

Нийслэлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд

“Монголоо ногооруулъя” аян болон Туул голыг хамгаалах “Хатан Туул ба цаг хугацаа” 2 сарын аянд иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтарч цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэлээ. Иргэд, аж ахуйн нэгжүүдийн худалдаалж байгаа мод, тарьц, суулгацны үнийн санал, нөөцийн мэдээллийг төвлөрүүлэн вэб сайтад байршуулж иргэд, байгууллагуудыг бодит мэдээллээр хангах ажил хийгдлээ.

Улаанбаатар хотыг дэлхийн хөгжсөн хотуудын жишигт хүрэхүйц өнгө үзэмжтэй, тоос шороогүй, чийглэг, цэвэр агаартай, тохилог хот болгон хөгжүүлэх зорилготой “Сайхан хот - сайхан амьдрал” болзолт уралдааныг нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд зарласан. Уралдааны үр дүнд нийслэлд 41 усан оргилуур шинээр баригдсанаас гадна байгууллага аж ахуйн нэгж бүрийг орчиндоо 50 метр газрыг гэрэлтүүлэх чадалтай гэрэлтүүлэг тавихыг шаардлага болгон ажилласан нь үр дүнгээ өглөө. Уралдаанд нийт 56 байгууллага, айл өрх уралдаанд шалгарч Нийслэлийн 371 жилийн ойн өдрөөр буюу 11-р сарын 26-ны өдөр Нийслэл, дүүргийн шагналаар шагнагдлаа.

Байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нутгийн иргэдийн нөхөрлөл байгуулах үүсгэл санаачлагыг дэмжиж 7 нөхөрлөл байгуулагдаж 11719 га талбайг хариуцан ажиллаж байна.

Нийслэлийн хэмжээнд нийт цэцэрлэгжүүлсэн болон ойжуулалт хийсэн талбай 467 га, ногоон бүсийн ойн сангийн талбайн хэмжээг 395.0 га-гаар нэмэгдсэн. Ингэснээр нэг хүнд ногдох ногоон байгууламж 5.7 м/кв буюу 4,6 хувь болж байна. Мөн нийт зүлэгжүүлсэн талбай 1.295.249 м/кв буюу 2009 оноос ногоон байгууламжын хэмжээ 22 хувиар өссөн.

Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хийсэн талбайд нийт 7086 уртааш метр хамгаалалтын хашаа барьсан нь хамгаалалтанд анхаарсан чухал ажил болсон.

Гэр хорооллын доторхи авто замыг үе шаттай сайжруулах ажлын хүрээнд

2010 онд гэр хорооллын нөхцлийг сайжруулахад улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 11 км авто зам баригдсан. 2010-2011 онд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих “Хот байгуулалтын салбар” төслийн дотоод эх үүсвэрт 298,0 сая төгрөгийг төлөвлөсөн. Хөнгөлөлттэй зээлээр нийт 3.194.0 сая төгрөгийн хүрээнд 12.3 км авто замын 3 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Авто замын сүлжээг сайжруулах ажлын хүрээнд

- Анх удаа нийслэлийн замын салбарт хөрөнгө оруулалтын шинэ хэлбэр болох Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэй 60,606.2 сая төгрөгийн 20 төсөл, арга хэмжээ
- Бүс орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр улсын төсвийн 4,065.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 14 төсөл арга хэмжээ
- Нийслэлийн замын сангийн 6,467.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 75 төсөл арга хэмжээ
- Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлийн 3,194.0 сая төгрөгийн хөрөнгөөр 3 төсөл, арга хэмжээ
- Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 377.7 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ
- Он дамжин 3 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж нийт 74.705.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан 169 ажлын хэрэгжилтийг ажил тус бүрээр гарган хавсаргав.

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг бүлэг тус бүрээр харуулбал:

№	Агуулга	Заалтын тоо	Хэрэгжилтийн явц						Хувь	
			Тасарсан	Биелэлтийн байдал						
				100%	90%	70%	50%	30%		10%
1.	1-р зорилт: Хүн ам нийгмийн зохистой бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулах.	53	-	-	1	1	46	5	-	49.2
2.	2-р зорилт: Үйлдвэржүүлэлтийн бодлого хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангах.	69	-	2	4	8	53	2	-	55.5
3.	3-р зорилт: Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах.	26	-	-	4	3	19	-	-	32.9
4.	4-р зорилт: Эрх зүйт төрийг төлөвшүүлж, засаглалын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох.	15	-	-	1	1	13	-	-	54.0
5.	5-р зорилт: Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого.	6	-	-	-	2	4	-	-	56.6
НИЙТ		169	-	2	10	15	135	7	-	53.9

Хэрэгжилтийг хангах хугацаагаар нь харуулбал:

Агуулга	Хэрэгжилтийг хангах он						Нийт
	2008-2012	2009-2010	2009-2011	2009-2012	2010-2011	2010-2012	
1-р зорилт: Хүн ам нийгмийн зохистой бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулах.	17	2	-	27	2	5	53
2-р зорилт: Үйлдвэржүүлэлтийн бодлого хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангах.	-	8	3	54	1	3	69
3-р зорилт: Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах.	-	6	2	18	-	-	26
4-р зорилт: Эрх зүйт төрийг төлөвшүүлж, засаглалын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох.	-	1	1	13	-	-	15
5-р зорилт: Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого.	-	-	2	2	-	2	6
Хэрэгжүүлэх нийт ажил	17	17	8	114	3	10	169

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2010 оны хэрэгжилт

Бүлэг - Нэг. ХҮН АМ НИЙГМИЙН ЗОХИСТОЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭНЭЭР ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ

1.1 Эрүүл мэндийн бодлого

1. Дэд бүлэг – 1.1

Зорилт – 1.1.1

Арга хэмжээ – 1.1.1.1 Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилтийн механизмыг төв болон орон нутгийн түвшинд оновчтой болгоно.

Биелэлт: Нийслэлийн хэмжээнд эрүүл мэндийн холбогдолтой 17 үндэсний хөтөлбөр, НИТХ-аас баталсан 3 дэд хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар орон нутгийн холбогдох байгууллагуудыг мэргэжлийн арга зүйгээр хангаж, хянах, туслан зөвлөх үүрэгтэйгээр ажиллаж байна.

ЭМЯ-наас зохион байгуулсан “Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн шинэ чиг хандлагыг хөгжүүлэх замаар нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь” сэдэвт үндэсний семинарт дүүргүүдийн эрүүл мэндийн нэгдлүүдийн төлөөлөлийг хамруулсан.

Семинарт оролцогчдоос Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг цаашид хэрхэн хөгжүүлэх талаар үндэсний үзэл баримтлалыг тодорхойлох, Эрүүл мэндийн анхан шатны тусламжинд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн шинэчлэлийн арга замыг тогтоох зэрэг асуудлаар санал, зөвлөмжийг ЭМЯ, ДЭМБ-д хүргэлээ. Тухайлбал: Нийгмийн эрүүл мэндийн санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилгоор хөтөлбөрт суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлэх, Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх бодлого барих зэрэг саналуудыг хүргэсэн.

Хэрэгжилт – 50%

2. Арга хэмжээ – 1.1.1.3 Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын удирдамжийн дагуу эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын тушаалаар байгуулагдсан “Эрүүл хот” үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан ба хөтөлбөрийн төслийг “Эрүүл хот” үндэсний форумд хэлэлцүүлж, төслийн эцсийн хувилбарыг Засгийн газарт хүргүүлээд байна. “Эрүүл хот” нийслэлийн дэд хөтөлбөрийн биелэлтийг холбогдох газруудаас авч нэгтгэн тайланд үнэлгээ хийлээ. Нийслэлд хэрэгжсэн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай илтгэлийг “Эрүүл хот” үндэсний форум дээр Засаг даргын орлогч Ц.Цогзолмаа тавьж, хэлэлцүүлсэн.

“Эрүүл хот” дэд хөтөлбөрийн хүрээнд ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотод “Эрүүл мэндийн тэгш байдлын үнэлгээ хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах” богино хугацааны төслийг амжилттай хэрэгжүүлээ. Иргэдэд үзүүлж байгаа нийгмийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдалд судалгаа хийж, тулгамдсан асуудлуудыг тодорхойлон, зарим асуудлуудыг нийслэлийн Эдийн засаг нийгмийн 2010 оны зорилтод тусган, хэрэгжүүлж ажилласан. Уг төслийн хэрэгжилтийн явцыг Кени улсад болсон сургалт зөвлөлтөө дээр танилцуулсан ба 7-р сард ДЭМБ-ын мэргэжилтэн ирж танилцаад Нийслэлийг “Сайн хэрэгжүүлсэн” гэж үнэлсэн.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар “Тамхигүй орчин бүрдүүлсэн ажлын байр шалгаруулах хөдөлгөөн өрнүүлэн ажиллах тухай” шийдвэр гарч Монголын Мянганы сорилтын сангийн эрүүл мэндийн төслийн санхүүжилтээр “ТАМХИГҮЙ ОРЧИН БҮРДҮҮЛСЭН АЖЛЫН БАЙР” төслийг 2010 оны 10-р сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. “Тамхигүй орчин бүрдүүлсэн ресторан” шалгаруулах болзлын дагуу 2 дахь жилдээ тамхигүй орчин бүрдүүлсэн ресторан, зоогийн газарт шалгуулалт хийж, “Их төв” ХХК-ий “Зочин бууз” зоогийн газрыг шалгаруулсан. 2010 оны 4-р сараас Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба “Тамхигүй орчин бүрдүүлсэн хамт олон”, Нийслэлийн 3-р Амаржих газар, Баянгол дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл зэрэг байгууллагууд “Тамхигүй орчин бүрдүүлсэн загвар эмнэлэг”, ШУТИСургууль “Тамхигүй их сургууль” болохоор санаачлага гарган, төлөвлөгөө боловсруулан ажиллаж эхлээд байна. Болзлын дагуу 2011 оны 5 дугаар сард шалгаруулалт болно.

“Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо” Нийслэлийн зөвлөгөөнийг Баянзүрх, Сүхбаатар, Баянгол, Багануур, Хан-Уул, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүдэд зохион байгууллаа.

“Нийслэлийн эрүүл-загвар сургууль” хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын хэсэгчилсэн цуврал уулзалтыг 3 удаа зохион байгууллаа. “Эрүүл загвар сургууль”-ийн стандартыг боловсруулах ажлын хүрээнд холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдтэй 2 удаа уулзалт ярилцлага,

ажлын хэсэг 3 удаа хуралдаж стандартын хэрэгжих хүрээ, хувилбаруудыг тодорхойлж хэлэлцсэн. Хөтөлбөрт хамрагдсан сургуулиудад мөрдөгдөх стандартын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан.

Хэрэгжилт – 70%

3. Дэд бүлэг – 1.1

Зорилт – 1.1.4

Арга хэмжээ – 1.1.4.1 Төлбөрийн чадваргүй, амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүй авах эрхийн бичиг олгох үр дүнтэй механизмыг судалж шийдвэрлэнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрхийн бичгийн хөтөлбөрийг Азийн Хөгжлийн банк, Японы ядуурлыг бууруулах сангийн дэмжлэгтэйгээр 2010 оны 12-р сарын 16-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хотын орон гэргүй иргэд, 2011 оны эхний улиралд Сонгинохайрхан дүүргийн ядуу өрхүүд хамрагдана. 2011 онд үлдсэн 8 дүүргийн ядуу өрхийн гишүүдийг эрхийн бичгийн хөтөлбөрт хамруулна. “Орлого орлуулан тооцох” аргаар тодорхойлсон ядуу өрхөд орон нутгийн засаг захиргааны нэгжээр дамжуулан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрхийн бичгийг олгох юм. Ядуу өрхийн гишүүд энэхүү эрхийн бичгээр дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, Нэгдсэн эмнэлгээс тусламж үйлчилгээ, оношлогоо, шинжилгээ, хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ, даатгалын байгууллагатай гэрээтэй ажилладаг эмийн сангуудаас эмийг хөнгөлөлттэй үнээр авах эрхтэй болно. Дүүргийн Эрүүл мэндийн нэгдлүүд өөрсдийн харьяаны эмзэг бүлгийн иргэдэд эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүйгээр үзүүлж байна.

Хэрэгжилт –50%

4. Дэд бүлэг – 1.1

Зорилт - 1.1.5.

Арга хэмжээ-1.1.5.1 Эрүүл мэндийн салбарын эрх зүй, санхүүгийн зохицуулалтын механизмыг боловсронгуй болгоно.

Биелэлт: Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн төслийг шинэчилэх талаар харьяа 29 байгууллагаас давхардсан тоогоор 250 гаруй санал ирсэнийг нэгтгэн ЭМЯ-нд хүргүүлсэн. Санхүүгийн механизмыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, түүнийг мөрдөж ажиллах ажлыг зохион байгуулж Эрүүл мэндийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын ном хэвлүүлж тараасан.

Эрүүл мэндийн сайдын тушаалаар Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих оношийн хамааралтай бүлгийн тоо болон санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлсэн. Хоёр дах шатлалын тусламж үйлчилгээний нэгж өртөг тооцох ажлыг зохион байгуулан ажилласан.

Өрхийн эмнэлгийн санхүүжилтын талаар гарч буй бэрхшээл, тулгамдсан асуудал, өрийн байдалд судалгаа, дүгнэлт хийж, өрхийн эмнэлгийн нэг иргэнээр тооцсон зардлын хэмжээг нэмэгдүүлэх, санхүүжилтийн олон эх үүсвэртэй болгох тухай саналыг өрхийн эмнэлгийн төсвийн зарцуулалтын нарийвчилсан судалгааны хамт ЭМЯ-д хүргүүлсэн. Өрхийн эмнэлгийн санхүүжилт нь тухайн хорооны үндсэн хүн амын тоогоор төсөвлөгддөг учраас хороо, өрхийн эмнэлгийн хүн амын бүртгэл, судалгааны зөрүүтэй байдлыг арилгах, хамтын ажиллагааг сайжруулах үүргийг дүүргүүдийн ЗДТГазарт өгч, нийслэлийн бүх хороодын Засаг дарга нарын ажил дүгнэх үзүүлэлтэд тусгасан.

Нийслэлийн өрхийн эмнэлгүүдийн 2010 оны санхүүжилтийг 6,3 тэр бум төгрөгөөр, тус санхүүжилт дээр 383 сая төгрөгийн төсвийн тодотголыг батлуулж, хуваарийг дүүргүүдийн төрийн санд хүргүүлэн, сар бүр олгож байна. Нийслэлийн дүүргүүдэд шинээр болон өөрчлөн зохион байгуулагдах 20 хороонд өрхийн эмнэлэг байгуулахад шаардагдах 1,7 тэр бум төгрөгийн төсвийн санал боловсруулж Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.

“Өрхийн эмнэлгийн үйлчилгээг гүйцэтгүүлэх гэрээг дүгнэх журам, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлах тухай” Нийслэлийн Засаг даргын захирамжаар дүүргүүдийн Засаг дарга, Эрүүл мэндийн нэгдлийн дарга нарт өрхийн эмнэлгүүдтэй гэрээг шинэчлэн байгуулж ажиллах үүрэг өгөгдсөн.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр - 3 төслийн “Өрхийн эмнэлгийн гурвалсан гэрээг боловсронгуй болгох” ажлын хэсгийн зөвлөхийг урьж, дүүргийн ЗДТГ, Эрүүл мэндийн нэгдлийн холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан “Өрхийн эмнэлгийн нэмэлт санхүүжилтийг олгох шалгуур үзүүлэлтүүд” сэдэвт уулзалт, ярилцлагыг зохион байгуулсан. ЭМЯ, Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр - 3 төслийн төсөлд өрхийн эмнэлгийн гурвалсан гэрээний биелэлтийг дүгнэх болон нэмэлт санхүүжилт олгох шалгуур үзүүлэлтийн саналыг хүргүүлсэн.

Хэрэгжилт –50%

5. Дэд бүлэг – 1.1

Зорилт - 1.1.5.

Арга хэмжээ - 1.1.5.2 Эрүүл мэндийн салбарын төрийн байгууллага болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх оновчтой механизмыг бүрдүүлнэ

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2009 оны тушаалаар байгуулагдсан Салбарын хөгжлийн бодлого, удирдлага, менежментийг дэмжих зорилтын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн чиг үүргийн нэгж хэсэг болох “Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын өнөөгийн хөгжлийн түвшинг үнэлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох”, Төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар эрүүл мэндийн салбарт баримтлах бодлого боловсруулах” асуудлын хүрээнд Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр - 3 төслийн төслийн GVG зөвлөх компаний зөвлөхүүдийн тусламжтайгаар сонгосон 5 аймагт хувийн хэвшлийн хөгжлийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийв. ТХХТ-ийн талаар эрүүл мэндийн салбарын баримтлах бодлогын эхний төслийг боловсруулан ажлын хэсгээр хэлэлцүүлсэн. Нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах замаар түншлэл, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 2 дахь шатлалын мэс заслын тусламж үйлчилгээг “Мон-мэс”, “Номун” эмнэлгүүдээр, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг Баянзүрх дүүргийн 20 хорооны 200 гаруй мянган хүн амд эмнэлгийн хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих сувилал болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн сонгон шалгаруулалтад 45 эрүүл мэндийн байгууллага болон шинээр сонгон шалгаруулалтад орох санал ирүүлсэн 19 байгууллага, нийт 64 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага шалгаруулалтад тэнцэж, Нийслэлийн засаг даргын захирамжаар 2011-2013 онд эрүүл мэндийн даатгалаас санхүүжих эмнэлгүүдийн жагсаалт батлагдаж, дэлгэрэнгүй мэдээллийг нийслэлийн эрүүл мэндийн газрын вэб сайтад тавьж, иргэдэд эрүүл мэндийн даатгалаар үйлчлэх хувийн хэвшлийн эмнэлгүүдийн мэдээллийг тодорхой болгох ажлууд хийгдлээ.

Хэрэгжилт –50%

6. Дэд бүлэг – 1.1

Зорилт - 1.1.6.

Арга хэмжээ - 1.1.6.3 Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын /төрөлжсөн мэргэжлийн, аймаг, дүүрэг, сумын болон өрхийн эмнэлгийн/ үйл ажиллагааны стандартыг шинэчилнэ.

Биелэлт: ЭМЯ-д амаржих газрын стандартыг боловсруулах санал тавьсаны дагуу стандарт боловсруулах ажлын хэсэг ажиллаж төслийг бэлэн болгосон. ЭМЯ-ны Удирдлагын зөвлөл, Стандартын техникийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжигдсэн бөгөөд Үндэсний стандарт хэмжил зүйн газраар батлагдах шатандаа явж байна.

“Өрхийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт”-д өөрчлөлт оруулах тухай саналыг ЭМЯ-д хүргүүлсэн. Эрүүл мэндийн сайдын тушаалаар байгуулагдсан дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Стандартын төслийг нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцүүлсэн. Дүүргийн нэгдсэн эмнэлэг, төвүүдийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг шинэчлэн боловсруулан Стандарт хэмжил зүйн үндэсний төвд батлуулахаар хүргүүлээд байна.

Хэрэгжилт –50%

7. Дэд бүлэг 1.1

Зорилт – 1.1.6

Арга хэмжээ – 1.1.6.4 Нийслэл дэх эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, дүүргийн нэгдсэн эмнэлгийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах талаар судалгаа хийж, харъяа байгууллагын удирдлагуудаас судалгаа авч санал боловсруулан ЭМЯ-д хүргүүлэн сайдын зөвлөлийн хурлаар орж батлагдах шатандаа явж байна. “Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дүрэм, үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын тушаалыг хэрэгжүүлэх ажил эхлээд байна.

Хоёр дахь шатлалын эмнэлгүүдийн орны тоог нэмэгдүүлэх саналаа ЭМЯ-ны Стратеги бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн.

Амаржих газрын бүтэц, үйл ажиллагааны стандарт шинээр боловсруулагдаж батлагдсаны дагуу амаржих газруудад хүний нөөцийн судалгаа, шаардагдах цалингийн тооцоог гаргасан. 2011 онд амаржих газруудад 37 орон тоог нэмэгдүүлэхээр 528 сая төгрөгийн төсвийн төслийг ЭМЯ-д хүргүүлсэн. “Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр-4”-ийн хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Сонгинохайрхан дүүрэгт загвар дүүргийн эмнэлэг байгуулах төсөл хэрэгжихээр судалгааны ажил хийгдэж байна.

Хэрэгжилт –50%

8. Дэд бүлэг – 1.1

Зорилт - 1.1.7

Арга хэмжээ - 1.1.7.6 Өрх, сумын эмнэлэг бүрийг нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багцад заасан эмнэлэгийн тусламж, үйлчилгээг хүн амд бүрэн үзүүлэх чадавхитай болгох, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нь түлхүү хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: 2010 оныг Нийслэлийн Эрүүл мэндийн газраас “Лабораторийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах жил” болгосонтой холбогдуулан өрхийн эмнэлгүүдийн оношлогооны чадавхийг сайжруулах зорилгоор чих хамар хоолой, нүдний тусламж үйлчилгээний оношлогоо, эмчилгээний багаж тоног төхөөрөмжийн судалгааг гаргасны дагуу нэг бүр нь 352.000 төгрөгийн өртөг бүхий пульсоксометрийн аппаратаар 107 өрхийн эмнэлгийг хангаж бүх өрхийн эмнэлгүүд захын цусан дахь хүчилтөрөгчийн хангамжийг тодорхойлж, яаралтай оношлох чадавхийг сайжруулсан. УИХ-ын гишүүний дэмжлэгээр Баянгол дүүргийн өрхийн эмнэлгүүдэд 140,7 сая төгрөгийн үнэ бүхий оношлогооны болон эмгүй эмчилгээний багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан.

“Өрхийн эмч нарын нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үзүүлэх чадавхийг сайжруулах”, “Эмийн харшлаас сэргийлье”, “Томуу,томуу төст өвчний үед 5 хүртэлх насны хүүхдийн эмчилгээнд анхаарах асуудлууд”, “Хавдрын урьдчилан сэргийлэлт ба эмчилгээнд хоол, тэжээлийн үүрэг” зэрэг богино дунд хугацааны кредит сургалтуудад давхардсан тоогоор 265 өрхийн эмч, 24 өрхийн сувилагч нарыг хамруулаа. Нийслэлийн Эрүүл мэндийн газраас боловсруулан, бүтээсэн “Төрөлхийн хөгжлийн гажиг, түүнээс сэргийлэх арга зам” сэдэвт ном, “Эрүүл бие саруул ухаан”, “Халдварт өвчнөөс хамтдаа сэргийлье” иргэдэд зориулсан зайны сургалтын интерактив CD, ЭМЯ-наас 17,8 сая төгрөгийн тамифлу эм, “Томуу, томуу төст өвчнөөс та өөрийгөө болон гэр бүлээ хамгаалаарай” сэдэвт CD, DVD, “БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тусламж үйлчилгээний удирдамж”, “Өрхийн эмнэлэгт хөтөлгөдөх анхан шатны бүртгэлийн маягтын эмхэтгэл” номуудыг 124 өрхийн эмнэлэг бүрт олгож, мэргэжлийн болон сургалт сурталчилгааны гарын авлага материалаар хангасан.

Эрүүл мэндийн анхан шатлалд ажиллах хүний нөөцийн хөтөлбөрийг өөрийн дүүргийн онцлог байдалд тохируулан боловсруулах саналыг дүүргийн ЗДТГ-т хүргүүлсэнээр Эрүүл мэндийн нэгдлийн дарга нар дүүргийн Засаг даргатай байгуулах бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусган, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаар дүүрэг бүр эрүүл мэндийн анхан шатлалд ажиллах дунд хугацааны хүний нөөцийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллаж, өрхийн эмч 518, сувилагч 478 буюу 86,7 хувийн хангамжтай ажиллаж байгаа нь 2009 оны мөн үеэс эмчийн хангамж 11,7 хувиар нэмэгдсэн.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр - 3 төслийн төслийн хүрээнд Эрүүл мэндийн яам, ЭМСХХ-3, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, “VSO” олон улсын байгууллага, “Энэрэнгүй сэтгэл” өрхийн эмнэлгийн хооронд байгуулсан харилцан ойлголцоллын санамж бичгийн дагуу “VSO” олон улсын байгууллагын санхүүжилтээр, Эрүүл мэндийн зөвлөх эмч, тус дүүргийн өрхийн эмч нарт “Эмчлэх чадварыг сайжруулах”, “Анагаахын мэдлэгээ өргөжүүлэх дур хүсэл төрүүлэх”, “Өрхийн эмнэлгийн ажилчдын үйлчилгээний ёс суртахуун, мэргэжлийн хувьд өөртөө итгэлтэй байдлыг дээшлүүлэх”, “Эмчилгээ үйлчилгээний чанар сайжруулах замаар өрхийн эмч нарын хариуцлагыг өндөрсгөх” зэрэг сэдвүүдээр 13 удаагийн, сувилагч нарт “Сувилахуйн чадварыг сайжруулах”, “Сувилахуйн мэдлэгээ өргөжүүлэх дур хүсэл төрүүлэх”, “Сувилахуйн үйлчилгээ, нэр хүндийг сайжруулах”, “Өрхийн эмнэлгийн ажилчдын ёс суртахуун, мэргэжлийн хувьд өөртөө итгэлтэй байдлыг дээшлүүлэх” зэрэг сэдвүүдээр 7 удаагийн ажлын байрны цуврал сургалт явагдаж, нийт 131 эмч, сувилагч хамрагдсан.

Хэрэгжилт –50%

9. Дэд бүлэг – 1.1

Зорилт - 1.1.9.

Арга хэмжээ - 1.1.9.1 Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнийг лабораторийн шинжилгээнд үндэслэн тандах тогтолцоог үндэсний түвшинд бэхжүүлэх арга хэмжээ авна.

Биелэлт: Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнийг лабораториар баталгаажуулах орон нутгийн чадамж хангалтгүй ялангуяа ХӨСҮТ, Баянгол дүүргийн ХӨЭСҮТөвийн лабораторит онош бататгах үйл ажиллагаа хийж байна. Халдварт өвчнийг эрт сэрэмжлэх тандалт мэдээллийн заавар журмын дагуу 124 өрхийн эмнэлгээс 7 хоног бүр мэдээлэл авч ХӨСҮТ-д мэдээлж өвчлөлийн байдалд дүгнэлт хийж, голомтын арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийслэл хотын “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх төв”-ийн бүтэц тогтолцооны санал боловсруулан ЭМСайдын зөвлөлд оруулж хэлэлцүүлсэн. “Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дүрэм, үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын тушаал гарсны дагуу халдварт өвчний тандалт, сэргийлэлтийн алба байгуулахаар бэлтгэл ажил эхлээд байна.

Халдварт өвчний эрт сэрэмжлэх хариу арга хэмжээ авах чадавхийг сайжруулах үүднээс нийслэлийн Эрүүл мэндийн газарт мэргэжлийн нэг боловсон хүчнийг нэмэгдүүлэн авсан. Халдварт өвчний эрт сэрэмжлэх мэдээллийн программыг суулган ажиллахад бэлэн болгон ажлын байран дахь сургалтанд 8 хүнийг хамруулж, ХӨСҮТ-тэй хамтран халдварт өвчний эрт сэрэмжлэх хариу арга хэмжээ авах асуудлаар тандалт мэдээллийг сайжруулахаар дүүрэг тус бүрээс 8 хүнийг сургагч багшаар бэлтгээд байна.

“Халдварт өвчний эрт сэрэмжлэх тандалт мэдээллийн үйл ажиллагааг сайжруулахад салбар хоорондын уялдааг сайжруулъя” сэдэвт сургалтанд 80 хүнийг хамруулж нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Мал эмнэлэгийн газар, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Онцгой байдлын газрын төлөөлөл оролцсон салбар хоорондын ажлын хэсэг томилж “Нийгмийн эрүүл мэндэд ноцтой нөлөө үзүүлж болзошгүй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” хамтран ажиллах журмын төслийг боловсрууллаа.

Хэрэгжилт –50%

10. Дэд бүлэг – 1.1

Зорилт - 1.1.9.

Арга хэмжээ - 1.1.9.4 “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, шинэчлэн боловсруулна.

Биелэлт: Халдварт өвчинтэй тэмцэх тухай үндэсний хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дуусаж байгаатай холбоотойгоор харьяа эрүүл мэндийн байгууллагаас 2002-2009 онуудад халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх 6 дэд хөтөлбөрийн дагуу хийсэн ажлын дүнг нэгтгэн ХӨСҮТ-д хүргүүлсэн.

Нийслэл, дүүргийн халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх бүтэц тогтолцоог сайжруулах тухай саналаа ЭМЯ-д хүргүүлсэн бөгөөд ЭМЯ-с нийслэл хотын халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх бүтэц тогтолцооны талаар санал боловсруулах үүрэг болгосоны дагуу саналаа боловсруулан ЭМЯ-д хүргүүлсэн бөгөөд ЭМЯ-ны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн “Нийслэлд халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх чиглэлээр тодорхой хэмжээний бүтэц байх нь зүйтэй” гэсэн шийдвэр гарсаны дагуу ЭМСайдын тушаал гарахаар төсөл хэлэлцэгдэж байна.

Хэрэгжилт –50%

11. Дэд бүлэг – 1.1

Зорилт - 1.1.19

Арга хэмжээ - 1.1.19.1 “Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого”-ыг боловсруулж, биеийн тамир, спортын эрчимтэй хөгжлийг хангах эрх зүйн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Биелэлт: Нийслэлийн “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулсан бөгөөд салбарын цогц хөтөлбөр батлагдан гарсны дараа батлуулахаар хүлээгдэж байна. Нийслэл, дүүргүүдийн биеийн тамир спортын газар, хороодын 2010 оны улсын төсөвт биеийн тамир спортын арга хэмжээний зардалд нийт 133.2 сая төгрөг, оюутны шигшээ багийн зардалд 55.6 сая төгрөг тус тус хуваарилагдсан.

“Үндэсний шигшээ баг байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын дагуу “Оюутны болон өсвөрийн шигшээ баг”-ийг нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулсан. Дүүргүүдийн Засаг дарга нарын захирамжаар “Өсвөрийн шигшээ баг”-ийг 2006 оноос эхлэн спортын 3-9 төрлөөр байгуулан ажиллуулж байна. Өсвөрийн шигшээ багийг дүүргүүдэд нийт спортын 14 төрлөөр байгуулан, 29 дасгалжуулагч, 471 тамирчин хамрагдан хичээллэж байна.

Хэрэгжилт –50%

12. Дэд бүлэг – 1.1

Зорилт - 1.1.19.

Арга хэмжээ - 1.1.19.2 Биеийн тамир, спортоор хичээллэхийн ач холбогдолыг сурталчилах мэдээлэл, сурталчилгааны ажлыг нэгдмэл байдлаар зохион байгуулна.

Биелэлт: Нийслэлийн хүн ам, байгууллага, хамт олныг биеийн тамир спортын арга хэмжээнд татан оролцуулах календарчилсан төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн талаар дэмжлэг авч бүрэн хэрэгжүүлээ.

Нийслэл, дүүргийн хэмжээнд нийтийг хамарсан биеийн тамир, чийрэгжүүлэлтийн 252 арга хэмжээ, 75 сургалт семинар, бусад 46 арга хэмжээ, нийт 373 арга хэмжээ зохион байгуулж, 5077 байгууллагын 567424 хүн хамруулж, МҮОНТелевиз, UBS телевиз, ТВ-5, ТВ-9, SBN, NTV, Таван цагираг, Өдрийн сонин, УБ таймс, УБ радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр 500 удаа олон нийтэд сурталчиллаа. Нийслэл, дүүргийн хэмжээнд нийт 75 сургалт зохион байгуулж, 2391 хүн оролцлоо.

Цэцэрлэгийн хүүхдүүдийн өглөөний дасгалыг насны ангилалаар, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээлийн өмнө болон завсарлагаанаар хийх дасгалыг бага, дунд, ахлах ангийн гэсэн

ангиллаар боловсруулан зурагт хуудас, ном, CD хэлбэрээр боловсруулан гаргаж 600 гаруй байгууллагад хүргүүлж, нийслэлийн 9 дүүрэгт бодит ажил болгох чиглэлээр хамтран ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 7-17 насны сурагчдын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах аргачлалыг боловсруулан 1000 зурагт хуудас, ном болгон хэвлүүлж багш арга зүйч нарт гарын авлага болгон өглөө.

Хэрэгжилт –50%

13. Дэд бүлэг – 1.1

Зорилт - 1.1.19.

Арга хэмжээ - 1.1.19.3 Нийтийн биеийн тамир, спортын байгууллагын барилга байгууламжийн засвар үйлчилгээ, ашиглалтыг үе шаттай сайжруулна.

Биелэлт: НИТХ-р 166.0 сая төгрөг баталж биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжсэн. Үүнээс орон сууц, хорооллын дунд биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн талбай байгуулахад 69 сая төгрөг; нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдын бие бялдраа чийрэгжүүлэх танхим байгуулахад 40 сая 642.8 мянган төгрөг; оюутны шигшээ багийн зардалд 48 сая 327.2 мянган төгрөг; биеийн тамир, спортын нийтийн арга хэмжээний зардалд 8 сая 30 мянган төгрөг тус тус зарцууллаа.

Сонгинохайрхан, Хануул, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт биеийн тамир, чийрэгжүүлэлтийн 3 талбайг 69,0 сая төгрөгөөр байгууллаа. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 4 сургуульд 700.0 сая төгрөгөөр биеийн тамир спортын талбай байгуулсан.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төв байранд төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх танхим байгуулахаар нийслэлийн орон нутгийн төсөвт суугдсан нийт 40.0 сая төгрөгийн хөрөнгөөр бодибилдинг, аэробикийн тоног төхөөрөмжийг суурилуулсан.

Чингэлтэй дүүрэг 2 байрны дунд сагсан бөмбөгийн талбай, усан цөөрөм, хүүхдийн тоглоомын талбайд бичил цэцэрлэг, 1 цэцэрлэгийн гадна талбай, Баянгол дүүрэг 2 хорооны нутаг дэвсгэрт сагсан бөмбөгийн талбай, Сонгинохайрхан дүүрэг 1 байрны гадна хөлбөмбөгийн иж бүрэн цогцолбор талбай, 2 байрны дунд биеийн тамирын талбайг тус тус байгуулсан.

Хэрэгжилт –50%

14. Дэд бүлэг – 1.1

Зорилт - 1.1.20

Арга хэмжээ - 1.1.20.3 Хяналт-шинжилгээ, судалгааны үр дүн, нотолгоог ХДХВ\ДОХ\БЗДХ-ын эсрэг хариу арга хэмжээ төлөвлөх, шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглана.

Биелэлт: ЭМЯ-наас ХДХВ/ДОХ, БЗДХ-ын харуулдан тандалтын судалгааг 2009-2010 онд нийт 20 аймгийг хамруулан зохион байгуулж судалгааны үр дүнг эцэслэн гаргаад байна. Судалгааны үр дүнгийн тайланг хэвлүүлэн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нар болон холбогдох хүмүүст түгээгээд байна. Бэлгийн замаар дамжих халдварын тусламж үйлчилгээ, эрсдэлт бүлгийн хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээг чанартай явуулах иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх, үнэлгээ хийх зорилгоор ажлын хэсэг Баянгол, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, Багануур, Налайх дүүргийн ЭМН, өрхийн эмнэлэг, 1, 2, 3 дугаар амаржих газарт "Нэг цэгийн үйлчилгээ"- ний үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, дүгнэлт гарган, тухайн байгууллага бүр дээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авлаа. БЗДХ/ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах Үндэсний хорооны ажлын албатай хамтран "Эрсдэлт бүлгийн хүн амд хүрч үйлчлэх тусламж үйлчилгээг сайжруулах" сэдвээр Нийслэлийн хэмжээний зөвлөлгөөнийг дүүргүүдийн удирдлага, эрүүл мэнд хариуцсан албан хаагч нийт 40 хүнийг хамруулан зохион байгуулсан.

Хэрэгжилт –50%

15. Дэд бүлэг – 1.1

Зорилт - 1.1.21

Арга хэмжээ - 1.1.21.2 Нийслэл хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан дүүрэг бүрт усан бассейн бүхий орчин үеийн соёл, спортын цогцолбор барих ажлыг судлан шийдвэрлэнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын багцад Нийслэлийн 6 дүүрэгт баригдах спорт цогцолборын барилгад нийт 15,806.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 60 сая төгрөгийн санхүүжилт хийгдлээ. 2010 онд спорт цогцолборуудын зураг төслийн бэлтгэл, судалгааны ажил хийгдэн, эскиз боловсруулж, 2011 онд ажлын зураг төсвийг иж бүрэн дуусгаж, барилга угсралтын ажил эхлэнэ. Спорт цогцолборын барилгын зураг төслийн ажлыг Эрүүл мэндийн сайд Нийслэлийн удирдлагуудтай уулзсан хурлаар нийслэлийн Зураг төслийн хүрээлэнгээр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэгдсэн.

Зураг төслийг боловсруулах бэлтгэл, судалгааны ажлын явцад ЭМЯ, Улсын биеийн тамир спортын хороо, нийслэлийн Биеийн тамир спортын газар зэрэг мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөн, Налайх

дүүрэгт баригдах 700 хүний, Сүхбаатар, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт баригдах 1000 хүний суудалтай спорт цогцолборын барилгын эскиз боловсруулагдаад байна.

Нийслэлийн 6 дүүрэгт баригдах спорт цогцолборын барилгын газар олголтыг нийслэлийн Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлээд байна. Үүнд:

- Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, Тээвэр хөгжлийн банкны барилгын баруун урд талд 1,35 га
- Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо, 39 дүгээр сургуулийн биеийн тамирын талбайд 0,4 га
- Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, МУИС-ийн Эдийн засгийн их сургуулийн хичээлийн байрны зүүн хойд талд 0,18 га
- Баянгол дүүргийн 15 дугаар хороо, 40 дүгээр сургуулийн баруун талд 0,015 га
- Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Буянт-Ухаа орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Буянт-Ухаа дахь спортын ордны зүүн урд талд 2,3 га
- Налайх дүүргийн 1 дүгээр хороо, Хөл Налайх цэцэрлэгт хүрээлэнгийн зүүн талд 2,0 га газар олгогдоод байна.

2011 оны улсын төсөвт 7 дүүрэгт усан сан байгуулах, 6 дүүрэгт спорт цогцолбор барих хөрөнгийг суулгасан.

Хэрэгжилт –50%

16. Дэд бүлэг – 1.1

Зорилт - 1.1.22

Арга хэмжээ - 1.1.22.1 Шастины нэрэмжит төв эмнэлэгийг түшиглэн телемедициний сүлжээ-төв байгуулна.

Биелэлт: Нийслэлийн Эрүүл мэндийн салбарын мэдээллийн тогтолцоонд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлж ЭМЯ-аас нийслэлийн Эрүүл мэндийн газарт иж бүрэн 15 компьютер, 42 инчийн LCD дэлгэц, IP phone зэрэг техник хэрэгсэл олгосон нь цаашид телемедицины сүлжээнд холбогдох эхлэл тавигдаж байна.

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад мэдээллийн нэгдсэн сантай болох зорилгоор Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын газар зүйн байршилын зураг хийлгэх ажлыг эхлэсэн. Мөн Нийслэлийн эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн 2010-2014 он хүртлэх хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулаад байна.

Харьяа эрүүл мэндийн байгууллагууд цахим архив үүсгэн, үйл ажиллагаа нь тогтмолжиж, дотоод сүлжээнд бүрэн хамрагдсан. Баянгол, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, өрхийн эмнэлгүүд сүлжээгээр холбогдлоо. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын шуурхай хурал зөвөлгөөнийг интернет технологи ашиглан шаардлагатай техник хэрэгсэлүүдээр ханган зохион байгуулан ажиллаж байна.

Хэрэгжилт –50%

17. Дэд бүлэг – 1.1

Зорилт - 1.1.22

Арга хэмжээ - 1.1.22.2 Улаанбаатар хотын эрүүл мэндийн анхан, дунд шатанд өгөгдлийг цахим хэлбэрээр дамжуулах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

Биелэлт: Нийслэлийн Эрүүл мэндийн 27 байгууллагыг нэгдсэн сүлжээнд холбохоор сүлжээний шийдэл гаргах, газар зүйн байршилын кадастарын зураг хийлгүүлэх зорилгоор нийслэлийн 4 дүүргийн 56 өрхийн эмнэлгүүдийн кадастрийн зургыг авч сүлжээний архитектур гаргах ажлыг хийж эхлээд байна. ЭМЯ, түүний харьяа байгууллагуудтай нийслэлийн эрүүл мэндийн газар нийслэлийн эрүүл мэндийн газар VPN сүлжээгээр холбогдоод байна.

Харьяа эрүүл мэндийн байгууллагууд цахим архив үүсгэх программыг Үндэсний Архивын ерөнхий газраас суурилуулан сан хөмрөгийг программд цахимжуулан хадгалах үйл ажиллагааг эхлүүллээ. Мөн Албан хэрэг хөтлөлтийн шинэчилсэн программыг 2011 оноос эхлэн бүрэн хэрэгжүүлэх туршилтийн үйл ажиллагаа явагдсан. ЭМЯ-с зохион байгуулж буй эрүүл мэндийн байгууллагын хооронд онлайн сүлжээгээр албан бичгийг солилцох үйл ажиллагаа бүрэн хэрэгжиж эхлээд байна.

Сүхбаатар, Хануул дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлд нийт 75 компьютер шинээр, 30 өрхийн эмнэлэг тус бүрт 1 иж бүрэн компьютер олгож, дотоод сүлжээнд бүрэн хамруулж интэрнэтэд 100 хувь холбогдсон. Нийслэлийн 124 өрхийн эмнэлгээс 71 буюу 57,7 хувь интэрнэтэд холбогдож, мэдээ, мэдээллийг цахим хэлбэрээр түргэн шуурхай хүргэх боломж нэмэгдсэн. Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагууд хооронд явагдах тушаал,шийдвэр албан тоот, албан даалгаврыг цаасгүй технологид шилжүүлэн албаны мэйл хаягаар харилцаж үйл ажиллагаагаа явуулж байна.

Хэрэгжилт –50%

1.2 Боловсрол, соёл, шинжлэх ухааны бодлого

18. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.2

Арга хэмжээ - 1.2.2.1 Баг бүрт гэр цэцэрлэг байгуулж, хувийн хэвшлийн цэцэрлэг байгуулахыг дэмжин сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Төрийн бус өмчийн цэцэрлэг байгуулах 25 хүсэлт ирснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Нийслэлийн Засаг даргын Захирамжаар томилогдсон ажлын хэсэг ажиллаж дүгнэлтээ гаргаж холбогдох газарт хүргүүлээд байна.

2010 онд төрийн өмчийн цэцэрлэг 10-аар, төрийн бус өмчийн цэцэрлэг 28-аар, нийтдээ цэцэрлэгийн тоо 38-аар нэмэгдсэн. Төрийн өмчийн цэцэрлэгийн орны тоо 1460-аар нэмэгдэж байна. 2010-2011 оны хичээлийн жилд төрийн өмчийн 174, төрийн бус өмчийн 101, нийт 275 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж эдгээрт 54760 хүүхэд хүмүүжиж байна. Энэ нь өнгөрсөн хичээлийн жилээс 6004 хүүхдээр нэмэгдсэн. Эдгээрээс хувилбарт сургалтанд 5292 хүүхэд хамрагдсан.

Хэрэгжилт –50%

19. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.2

Арга хэмжээ - 1.2.2.2 Өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох нормативт зардлыг олгоно.

Биелэлт: 2010 онд Нийслэлд цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох нормативт зардалд 27,506,1 сая төгрөг батлагдсан. Батлагдсан хуваарийн дагуу санхүүжилт хийгдсэн.

Хэрэгжилт –50%

20. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.2

Арга хэмжээ - 1.2.2.4 Цэцэрлэгийг тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр хангаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

Биелэлт: Цэцэрлэгүүдийн тоглоом наадгайг шинэчлэхэд эцэг эх, ДЗМОУБ, БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, УИХ-ын гишүүдийн багцаас нийт 128,757,000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Нийслэлийн 19 цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилсэн. Чийрэгжилтийн төвийг 52 цэцэрлэг байгуулж, 53 цэцэрлэгт энэ ажлын явц 80-89 хувьтай байна. "Сургуулийн өмнөх болон бага боловсролын чанарыг сайжруулах нь" төслийн хүрээнд ЧД-ийн 10 цэцэрлэгийн тоглоом болон сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулсан төдийгүй Дүрслэх урлагийн хичээлийн багц үзүүлэнг нийслэлийн цэцэрлэгүүдэд түгээсэн.

БСШУЯ, НҮБ-ын "Хүүхдийн сан"-гаас нийт 30,364 сая төгрөгийн өртөг бүхий тоглоом, тавилга, гэрийг 7 цэцэрлэгт, тавилга 7 цэцэрлэгт, иж бүрэн гэр 2 цэцэрлэгт олгосон.

ХБНГУ-ын ЭСЯ-ны хөрөнгөөр Хануул дүүргийн 1 цэцэрлэгийн дотоод тохижилтын ажилд 12 сая төгрөг, НҮБ-ын Хүүхдийн сангийн "Бага насны хүүхдийг хөгжүүлэх хувилбарт сургалт хөтөлбөр"-ийн хүрээнд 3 цэцэрлэгт гэр, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай түгээсэн. "Тогтвортой амьжиргаа-2" төслийн хүрээнд нийслэлийн 33 цэцэрлэгийн тохижилт, гал тогооны тоног төхөөрөмж болон сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэлд нийт 176 сая төгрөгний хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн.

Хэрэгжилт –30%

21. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.2

Арга хэмжээ - 1.2.2.5 Цэцэрлэгийн барилга барих, өргөтгөх, засварлах замаар хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7 цэцэрлэгт 199,6 сая төгрөгийн их засварын ажил хийгдэж, шинээр 22 цэцэрлэг, 11 цэцэрлэгийн өргөтгөл баригдаж байгаагаас 10 цэцэрлэгийн шинэ барилга, 11 цэцэрлэгийн өргөтгөлийг хүлээн авснаар цэцэрлэгийн орны тоо 2295-аар нэмэгдсэн. 2011 онд багтаж 3 цэцэрлэгийн өргөтгөл ашиглалтанд орно. Ингэснээр цэцэрлэгийн орны тоо 235 –аар нэмэгдэнэ. Цэцэрлэгийн орны тоо 2009 оноос 944-р нэмэгдсэн. Мөн 69 цэцэрлэгт засвар үйлчилгээ хийгдлээ.

Хэрэгжилт –50%

22. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.3

Арга хэмжээ - 1.2.3.5 Бага боловсролын хамран сургалтыг 95.0 хувьд хүргэнэ.

Биелэлт: 2008-2009 оны хичээлийн жилд бага боловсролын хамран сургалт 96,7 хувьд хүрсэн. 2009-2010 оны хичээлийн жилд бага боловсролын хамран сургалт 92,5 хувьд хүрсэн. 2010-2011 оны хичээлийн

жилд Нийслэлд 206 Ерөнхий Боловсролын сургууль үйл ажиллагаа явуулж байгаагаас төрийн өмчийн 110, төрийн бус өмчийн 96 сургуульд 184595 сурагч суралцаж байна. 1-р ангид 17398 хүүхдийг элсүүлсэн. Үүнээс бага боловсролд 96582 хүүхэд суралцаж байна.

Хэрэгжилт –50%

23. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.4

Арга хэмжээ - 1.2.4.5 Багшийн мэргэжлийн үнэлэмж, нэр хүндийг дээшлүүлж, багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны цалин, хангамжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Монгол улсын Засгийн газрын 2008 оны 54 дүгээр тогтоолын дагуу салбарын албан хаагчдын нийгмийн асуудлыг дээшлүүлэхэд улирлын мөнгөн урамшуулал олгох ажлыг зохион байгуулж 15926 ажиллагчдад 1.476,6 тэрбум төгрөгний урамшуулал олгогдсон. Нийслэлийн Засаг даргын Захирамжийн дагуу Нийслэлийн оны тэргүүний сургууль, цэцэрлэг, сургалтын менежер, нийгмийн ажилтан зэрэг 17 мэргэжлийн аварга шалгаруулах ажлыг зохион байгууллаа.

Хэрэгжилт –50%

24. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.4

Арга хэмжээ - 1.2.4.6 Багш, ажилтнууд сургууль дээрээ мэргэшил дээшлүүлэх, бүтээлчээр ажиллах нөхцөл бүрдүүлэхэд шаардлагатай орчны стандарт боловсруулж, төрийн өмчийн бүх сургуулийн багш нарын өрөө, ажлын байрыг стандартын шаардлагын дагуу тоноглоно.

Биелэлт: 2009-2010 оны хичээлийн жилд Нийслэлийн төрийн өмчийн 79 сургуульд нийт 90 "Багш хөгжлийн төв" байгуулагдан 585 ширхэг компьютер ашиглагдаж, 90 хувь нь интернетэд холбогдсон. Мөн 143 принтер, 70 скайнер, 86 хувилагч, 98 LCD проектор байгаагийн зэрэгцээ 23181 ном, сурах бичиг тус тус ашиглагдаж байна.

Хэрэгжилт –50%

25. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.5

Арга хэмжээ - 1.2.5.1 Хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшинг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Дүйцсэн хөтөлбөрөөр нийт 47 бүлэгт, 9-24 нас ба түүнээс дээш насны нийт 992 хүүхэд хичээллэж байна. Үүнээс 597 хүүхэд бага боловсролд, 278 хүүхэд суурь боловсролд, 117 хүүхэд бүрэн дунд боловсрол эзэмшиж байна.

Хэрэгжилт –50%

26. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.5

Арга хэмжээ - 1.2.5.2 Ерөнхий боловсролын сургуулиас завсардсан сурагчдад албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгоно.

Биелэлт: 2009-2010 он хичээлийн жилд Албан бус Гэгээрлийн Хөгжлийн 6 төвүүдээр нийт 12313 хүн албан бус боловсролын сургалтанд хамрагдсан.

50%

Хэрэгжилт –

27. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.6

Арга хэмжээ - 1.2.6.3 Төрөөс ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг сурах бичгээр хангах график төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна.

Биелэлт: 2009-2010 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад 84 нэрийн 540497 сурах бичиг түгээн сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Үүнд: 12 жилийн сургалттай 1-р ангид 7 нэрийн 110031, 2-р ангид 8 нэрийн 77912, 3-р ангид 7 нэрийн 15608, 4-р ангид 8 нэрийн 35956, 5-р ангид 10 нэрийн 43757, 6-9-р ангид 36 нэрийн 154902, 10-11-р ангид 16 нэрийн 102331 ширхэг сурах бичгийг сургуулиудад хуваарилан хүргүүлсэн.

Хэрэгжилт –50%

28. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.7

Арга хэмжээ - 1.2.7.1. "Үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан сургуулийн хоолны газар, дотуур байрны гал тогоог зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна.

Биелэлт: "Үдийн цай" хөтөлбөрийг "Үдийн хоол" болгон өргөжүүлэх, суралцагчдын хоолны эрүүл ахуйг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэгийг гал тогооны тоног төхөөрөмжөөр хангах ажлыг БСШУ-ны сайд, Нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан "Санамж бичиг"-т тусган ажиллаж байна. Ерөнхий боловсролын 9 сургуулийн гал тогооны тоног төрөөрөмжийг загвар байдлаар шинэчилж нэг сургуульд

25.0 сая төгрөгний өртөгтэй гал тогооны тоног төхөөрөмж суурилуулсан. “Тогтвортой амьжиргаа-2” төслөөр Баянгол дүүргийн 2 сургуульд гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэхээр бэлтгэл ажлыг зохион байгуулж байна.

Хэрэгжилт –50%

29. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.7

Арга хэмжээ - 1.2.7.2 “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам батлан мөрдүүлж, сурагчдыг хөтөлбөрт ээлж дараатай хамруулна.

Биелэлт: 2009-2010 оны хичээлийн жилд “Үдийн цай” хөтөлбөрт 189 сургуулийн 96815 хүүхэд хамрагдсан. Нийт сургуулиудын 82 хувь нь сурагчдад халуун хоолоор үйлчилж байгаа бөгөөд 64 хувь 7 хоногийн 3-5 өдөр халуун хоол өгч байгаа нь цаашид “Үдийн хоол” хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны эхлэл болсон гэж үзэж байна. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын хоол, хүнсний чанар, аюулгүй байдалд хяналт тавих, хүүхдийн хоол хүнсний хангамж, чанарын асуудлаар эцэг, эх, нийлүүлэгч байгууллага, иргэдээс ирүүлсэн гомдол, хүсэлтийг судлан холбогдох байгууллагад санал тавих орон тооны бус хяналтын зөвлөл байгуулж ажиллах тухай БСШУ-ны Сайдын тушаалыг хэрэгжүүлэх “Хяналтын зөвлөлийн ажиллах чиглэлийг тогтоох журам”-ыг баталж, сурагчдын Үдийн цай хөтөлбөрт хэрэглэгдэж байгаа хүнсний бүтээгдэхүүнийг хэрхэн хэрэглэх, хадгалах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай”, цэцэрлэгийн хоол хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн стандарт илчлэгт анхаарч, хоол бэлтгэх, ханган нийлүүлэх үйл явцад хяналт тавих зорилгоор “Үдийн цай” хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт тавих 24 хүний бүрэлдэхүүнтэй 6 багтай ажлын хэсэг байгуулан ажиллууллаа.

Хэрэгжилт –30%

30. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.9

Арга хэмжээ - 1.2.9.1 Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ээлжгүй болгоход чиглэсэн арга хэмжээ авна

Биелэлт: 2010 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 сургуулийн 1600 суудалтай, Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 5 сургуулийн 2520 суудалтай өргөтгөлийн барилгын ажил эхэлсэн. Үүнээс 4 сургуулийн 2200 суудалтай өргөтгөлийн барилгуудыг ашиглалтанд 2011 онд өгөхөөр төлөвлөн ажиллаж байна. Нийт 2 шинэ сургууль, 7 сургуулийн өргөтгөл баригдаж сурагчдын суудлын тоо 4120-аар нэмэгдэнэ. 2009-2010 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 3-р ээлжинд 116 бүлгийн 4131 сурагч хичээллэж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 1882 сурагчаар цөөрсөн байна.

Хэрэгжилт –50%

31. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.9

Арга хэмжээ - 1.2.9.3 Ангийн самбар, тавилга, сурагч, багшийн ширээ, сандлыг ээлж дараатай шинэчилнэ.

Биелэлт: “Тогтвортой амьжиргаа-2” төслөөр 9 сургуулийн техник хэрэгсэл, тавилга, цахилгаан, сандал ширээг шинэчлэх ажлууд хийгдсэн. Улсын Их хурлын гишүүдээс болон БСШУЯ-с багш, сурагчийн ширээ сандал, ангийн самбарыг шинэчлэх ажил шат дараатай хийгдэж 190 бүлэгт 3800 сурагчийн ширээ, 7600 сурагчийн сандал, 190 ангийн самбар, 190 ангид багшийн ширээг шинэчилсэн.

Хэрэгжилт –50%

32. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.9

Арга хэмжээ - 1.2.9.4 Дотуур байр барьж, өргөтгөн, дотуур байрны орчин, ариун цэвэр, усны хангамжийг сайжруулна.

Биелэлт: 2009 онд 74-р сургуулийн дотуур байрыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өргөтгөсөн. Энэ онд батлагдсан төсөв байхгүй тул дотуур байрны нөхцлийг сайжруулах ажил хийгдэж эхээлгүй байна.

Хэрэгжилт –30%

33. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.10

Арга хэмжээ - 1.2.10.1 Зарим аймгийн төвд усан бассейн байгуулж хүүхэд, залуучуудын биеийн тамир, спортоор хичээллэх орчин бүрдүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн Засаг даргын Захирамжаар хотын төвийн 2 сургуулийн орчимд биеийн тамирын чийрэгжүүлэлтийн талбайг байгуулсан. “Мобиком” ХХК-ны 85,0 сая төгрөгийн санхүүжилтээр ЧД-ийн 24-р сургуулийн биеийн тамирын талбайг олон улсын жишигт нийцсэн хөл бөмбөгийн талбайгаар шинэчлэн тохижууллаа.

Хэрэгжилт –30%

34. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.12

Арга хэмжээ - 1.2.12.2 Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг сайжруулж, эрэлт, нийлүүлэлтэд тохирсон мэргэжилтэй ажилтан бэлтгэх төлөвлөлтийг сайжруулна.

Биелэлт: Нийслэлийн Хөдөлмөрийн газар ХХҮГ-аас 2010 онд зарласан Аж ахуй эрхлэх сургалтын төвийг сонгон шалгаруулах тендерт оролцон дэргэдээ аж ахуй эрхлэх сургалтын төвийг байгуулан ажиллаж байна. Тус төв нь ХЭДС-ийн зардлаар аж ахуй эрхлэх үр чадвар олгох чиглэлээр 9 төрлийн сургалтыг зохион байгуулсан. 2010 онд 40 гаруй удаагийн сургалт зохион байгуулж, жижиг бизнес эрхэлдэг болон эрхлэхийг хүссэн 462 иргэнд олон улсын хөдөлмөрийн байгууллагын Бизнесээ эхэл хөтөлбөрийн сургалтыг зохион байгууллаа.

Ажил мэргэжлийн зөвлөх бэлтгэх сургалтыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төрийн болон төрийн бус зарим байгууллагын төлөөллийг хамруулан 3 өдрийн 14 цагийн сургалтыг ХХҮГ-тай хамтран 9 удаа зохион байгуулж, төвийн болон хөдөө орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудын 98 ажилтныг хамруулж, ажил мэргэжлийн зөвлөхийн гэрчилгээ олгосон.

Гадаад хэлний сургалтыг 5 удаа, компьютерийн мэдлэг олгох сургалтыг 5 удаа зохион байгуулж нийт 135 иргэнийг хамруулан англи хэл болон компьютерийн мэдлэгийг нь дээшлүүлж, сертификат олгосон. ХБНГУ-ын Техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран Хотын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд "Явган хүний зам тавигч, цэцэрлэгжүүлэгч бэлтгэх" сургалтын эхний ээлжинд 20 ажил мэргэжилгүй залуучууд хамрагдсан.

Хэрэгжилт –50%

35. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.18

Арга хэмжээ - 1.2.18.1 Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургуульд суралцагчдад нийтийн тээврээр үйлчлүүлэхэд хөнгөлөлт үзүүлнэ.

Биелэлт: Их дээд сургууль, коллеж болон мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагч, оюутныг нийтийн тээврээр үнэ төлбөргүй тээвэрлэх ажлыг зохион байгуулсан. Нийт 116 сургуулийн 80000 сурагч, оюутны мэдээллийн сан бүрдүүлж, нийтийн тээврийн хэрэгслээр зорчих Цахим картыг 2,3-р сард хэвлүүлж, 4-р сараас эхлэн оюутны гар дээр олгогдсон.

Цахим картыг бүрэн ажиллагаанд оруулсанаар үед оюутнуудын нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зорчилтын тоо, чиглэл тус бүрээр тээвэрлэсэн оюутны тоо зэрэг нь бодитойгоор гарах боломж бүрдсэн. Цахим карт нэвтрүүлснээр нийтийн тээврийн үйлчилгээний үндсэн чиглэлийн шугамын орлого нэмэгдсэн.

Хэрэгжилт –50%

36. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.20

Арга хэмжээ - 1.2.20.1 Бүсийн төвүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг төрөөс дэмжинэ.

Биелэлт: БСШУСайд, Нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан хамтран ажиллах "Санамж бичиг"-т тусгагдсаны дагуу шинээр бий болгох "Оюутны хотхон"-ыг Налайх дүүргийн нутаг дэвсгэр Шивэртэйн хөндийд суурьшуулахаар бэлтгэл ажил хангагдаж байна. БСШУЯ-нд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Хэрэгжилт –30%

37. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.25

Арга хэмжээ - 1.2.25.1 Соёлын төвүүдийн барилгыг шинээр барих, их засвар хийх ажлыг дэс дараатай хэрэгжүүлнэ.

Биелэлт: БСШУ-ны сайд, Нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан "Хамтын ажиллагааны гэрээ"-нд тусгагдсаны дагуу Баянгол дүүрэгт Тайваны хүүхэд гэр бүлийг дэмжих сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын хөрөнгө оруулалтаар Хүүхэд залуучуудын соёлын төв байгуулах гэрээг хийж, дүүргийн Засаг даргын захирамжаар 1500м² газар, Сонгинохайрхан дүүрэгт дүүргийн Засаг даргын захирамжаар 0,5 га газрыг соёлын төвийн зориулалтаар эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн. Нийслэлийн Засаг даргын захирамжаар Хануул дүүрэгт 1 га газрыг Соёлын өвийн төвийн барилгын зориулалтаар эзэмших эрхийг шийдвэрлүүллээ.

Мөн "Тогтвортой амьжиргаа-2" төслийн 9,2 сая төгрөгийн санхүүжилтээр Багахангай дүүргийн Соёлын төвийн барилгын тохижилт, Багануур дүүргийн соёлын төвд 27 сая төгрөгийн санхүүжилтээр үзэгчдийн танхимын сандлыг бүрэн шинэчилж, УИХ-ын гишүүн Ц.Батбаярын дэмжлэгтэйгээр Налайх дүүргийн Соёлын төвд 10 сая төгрөгийн техник хэрэгсэл олгож, Хануул дүүргийн дүүргийн соёлын төвийн

барилгад эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 180 сая төгрөгийн барилгын засвар, орон нутгийн төсвөөс 18 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн ажлууд хийгдсэн.

Жил бүр өсөн нэмэгдсээр буй нийслэлийн иргэдийн соёлын эрэлт хэрэгцээг хангах орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор шинээр баригдах Буянт-Ухаа, Яармаг, Ногоон зоорийн орчмын орон сууцны хорооллуудын зураг төсөлд соёл чөлөөт цагийн цогцолборын зураг төслийг гаргаж "Нийслэл 2009-2015" хот байгуулалтын төсөлд хамрагдаж байгаа 18 хорооллын техник эдийн засгийн төлөвлөлтөнд нийт 32020 суудал бүхий соёлын төв байхаар оруулаад байна.

Хэрэгжилт –50%

38. Дэд бүлэг – 1.2

Зорилт - 1.2.28

Арга хэмжээ - 1.2.28.3 Үндэсний түүх, нүүдлийн соёлоо судлан сурталчлах, монгол бичгээ өвлүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, "Монгол бичиг", Морин хуур, уртын дуу", "Монгол хөөмий", "Монгол бий биелгээ", "Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах сэргээн засварлах" хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Биелэлт: "Морин хуур-уртын дуу" дэд хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулдаг мэргэжлийн морин хуурчдын уралдаан хүрээгээ тэлж 4-р сард Олон улсын хэмжээнд нийслэл Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа.

Төв аймгийн Монгол туургатан театрт 10-р сард зохиогдсон Өсвөрийн морин хуурчдын улсын V уралдаанд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн морин хуурчид оролцож тэргүүн, дэд, гутгаар болон шагналт байруудыг тус тус эзэлсэн. Ерөнхий боловсролын сургуулийн 6-10 дугаар ангийн хүүхдүүдийн дунд 5-р сард "Морин хуур, уртын дууг хэн сайн мэдэх вэ" сэдэвт эссе бичлэгийн уралдааныг зарлаж нийт 11 сургууль оролцсон.

Сонгинохайрхан дүүргийн 1 сургуульд Ардын ёс заншлын жишиг танхим байгуулснаар Чингэлтэй дүүргийн 4 сургууль ДЗМОУБ-ын санхүүжилтээр тус танхимыг байгуулсан. Тус танхимуудад 30 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Баянзүрх дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг "Морин хуур сургалт үйлдвэрлэлийн төв"-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлснээр улам өргөжин "Music house" нэртэйгээр дүүргийн иргэд, хүүхэд залуучуудад морин хуур хөгжмийн сургалт, морин хуур урлалын сургалт, морин хуур хөгжмийн зэмсгийн худалдаа зэрэг үйл ажиллагааг явуулж эхлээд байна.

Нийслэлийн дүүргүүдийн соёлын төвүүдэд орон тооны уртын дуу, морин хуур, бүжгийн багш "Ардын ёс заншлын танхим"-ын арга зүйч тус тус ажилласнаар морин хуур, уртын дууны сургалт тогтмолжиж үндэсний ёс заншлаа уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах таатай боломж бүрдэж байна.

"Монгол хөөмий" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр дүүргүүдийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, соёлын төвүүдийн захирал, менежерүүдэд арга зүйн зөвлөгөөг тогтмол үзүүлж, дүүрэг хороодын нийгмийн ажилтнуудад 9-р сард сургалт зохион байгууллаа.

Нийслэлийн хэмжээнд хөөмийчдийн судалгааг Мэргэжлийн ардын авъяастан, эхлэн суралцагч гэсэн 2 ангиллаар явуулж байна.

Сүүлийн үед хөгжмийн янз бүрийн урсгал, чиглэл гарч хөөмийг гажуудуулах явдал гарч буй тул монгол хөөмийг жинхэнэ язгуур утгаар нь заах, сургах, өвлүүлэх зорилгоор Багахангай, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн соёлын төвүүдэд хөөмийн сургалт хичээллүүлж байна.

БНХАУ-ын Манжуур хотод 7-р сард зохиогдсон Аялал жуулчлалын фестивальд 30 гаруй уран бүтээлчдийг оролцуулж "Монгол хөөмэй", "Морин хуур, уртын дуу", үндэснийхээ бүжгийг сурталчлсан.

Сонгинохайрхан дүүрэг, Жаргалантын соёлын төвтэй хамтран 11-р сард Жаргалантын соёлын төвд "Хөөмийгөөр уянгалсан хорвоо" уралдааныг зохион байгуулсан.

"Монголын уламжлалт бий биелгээ" дэд хөтөлбөрийг НИТХ-ын тогтоолоор батлуулсан. Нийслэлийн дүүргүүдэд бий биелээчдийн шинэчилсэн бүртгэл судалгааг явуулсан. Нийслэлийн 3 сургуульд бүжгийн төрөлжсөн анги хичээллэж байна.

Хан-Уул, Багануур, Багахангай, Налайх, Жаргалантын соёлын төвүүдэд бүжгийн дугуйлан тогтмол хичээллэж байгаагаас гадна Баянзүрх дүүргийн Д.Сүхбаатарын нэрэмжит Соёлын төвийн дэргэд ардын бүжгийн дугуйлан хичээллэж дугуйланд суралцагсдад энэ хичээлийн жилд шинээр Баруун Монгол биелгээ, Хотон биелгээ, Торгууд биелгээ, Баяд биелгээ болон бусад бүжгийн сургалтуудыг тогтмол явуулж байна.

Дүүргүүдийн соёлын төвүүдэд нийслэлийн хэмжээнд зохион байгуулах уралдааныг тус тус хуваарилснаар Налайх дүүрэг "Өсвөрийн бий биелээчдийн уралдаан"-ыг 9 дүүргийг хамруулан зохион байгуулсан. Улаанбаатар хотноо 12-р сард зохиогдсон "Биеэр мэтгэсэн угалз" бий биелээчдийн улсын уралдаанд нийслэлийн 9 дүүргийн 100 гаруй биелээчид оролцсон.

“Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах сэргээн засварлах” хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн хэмжээнд 167 түүх соёлын үл хөдлөх дурсгалт газар, барилга байшин, хөшөө дурсгалын бүртгэл мэдээллийн санг шинэчлэх ажлыг зохион байгууллаа.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хамгаалалтын бүсэд барилга байгууламж шинээр барих, хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулахыг зогсоож, бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор Нийслэл, 9 дүүргийн хэмжээнд нийт 125 газрын кадастрын зураглал хийж хамгаалалтын бүс тогтоож аж ахуйн нэгж, байгууллага, дүүргүүдэд хадгалалт хамгаалалтыг хангах гэрээ байгуулан ажиллаж байна.

Богд хааны сэрүүн ордны хамгаалалтын хашааг барьж, Богд хааны номын өргөөг сэргээн засварлах ажлыг эхлүүлээд байна. Их тэнгэрийн аман дахь бичигт хадны дэргэд Овог аймгуудын онгод шүтээн туг өргөцийг шинэчлэн босголоо.

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Д.Сүхбаатар, Х.Чойбалсангийн хөшөөнд нийт 450.0 сая төгрөгийн, Захирагчийн ажлын албаны 31.9 сая төгрөгийн хөрөнгөөр хөшөө дурсгалыг сэргээн засварлах ажлыг хийж байна. Баянзүрх дүүргийн эскадриль, Д.Сүхбаатарын төрсөн гэрийн буйр, Сүхбаатар дүүргийн 30-р байранд байрлах 3 хөшөө, Баянгол дүүргийн Норжмаагийн хөшөөг сэргээн засварласан.

Их тэнгэрийн аман дахь бичигт хадны дэргэд тайлбар бүхий хөшөөг БСШУЯ-ны Соёлын өвийн төвтэй хамтран босгож Бөө мөргөлийн “Дүнгэр” төвийн хамгаалалтанд хүлээлгэн өглөө. “Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлс”-ийн тайлбар, түүхийг англи хэлээр хөрвүүлэн, мэдээллийн сан хийсэн.

Хэрэгжилт –50%

1.3 Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн бодлого

39. Дэд бүлэг – 1.3

Зорилт - 1.3.1

Арга хэмжээ - 1.3.1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санаачилгад тулгуурлан орон нутаг, бүсийн хөгжил, салбарын бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийслэлийн хөтөлбөр”-ийг НИТХ-ийн тэргүүлэгчдийн хуралдаанаар баталж 6 томоохон зорилтын хүрээнд 29 хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэж байна.

2010 оны байдлаар нийслэлийн хэмжээнд 29882 ажлын байр шинээр бүртгэгдэж, 30700 ажлын байрны захиалга, 30395 ажилгүй иргэнийг бүртгэж, нийт бүртгэлтэй иргэдийн 21935 нь буюу 72,1 хувь нь зуучлагдсан байна. ХЭДС-гийн зээлийн хүрээнд нийт 2050 ажлын байр шинээр нэмэгдсэн. Нийт бүртгэлтэй иргэдийн 1.9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байгаагаас 51.5 хувийг тохирох ажилд зуучилсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2006 оны 166 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох зээлийн хүү нөхөн төлөх журам”-ын дагуу банкуудаар дамжуулан жижиг зээл олгож байна. Нийт 443 албан бус хөдөлмөр эрхлэгч, 26 ажилгүй иргэн, 45 аж ахуйн нэгж, байгууллагад 1 тэрбум 645 сая төгрөгийн зээлийг олгосноор 2050 шинэ ажлын байр бий болсон. Нийслэлд жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийн хүрээнд 490 ажлын байр, иргэд аж ауйн нэгжид хүнсний ногоо тариалах, хүлэмж бий болгосноор 436 түр буюу улирлын чанартай ажлын байр бий болсон.

Оюутны хөдөлмөрийн биржид цагийн ажил хийх хүсэлтэй 22150 оюутныг бүртгэж аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 21044 ажлын байранд нийт 19876 оюутан залуусыг нийтийг хамарсан болон мэргэжлийн ба мэргэжлийн бус цагийн ажилд хамруулан зуучлалын үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс 7624 буюу 38.4 хувь нь нийтийн эзэмшлийн гудамж талбайг тохижуулах, мод тарих, зүлэгжүүлэх, арчлах зэрэг нийтийг хамарсан ажилд хамрагдсан бол үлдсэн 12252 оюутан буюу 61.6 хувь нь суралцаж буй мэргэжлийнхээ дагуу болон мэргэжлийн үр чадвар шаардахгүй цагийн ажлын байраар хангагдаж орлогоо нэмэгдүүлсэн байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг 2292 оюутанд залуучуудад үзүүлсэн.

Эмзэг бүлгийн орон гэргүй, орлого багатай иргэдийг нийтийг хамарсан ажилд хамруулж нийт 77 ажлыг дүүрэг, хороод, ТҮК, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран зохион байгуулж давхардсан тоогоор 25452 иргэнийг хамруулж 147 сая төгрөгийн ажлын хөлсийг олгосон.

Хэрэгжилт –50%

Дэд бүлэг – 1.3

Зорилт - 1.3.6

Арга хэмжээ - 1.3.6.2 "Нэг өрх-нэгээс доошгүй ажлын байр" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Биелэлт: Тус хөтөлбөр батлагдан гараагүй байна.

40. Дэд бүлэг – 1.3

Зорилт - 1.3.7

Арга хэмжээ - 1.3.7.1 Эрэлтэд тулгуурласан "Эрхийн бичиг"-ийн сургалтыг орон нутагт өргөжүүлнэ.

Биелэлт: Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ажилгүй иргэдэд үр ашигтай улмаар ажилд зуучлагдах чадвартай болгох замаар "Эрхийн бичгийн" сургалтанд нийслэлийн 9 дүүргийн 5688 иргэн хамрагдаж хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байгаа мэргэжлийг эзэмшсэнээс 3375 буюу 59 хувь нь хөдөлмөрийн чадвартай, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 16-35 насны залуучууд байна.

Хэрэгжилт –50%

41. Дэд бүлэг – 1.3

Зорилт - 1.3.15

Арга хэмжээ - 1.3.15.1 Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон техникийн боловсролын сургуульд суралцагчдын тоог гурав дахин нэмэгдүүлнэ.

Биелэлт: Мэргэжлийн анхан шатны сургалтанд 14164 хүн суралцаж байна.

Хэрэгжилт –50%

1.4 Нийгмийн хамгааллын бодлого

42. Дэд бүлэг – 1.4

Зорилт - 1.4.1

Арга хэмжээ - 1.4.1.1 Нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, тэдний ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх арга хэмжээ авна.

Биелэлт: НХХЯ-ны сайдын тушаалаар баталсан нийгмийн ажилтны ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг танилцуулах, ажил мэргэжлийн талаар дүүрэгчилсэн уулзалт-хэлэлцүүлэгийг зохион байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдан хороодод ажиллаж байгаа хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлэх мэргэжилтнүүдийн багийг байгуулан анхны хурлаа 2010 оны 9-р сарын 7-ны өдөр зохион байгуулж, ажлын төлөвлөгөө болон багийн дүрмээ баталлаа. Байгуулагдсан "Хамтарсан баг"-ийн гишүүдийг хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшүүлэх, сургагч багш бэлтгэх сургалтыг Япон улсын Хүүхдийг ивээх сантай хамтран зохион байгуулж 23 хүнийг сургагч багшаар бэлтгэсэн.

2010 онд нийт 1597 анхан болон дунд шатанд ажилладаг мэргэжилтнүүд, сургууль, хороо, халамжийн төвийн нийгмийн ажилтныг мэргэшүүллээ. 2009 онд 430 мэргэжилтэнийг мэргэшүүлэх сургалтанд хамруулсан бол энэ онд 1597 болж 1167-р өссөн.

Хэрэгжилт –50%

43. Дэд бүлэг – 1.4

Зорилт - 1.4.6

Арга хэмжээ - 1.4.6.1 Нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэж буй төв болон орон нутгийн байгууллагуудын ажил үүргийн зохион байгуулалтыг сайжруулж, нийгмийн хамгааллын үйлчилгээг хүнд сурталгүй, ил тод, шуурхай болгох арга хэмжээ авна.

Биелэлт: Дүүргүүдийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэсүүд бүгд нэг цэгээс иргэдэд үйлчилгээ үзүүлж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийг Нэг хороо-Нэг банк зохион байгуулалттайгаар иргэдэд хүргэж байна. Хороо бүхэнд халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна.

Нийслэлийн хэмжээнд "Халамжийн үйлчилгээний менежер" программыг нэвтрүүлэн дүүргүүдэд хэвшүүлээд байгаа бөгөөд одоо нийслэлийн хэмжээнд нэгтгэж онлайн хэлбэрт шилжүүлэх ажлыг хийхээр бэлдэж байна. Нийгмийн халамжийн менежер програмд халамжийн үйлчилгээнд хамрагддаг бүх иргэдийн бүртгэлийг шивж оруулснаар нэг хүн олон үйлчилгээг зэрэг авах, өөр хороо, дүүрэгт давхардан авах байдал байхгүй болсон. Амьжиргааны түвшин тогтоох шинэчилсэн аргачлал болох Орлогыг орлуулан тооцох аргачлал 2010 онд батлагдсаны дагуу иргэдийг сонгон халамжийн үйлчилгээнд хамруулж байна.

Хэрэгжилт –50%

44. Дэд бүлэг – 1.4

Зорилт - 1.4.11

Арга хэмжээ - 1.4.11.2 “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т үндэслэн бүс нутгийн болон эдийн засаг, дэд бүтцийн хөгжилтэй уялдсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2008 онд шинэчлэн найруулсан “Нийгмийн халамжийн тухай хууль”-д заасан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг явуулах төлөвлөгөөг боловсруулсан.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зураг авалтыг хийж, стандарт боловсруулан шийдвэрлүүлэхээр холбогдох газруудад хүргүүлсэнээр гэрээний загвар аргачлал, хувийн хэргийн маягтын загварыг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраар батлуулан ажиллаж байна. Олон нийтийн үйлчилгээгээр зөвлөгөө өгч сургалтанд хамрах хүсэлтэй 1043, хөдөлмөр эрхэлж орлогын эх үүсвэртэй болоход 3661, сэргээн засах үйлчилгээнд 35, түр байршуулан асрамжлахад 147, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд харагдах 118 иргэнийг хамруулах иргэний судалгааг гарган ажиллаж ирлээ.

Хэрэгжилт –50%

45. Дэд бүлэг – 1.4

Зорилт - 1.4.12

Арга хэмжээ - 1.4.12.1 Хувийн хэвшил, иргэдийн оролцоо, санаачилгад тулгуурлан “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Нийслэлийн хүн амын ядуурлын тандалтын судалгаа”-г 5000 өрхөөс авсаны дагуу 4644 өрхийг ядуурлаас гаргах зорилтыг тавин ажиллаж байна. Нийслэлийн эмзэг бүлгийн бага орлоготой 4644 өрхийн 21895 гаруй иргэний судалгааг нарийвчлан гаргаж өрхийн бүртгэлийн карт нээн мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Дээрхи иргэдийн хувийн ур чадвар хүсэл сонирхлыг харгалзан 7 зорилтот бүлэг болгон ажлын хэсэг байгуулан ажиллаж 1.558.004 мянган төгрөг зарцуулсан.

Халамжийн үйлчилгээний стандарт бий болсноор сувилагч, нийгмийн ажилтан болон төрийн бус байгууллагын оролцоотой мэргэжлийн болон мэргэшсэн бүлэг ажиллуулах тооцоо, мэдээллийг цуглуулах ажил хийгдсэн.

Хэрэгжилт –90%

46. Дэд бүлэг – 1.4

Зорилт - 1.4.12

Арга хэмжээ - 1.4.12.2 “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т хамрагдах өрхийг сонгох, өрхийн хөгжлийн төлөвлөгөө гаргах аргачлалыг боловсруулна.

Биелэлт: Нийслэлийн хэмжээнд 2010 онд өрхийн хэрэгцээ, чадавхи санаачлагыг дэмжих “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлэх замаар 4600-аас доошгүй ядуу өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор Хүмүүнлэгийн ухааны их сургуультай хамтран 23 асуулт бүхий “Нийслэлийн хүн амын ядуурлын тандалтын судалгаа”-г 5000 өрхөөс авсан.

Хэрэгжилт –50%

47. Дэд бүлэг – 1.4

Зорилт - 1.4.12

Арга хэмжээ - 1.4.12.3 Өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн тухайн өрхийг хөгжүүлэх, амьжиргааг дээшлүүлэх ажлыг хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотойгоор зохион байгуулж, хөтөлбөрт хамрагдсан өрхийн мэдээллийн сан байгуулна.

Биелэлт: Ядуурлаас гаргах 4600 өрхийн 18000 иргэнийг бүртгэлжүүлэх ажлыг эхэлж өрх нэг бүрээр явж амьдрал байдлыг нарийвчлан судлан 21000 гаруй иргэнийг бүртгэлжүүлж мэдээллийн сан бүрдүүлсэн. Мэдээллийн санг үндэслэн судалгаанд хамрагдсан 4644 өрхийн 21895 иргэний мэдээлэл бүхий өрхийн картыг өрх тус бүрт нээн хөтөлж, тухайн өрхөд тулгамдаж буй асуудлуудыг багцлан 7 зорилтот бүлэгт ангилсан. “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т хамрагдах өрхийг сонгох, өрхийн хөгжлийн төлөвлөгөө гаргах, Зорилтот бүлгүүдэд хүрч ажиллах талаархи нэгдсэн сургалт семинарыг дүүргүүдийн нийгмийн ажилтануудад зохион байгуулан зааварчлага өгсөн.

Хэрэгжилт –50%

48. Дэд бүлэг – 1.4

Зорилт - 1.4.12

Арга хэмжээ - 1.4.12.4 Нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн ядууралтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Ядуурлын эсрэг хамтдаа” олон улсын байгууллагатай хамтран ажиллах зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулан хамтран ажиллах зорилтын хүрээнд 2010 онд 12 ажил хийхээр төлөвлөгөө гарган нийгмийн халамж, асрамжийн үйл ажиллагаа эрхлэдэг олон улсын болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаа.

“Мерсикорпс” олон улсын байгууллагатай хамтран Сонгинохайран дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажиллах арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Хараагүй иргэдийн холбоо, Стандарт хэмжил зүйн үндэсний төвтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн талаархи семинарыг зохион байгуулсан.

Ядуурлын эсрэг олон улсын өдрөөр “Эмнести интернэшнл” олон улсын байгууллагатай хамтран ядуурлыг бууруулах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтэд таниулах “Хүнийг хүндэл” өдөрлөг, сувилалын цэцэрлэг яслийн 10 дугаар цогцолбортой хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 100 ээжийн чуулга уулзалт, Дэлхийн зөн олон улсын байгууллага, Хүүхдийн төлөө газартай хамтран “Гэр бүл-Хөгжил” зөвлөгөөнийг тус тус зохион байгуулсан.

“ХӨГЖИМ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛД” төслийг НХХЯ, ХХҮГ-тай хамтран зохион байгуулж тэнэмэл амьдралтай 34 хүүхдийг хамрууллаа.

ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран Нийслэлийн хүн ам ядуурлын хамаарлын судалгааг төвийн 6 дүүргийн гэр хорооллын 600 өрхөөс авсан.

Улаанбаатар дээд сургуулийн “Гэр бүл судлалын тэнхэмтэй хамтран Сонгинохайрхан дүүргийн 25 хорооны 50 өрхөд “Гэр бүлийн боловсрол” сургалтыг 1 сарын хугацаанд зохион байгуулсан. Чингэлтэй дүүргийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст үр бүтээлтэй хэрэгжсэн орон нутгийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээгээр бүх дүүргийн ажилтануудад үзүүлэх сургууль зохион байгуулсан.

Хэрэгжилт –50%

49. Дэд бүлэг – 1.4

Зорилт - 1.4.15

Арга хэмжээ - 1.4.15.1 “Хүн байхын учир” аяныг өргөжүүлж, хүүхэд, өсвөр үеийхний “Гэр бүлдээ үүнийг хүснэ”, “Миний паспорт”, “Миний нэрийн хуудас” зэрэг хөдөлгөөн, үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжинэ.

Биелэлт: “Хүн байхын учир” аяны хүрээнд : Халамжийн төв дэх хүүхдийг гэр бүлд нь буцаах “Хүүхэд-гэр бүл” жилийн аяныг Нийслэл дэх халамжийн төвүүдэд зарлаж, дүгнэлээ.

- Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн дунд түүх дурсгалыг танин мэдүүлэх түүнийг хайрлан хамгаалах сэтгэлтэй болгох зорилгоор “Хөшөө дурсгалаа хайрлан хамгаалъя” аялалыг 2010 оны 03 сарын 23-нд 3 дах жилдээ зохион байгуулж, нийт 120 гаруй хүүхэд оролцсон.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжил, оролцоог дэмжих зорилгоор “Хаврын баяр-бидний баяр” урлагын наадам, “Бид чадна” тэмцээнийг зохион байгуулж 300 гаруй хүүхэд оролцсон байна. “Зорилгодоо хүрье- Хүүхдийн хөдөлмөрийг устгая” уриан дор хөл бөмбөгийн тэмцээнийг 70 хүүхдийг оролцуулан хийсэн.
- “Инээмсэглэл бэлэглэе” сайн санааны аяныг зохион байгуулж, 2 дүүргийн таван сургууль оролцлоо. Тус аянд авъяаслаг сурагчид урлагийн тоглолт хийж, энэ тоглолтыг 1000 гаруй хүүхэд үзэж өөрт байгаа илүү зүйлсээ цуглуулан Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төв, Хүүхдийн халамж үйлчилгээний төв зэрэг асрамжийн төвүүдийн хүүхдүүдэд хандив болгон өглөө.

Миний нэрийн хуудас аяны хүрээнд: Халамж, асрамжийн төвд амьдарч буй хүүхдүүдийг хөгжүүлэх, тэдний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Миний эрх үүрэг” сэдэвт хууль эрх зүйн боловсрол олгох тэмцээн, “Дуугаар хөлөглөсөн ирээдүй” урлагийн наадам, “Би Монгол хүүхэд” ёс заншил, өв уламжлалын тэмцээн, “Байгальд эвсэг багачууд” сэдэвт гар зургийн уралдаан, “Таван цагираг” спортын тэмцээн зэргийг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 500 гаруй хүүхдүүдийг оролцуулан, давхардсан тоогоор халамж, асрамжийн төвийн 1500 гаруй хүүхэд үзэж, дэмжин оролцсон байна.

Хэрэгжилт –50%

50. Дэд бүлэг – 1.4

Зорилт - 1.4.15

Арга хэмжээ - 1.4.15.2 Хүүхэд амралт, чөлөөт цагаа өнгөрөөж, мэдээлэл авч байгаа байдалд судалгаа хийж, хүүхэд, өсвөр үеийг хариуцлагатай, бүтээлч, тусч энэрэнгүй, нийгмийн идэвхтэй иргэн болгож төлөвшүүлэх талаар эцэг, эх гэр бүлийн гишүүдийн мэдлэг хандлагыг өөрчлөх сургалт, сурталчилгааг өргөжүүлэх чиглэлээр ТББ-уудтай хамтран ажиллана.

Биелэлт: Дүүрэг, хороодыг түшиглэн нийслэлийн хэмжээнд олон улсын болон төрийн бус байгууллага, орон нутгийн дэмжлэгтэйгээр “Гэр бүлд зөвлөгөө өгөх” 19 төв ажиллаж байна. Хүүхэд гэр бүлтэй ажиллах, гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг ажиллуулах талаар зөвлөмж, гарын авлага гаргаж, хорооны нийгмийн ажилтнуудад хүргүүллээ. Эдгээр төвүүдээр 500 гаруй хүүхэд гэр бүл үйлчилгээ авсан. Залуу гэр бүлд гэр бүлийн боловсрол олгоход чиглэсэн 2 удаагийн сургалтыг Гэрлэх ёслолын ордон, “Гал голомт төв”-тэй хамтран зохион байгуулсан.

“Гэр бүл-Хөгжил” эцэг эхийн зөвлөгөөнийг Дэлхийн зөн-Монгол олон улсын байгууллагатай хамтран Олон улсын Найрамдал төвд зохион байгуулсан. Энэхүү зөвлөгөөнийг угтан “Хүүхдийн төлөө нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх нь” уулзалт, хэлэлцүүлэгийг хүүхэд, гэр бүлийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг эрдэмтэн судлаачид, багш, мэргэжилтнүүд, зохиолч, сэтгүүлч нийт 20 хүнийг оролцуулан хийлээ. Уг уулзалт, хэлэлцүүлгээс хүүхдийн төлөө нийгмийн хариуцлагыг бий болгоход олон нийтийн ойлголт хандлагыг дээшлүүлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, аж ахуйн нэгж байгууллагуудыг татан оролцуулах талаар зөвлөмж, чиглэл гаргасан.

Эцэг эхчүүд энэ зөвлөгөөнөөс өөрсдийн эрх ашиг, дуу хоолойг илэрхийлэх “Нийслэлийн хүүхдийн эцэг эхийн холбоо”-г 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулж эхлээд байна. Одоогийн байдлаар энэ холбооны анхны уулзалт хийгдэж, холбооны дүрэм, ажлын чиглэл, 2010 оны ажлын төлөвлөгөөгөө гарган ажиллаж байна.

“Хос багана” шилдэг гэр бүл шалгаруулах үйл ажиллагааг зохион байгууллаа. Шилдэг гэр бүлүүдийг 9 дүүргээс 9 номинациар шалгаруулан өргөмжилж, хэвлэл мэдээллээр сурталчлах ажлыг МҮОНТ-тэй хамтран зохион байгууллаа.

Хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөгжил төлөвшил хүмүүжилд чиглэсэн ажлууд:

Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангиудын сурагчдын нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх, сурагчдад хууль эрх зүйн мэдлэг чадвар олгох зорилготой “ДЭВЖЭЭ” наадмыг 3 үе шаттайгаар “Боловсрол суваг” телевизтэй хамтран зохион байгууллаа. Тус наадам нь 25 сэдвийн хүрээнд явагдсан бөгөөд 5 сарын турш долоо хоног бүрийн Бямба, Ням гарагт “Боловсрол суваг” телевизээр цацагдаж, хүүхэд багачуудын үзэх дуртай нэвтрүүлгийн нэг болсон.

Хүүхэд өсвөр үеийг хөгжүүлэх, төлөвшүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Монголжингоо”, “Алтан цом”, “Солонго”, “Хаврын баяр бидний баяр” урлагын наадмыг зохион байгуулсан.

Ерөнхий боловсролын сургуулиудад “Оюуны үдийн цай” лекц, “Хүүхдийн байгууллагын 85 жилийн ойд барих миний бэлэг” хүүхдийн бүтээлийн уралдаанд 1500 гаруй хүүхэд оролцуулсан.

“Монгол тэмүүлэл- Сайхан Монгол орон” төрийн бус байгууллагатай хамтран 14 хоног тутамд “Эртэч Монгол хүн” уулзалтыг зохион байгуулж байна. Тус уулзалтыг 14 хоногийн өглөө бүр тогтмол зохион байгуулагдах бөгөөд Нийгмийн салбар бүрийн удирдагч, манлайлагч идэвхтнүүдийг оролцуулж, өсвөр насны хүүхэд, залуучуудад эрт босох Монгол ухаан болон амьдралын ухаан, цаашлаад зорилго тэмүүлэлтэй амьдрахад нь нөлөөлөх зорилготой юм. Уулзалтанд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 2000 гаруй хүүхэд оролцсон.

Хүүхэд багачуудад эх орныхоо түүх дурсгал, ёс заншил, урлаг соёлын өв уламжлалыг танин мэдүүлэх зорилгоор Нийслэлийн сургуулийн өмнөх боловсролынхны дунд “Миний бахархал-Миний эх орон” уриатай “Би монгол хүүхэд” уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгуулж дүгнэлээ. Уралдаанд нийт 115 цэцэрлэг оролцсон.

Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Хүүхэд-шинэ бүхний эхлэл” баярын нэгдсэн өдөрлөгийг 6-р сарын 1-нд Сүхбаатарын талбайд, дүүрэг бүр өөрсдийн нутаг дэвсгэр дээр зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр хүүхдийн байгууллагууд болон аж ахуйн нэгж, зарим хэвлэл мэдээллийн байгууллагууд тусгай хөтөлбөртөйгөөр оролцож хүүхэд багачуудад үйлчилгээ үзүүлээ.

Эдгээр үйл ажиллагаануудад өссөн дүнгээр 120 гаруй мянган хүүхэд хамрагдсан.

Хэрэгжилт –50%

51. Дэд бүлэг – 1.4

Зорилт - 1.4.15

Арга хэмжээ - 1.4.15.3 Хүүхэд, өсвөр үеийхний дунд эрүүл амьдралын дадал хэвшүүлэх, зохистой хооллолтыг эрхэмлэх, хорт зуршлаас татгалзах мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх талаар сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.

Биелэлт: Хүүхэд, өсвөр үеийг гэмт хэрэгт өртөх, мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх ажлыг хүүхдүүдийн дунд сургалт, сурталчилгаа, өсвөрийн сургагч багш бэлтгэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагаануудаар зохион байгуулж байна.

Мансуурлын эсрэг үндэсний төвтэй хамтран өсвөр үеийн сургагч багшаар 6 сургуулийн 125 хүүхдийг сургагч багшаар бэлдэж сертификат олгосон. Мөн “Сургууль-архи, тамхигүй орчин” сэдвийн дор сургалт, хүүхэдэйн жүжиг, богино хэмжээний кино үзүүлж урьдчилан сэргийлэх ажлыг Нийслэлийн 7 дүүргийн 95 сургуулийн нийт 25227 хүүхдийг хамруулсан.

Мансууруулах бодис хэрэглэлтийн тандалт судалгааг холбогдох байгууллагуудтай хамтран ерөнхий боловсролын сургуулийн 1200, их дээд сургуулийн 800 оюутнаас 42 асуумжтай судалгааны хуудсаар суурь судалгаа явуулж, судалгааны тайланг гаргаад байна.

Хорихоос суллагдсан хүүхдүүдийг нийгэмшүүлэх зорилгоор “Хайр бүгдийг найздаа” хүүхдүүдийн чөлөөт уулзалт, ярилцлага, Насанд хүрээгүй хүүхдийн хорих 411-р ангид хүмүүжиж байгаа хүүхдүүдэд зориулсан “Миний Улаанбаатар” өдөрлөгийг зохион байгуулсан.

Хүүхдийн халамж үйлчилгээний төвд ирсэн 36 хүүхдийг “Гадаадын хөтөлбөр-Монголд” ТББ-тай хамтран эрүүл мэндийн үзлэг, сургалтыг зохион явуулж, эд материалын тусламж үзүүлсэн.

“Нарантуул” зах дээр хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн дунд өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгөөр 43 хүүхэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шууд тусалцаа үзүүлж, иргэд олон нийт болон хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд, тэдний эцэг эхчүүдэд ойлголт нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт явуулж, брошур тараан, баримтат кино зэргийг үзүүлж хүүхдийн хөдөлмөрийн талаар тодорхой ойлголтыг нэмэгдүүллээ.

Дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд нийт 30000 гаруй хүүхэд, өсвөр үеийг мансууруулах бодис, хорт зуршлийн талаархи ойлголтыг нэмэгдүүлж, урьдчилан сэргийлсэн.

Хэрэгжилт –50%

1.5 Хүн амын бодлого

Дэд бүлэг – 1.5

Зорилт - 1.5.2

Арга хэмжээ - 1.5.2.1 “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийг зарлана

Биелэлт: НХХЯаманд гэр бүлийн хөгжлийг дэмжих жил болгох тухай асуудлыг тавьсан боловч одоогоор хариу ирээгүй байна.

52. Дэд бүлэг – 1.5

Зорилт - 1.5.6

Арга хэмжээ - 1.5.6.3 Ахмадуудад нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, тэдний чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжийг бүрдүүлэх, чанартай насжилтыг дэмжих зорилгоор аймаг, дүүрэг бүрт орон нутгийн нөөц хөрөнгө, бололцоог ашиглан ахмадын ордон байгуулж ашиглалтад оруулна.

Биелэлт: Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны ахмадын сувилалын барилгын ажилд 2009 онд 50 сая төгрөг батлагдснаас зураг төсвийн ажлыг 10.5 сая төгрөгөөр хийлгэсэн. 2010 онд хөрөнгө батлагдаагүй байна. Чингэлтэй дүүргийн ахмадын сувилалын барилгыг Хануул дүүргийн 12-р хорооны иргэний 26 хүн хүлээж авах хүчин чадалтай ахмадын сувилалын барилгыг худалдан авч, 2010 оны 8-р сарын 6-ны өдөр техникийн комисс ажилласан.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар Хануул дүүргийн 12-р хорооны нутаг дэвсгэр “Сонгино” амралтын урд талд Нийслэлийн өндөр настан ахмадын амралт, сувилалын газрын зориулалтаар 0,24 га газрыг олгогдсон. Нийслэлийн өндөр настан ахмадын амралт сувилалын газрын төслийг хийсэн.

Хэрэгжилт –50%

53. Дэд бүлэг – 1.5

Зорилт - 1.5.10

Арга хэмжээ - 1.5.10.1 Хүүхэд, тэдний өөрийн удирдлагын байгууллага, хөдөлгөөн, хүүхдийн нэгдсэн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хүүхдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан тэдний санал хүсэлтийг шийдвэртээ тусгаж ажиллах талаар нутгийн захиргааны байгууллагыг зөвлөмжөөр хангаж ажиллана.

Биелэлт: “Нийслэл, дүүргийн хүүхдийн холбооны үйл ажиллагааг бэхжүүлэх нь” төсөл хэрэгжсэнээр нийслэл, дүүргийн хүүхдийн холбооны үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

Нийслэлийн хүүхдийн холбооны 2010-2011 оны хичээлийн жилийн анхдугаар нэгдсэн хурлыг 9-р сард зохион байгууллаа. Хуралдаанаар Нийслэлийн хүүхдийн холбооны бүтэц, зохион байгуулалт, дотоод журам, шинэ хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөө баталлаа.

Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Нийслэл, дүүргийн хүүхдийн холбоо хамтран Нийслэл таймс сонины 1 дугаарыг эрхлэн гаргалаа.

Нийслэлийн хүүхдийн төлөөллийг нийслэлийн удирдагуудтай уулзуулах “1:1” уулзалтыг 3-р сард зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд 28 удирдах ажилтан, 45 хүүхэд нийт 70 гаруй хүн оролцлоо. Энэхүү үйл ажиллагаа нь ОУ-ын хүүхдийн нэвтрүүлгийн өдөр /3-р сарын 7-нд/ SBN, MYONP телевизээр нэвтрүүлэг болж гарлаа.

Нийслэлийн 9 дүүргийн “Хүүхдийн чуулган”-ыг зохион байгуулж, дүүргийн түвшинд хүүхдийн өмнө тулгамдсан асуудал болон шийдвэрлэх арга зам тодорхойлогдсон. Дүүргийн чуулганаас гарсан үр дүнг нэгтгэн 5-р сард “Нийслэлийн хүүхдийн асуудлаарх нэгдсэн чуулган” зохион байгуулагдлаа. Чуулганд хүүхдийн 500, насанд хүрэгчдын 100 төлөөлөл оролцсон.

НҮБ-ын Хүүхдийн сан, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө газартай хамтран “Хүүхдийн оролцоо-2010” өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт Хүүхдийн өөрийн удирдлагын 15 байгууллага оролцож, нийт 2000 гаруй хүүхэд оролцсон.

Хэрэгжилт –50%

Бүлэг - Хоёр. ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛТ

2.1. Макро эдийн засаг, санхүүгийн бодлого

54. Дэд бүлэг – 2.1

Зорилт – 2.1.1

Арга хэмжээ – 2.1.1.1 Эдийн засгийн салбаруудын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар өсөлтийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх замаар нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээг 5.0 мянган ам. долларт хүргэх зорилт дэвшүүлсэн. Энэ чиглэлээр Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2010 оны зорилтонд Улаанбаатар хотын эдийн засгийн чадамжийг бэхжүүлэх чиглэлээр нэн тэргүүний ач холбогдол бүхий 4-5 төсөл боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж энэ оны 5 дугаар сарын 28-нд Дэлхийн банк, олон улсын хандивлагч орнууд, банк санхүүгийн байгууллагууд болон дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцуулсан “Улаанбаатар хот - Түншүүдийн зөвлөлдөх уулзалт”-ыг зохион байгуулсан. Тус уулзалтан дээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 85.0 сая ам долларын хөрөнгийн оруулалтын урьдчилсан тооцоо бүхий 4 төслийг доноруудад санал болгосон. Үүнд:

1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл

2. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн болон оюуны багтаамж бүхий үйлдвэрлэлийн төвийг хөгжүүлэх төсөл

3. Улаанбаатар хотын нэгдсэн сувагчлалыг өргөтгөх, дүүргүүдийг хороодтой холбосон өндөр хурдны нэгдсэн сүлжээ бий болгох төсөл

4. Аялал жуулчлалын мэдээллийн хангамжийг сайжруулах төсөл

Донор байгууллагууд, хандивлагчдийн бүрэлдэхүүн бүхий Эдийн засгийн хөгжлийг дэмжих салбар ажлын хэсгийн хуралдаанаар эдгээр төслүүдийг нарийвчилан авч хэлэлцэн хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ. Мөн шинэ санаа, инноваци нэвтрүүлж буй бизнес эрхлэгч нарыг хөхиүлэн дэмжих, тэдэнд хүргэх бизнес инкубаторын үйлчилгээ, үйл ажиллагааг чадваржуулах зорилгоор НХХЯ, МБИҮНХ хамтран Нийслэлийн Засаг даргын ивээл дор “Бизнес инкубатор хөгжилд” сэдэвт олон улсын анхдугаар чуулга уулзалтыг 2010 оны 6 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулсан.

Хэрэгжилт –70%

55. Дэд бүлэг – 2.1

Зорилт – 2.1.2

Арга хэмжээ – 2.1.2.1 Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгож, дунд болон урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулна.

Биелэлт: Нийслэлийн 2011 оны төсвийн хүрээний мэдэгдэлийг гарган хуулийн хугацаанд СЯ-нд хүргүүлсэн ба 2011 оны төсвийн төслийг боловсруулан СЯ-р хянуулж, НИТХ-аар батлуулсан. 2011 онд улс, нийслэлд 26.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр УИХ-аар батлагдсан нь 2010 оноос 29.4 тэрбум төгрөгөөр буурсан.

Хэрэгжилт –70%

56. Дэд бүлэг – 2.1

Зорилт – 2.1.2

Арга хэмжээ – 2.1.2.2 Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх үндэсний тооцооны шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хүрэх түвшин, хөрөнгө оруулалтын хэрэгцээг оновчтой тодорхойлж, эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийн тэнцвэрийг бататгах макро эдийн засгийн зохицуулалтын орчныг сайжруулна.

Биелэлт: Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах чиглэлээр авч буй арга хэмжээ, түүнд зориулан зарцуулж буй төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх үүднээс Улаанбаатар хотын дүүргүүдийн түвшинд ажилгүйдэл, ядуурлын түвшинг судлан гаргах зорилгоор дүүргийн Мянганы хөгжлийн зорилтуудыг тодорхойлох ажил хийгдсэн. Дүүргүүдэд дэд ажлын хэсгүүд байгуулагдан холбогдох судалгааны ажлыг гүйцэтгэж Мянганы

хөгжлийн зорилтуудыг тодорхойлсон эхний төслөө гаргаад байна. Энэ нь нийслэл, дүүргийн бодлогын зорилтын хэрэгжилтийг хэрэгцээт газар нь чиглүүлэх үндсэн баримт бичиг юм.

Дүүргээс дэвшүүлж буй бодлогын зорилтууд, өнөөгийн нөхцөл байдлын судалгааны үр дүнг хэлэлцэх зорилгоор Мянганы хөгжлийн зорилтуудын бодлогын хэлэлцүүлгийг НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран зохион байгуулж, Баянгол, Хан-Уул, Багахангай дүүргүүдийн илтгэлийг жишээ болгон хэлэлцсэн. Мөн Налайх, Сонгинохайрхан дүүргүүдийн Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн явц, туршлагыг танилцуулж, дүүргүүдийн бодлогыг хэлэлцүүлсэн. Үүний үр дүнд дээрх бодлогын баримт бичгийн боловсруулалт сайжирч, дүүрэг бүр өөрийн тулгамдсан онцлог асуудал, хороодын хэрэгцээнд нийцэх шийдвэрлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргах боломжтой болсон.

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2010 оны зорилтонд тусгагдсанаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр нийслэлийн хэмжээнд 20.0 мянган ажлын байр шинээр бий болгож, мөн тооны иргэдийг ажлын байранд зуучлах ажлыг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд 2010 онд 29882 ажлын байр шинээр бий болж, 21935 иргэн ажлын байранд зуучлагдсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн ажлын байрыг нэмэгдүүлэх зээлийн хүрээнд 2050 ажлын байр шинээр бий болсон. Нийтийг хамарсан 22 төрлийн ажилд эмзэг бүлгийн орлого багатай 501 хүн хамрагдаж 32 сая 143 мянган төгрөгийг хөдөлмөрийн хөлсөнд авсан.

Хэрэгжилт –90%

57. Дэд бүлэг – 2.1

Зорилт – 2.1.2

Арга хэмжээ – 2.1.2.6 Улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийг бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв хотуудын зорилтот хөтөлбөр, төсөл, арга хэмжээтэй уялдуулан хуваарилж хэрэгжүүлнэ.

Биелэлт: Улсын төсвийн болон бүс орон нутгийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг тухайн салбарын сайдаас шилжүүлсэн эрхийн хүрээнд зохион байгуулж санхүүжүүлэх ажлыг гүйцэтгэлээ.

Хотын эдийн засаг, нийгмийн 2009-2012 онд хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 2009 онд Монгол улсыг хөгжүүлэх сан, улс, нийслэлийн төсвөөс 49.1 тэрбум, 2010 онд улс, нийслэлийн төсөв, өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр нийт 123.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. 2011 онд улсын төсвөөс 123.7 тэрбум, нийслэлийн төсвөөс 98.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр батлагдсан. Нийт 2009-2011 онд 395.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр байна.

Хэрэгжилт –70%

58. Дэд бүлэг – 2.1

Зорилт – 2.1.9

Арга хэмжээ – 2.1.9.2 Дэд бүтэц хөгжсөн бүсийн тулгуур төв-хот, аймгийн төвүүдэд аж үйлдвэрийн парк байгуулах ажлыг хөрөнгө оруулалт, эдийн засгийн бодлогоор дэмжинэ.

Биелэлт: “Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл технологийн парк байгуулах, газрын бүс тогтоох тухай” НИТХ-ын тогтоолоор Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт 403,3 га газар, Багахангай дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 96 га газар, Налайх дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 3,0 га газар аж үйлдвэрийн паркийн зориулалтаар батлагдсан.

Үйлдвэрлэл технологийн парк байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Багануурт Бионанотехнологийн үйлдвэрлэл технологийн парк, Багахангай, Налайх, Хан-Уул дүүргүүдэд үйлдвэрлэл, технологийн паркийн үүрэг, аж ахуйн нэгжийн төлөөлөлийн ажлын хэсэгт ажиллан ТЭЗҮ боловсруулахад санал өгч оролцсон. Паркийн ТЭЗҮ-г ХХААХҮЯ-наас Нийслэлд хүлээлгэн өгсөн. ХХААХҮ-ийн сайдын 2010 оны А/81 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэг “Үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай” журмын төслийг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдаас гаргасан саналыг тусган дахин хэлэлцүүлэхээр бэлтгээд байна. Багануурын уурхайг түшиглэн Багануур дүүрэгт үйлдвэрлэл технологийн парк байгуулахаар ХХААХҮЯ-наас санал боловсруулж, ЗГ-ын хуралдаанд оруулаад байна.

Хэрэгжилт –50%

59. Дэд бүлэг – 2.1

Зорилт – 2.1.10

Арга хэмжээ – 2.1.10.1 “Хувийн хэвшлийн хөгжлийн стратеги”-ийг батлуулан төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулна.

Биелэлт: Нийслэлд бизнес эрхлэх таатай орчин бий болгох, бизнес эрхлэгчдийн оруулах хувь нэмрийг дээшлүүлэх, төр захиргааны байгууллага, хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааг дээшлүүлэх, санхүүгийн зохистой механизмыг бий болгон үйлдвэрлэлийг хөгжүүлэх, алслагдсан дүүргүүдийг үйлдвэржүүлэх нэгдсэн бодлогыг тодорхойлох зорилгоор Нийслэлийн Засаг даргын тамгын газар,

Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Нийслэлийн бизнесийн холбоо нийт 11 чиглэлээр 2009-2012 онд хамтран ажиллахаар тохиролцож “Санамж бичиг” үйлдлээ.

Нийслэлийн Засаг дарга болон Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын даргын хооронд байгуулсан “Санамж бичиг”-т тусгагдсан “Төр хувийн хэвшлийн түншлэл”-ийг сайжруулах ажлын хүрээнд Нийслэлийн төр захиргааны болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах үүрэг бүхий “Зөвлөлдөх хороо”-ны бүрэлдэхүүнийг баталсан. Чиг үүрэг болон өмчийн харилцааны холбогдох журмын дагуу уг ажлын хэсэг өргөжин Засаг даргын 1 дүгээр орлогч Б.Баатарзоригоор ахлуулан Төр хувийн түншлэлд баримтлах үзэл баримтлал болон бүтцийн талаар сургалт, санал асуулга хийгдэж бүх хэлтэс, харьяа газруудаас хийгдэж болох ажлуудын жагсаалт гарган хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулагдсан. Төр ба хувийн хэвшлийн талаар нийслэлээс баримтлах бодлогын баримт бичигт өгөх санал болон бизнесийн таатай орчин бүрдүүлэх талаар саналыг Нийслэлийн /www.ulaanbaatar.mn/ вэб сайтаар тус тус авсан.

БНХАУ-ын Тяньжин хотод “Улаанбаатарын төлөөлөгчийн газар” УУГазар байгуулагдсан. Тяньжин хотын Дуньзян эдийн засгийн чөлөөт бүсэд болсон бизнес форум уулзалтанд худалдааны чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах сонирхолтой монголын 30 аж ахуйн нэгжийг МҮХАУТанхимтай хамтран оролцуулсан. Дуньзяны чөлөөт худалдааны бүсэд тээвэр ложистик, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, мах, махан бүтээгдэхүүнийг хадгалах, дамжуулан борлуулах зэрэг үйл ажиллагаа явуулахад зориулан 100 га-с доошгүй газрыг 50 жилийн хугацаагаар эзэмшиж, ашиглах, Няньзянийн боомтод түүхий нефть, кокс, нүүрс хадгалах, угаах, борлуулах үйл ажиллагааг явуулахад зориулан 160 га орчим талбай түрээслэн ашиглах зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх талаар хэлэлцээр хийгдэж байна. Тус хотод болсон “Дэлхийн оргинал бүтээгдэхүүн-2010” үзэсгэлэнд 9 аж ахуйн нэгжийг оролцуулсан.

“Бизнесийн орчинг сайжруулах жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх тухай тусгагдсаны дагуу нийслэлийн төрийн байгууллагууд, холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран судалсаны үндсэн дээр 3 үндсэн чиглэлээр нийт 30 арга хэмжээ бүхий саналыг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Монгол улсын Засгийн газраас 2010 оныг “Бизнесийн орчныг шинэчлэх жил” болгох тухай 2009 оны 377 дугаар тогтоолын дагуу нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хүрээнд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, зохион байгуулах, хяналт тавьж ажиллах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулсан. Ажлын хэсэгт нийслэлийн холбогдох удирдах ажилтнууд, төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл орсон. 2010 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 12 чиглэлийн нийт 60 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө боловсруулан батлуулсан.

Нийслэлийн хэмжээнд хийгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд шаардлага хангасан хувийн хэвшлийн компаниудыг түлхүү оролцуулж байна. Төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар гэр хорооллын айл өрхүүдэд ундны цэвэр ус түгээх зориулалтаар ашиглаж байсан 29 ус түгээх байрыг гэр хороололд ахуйн үйлчилгээ хөгжүүлэх замаар ажлын байр бий болгох, өрхийн бодит мөнгөн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Монголын хувийн хөдөлмөр эрхлэгчдийн холбоонд өмч эзэмшлийн гэрээгээр шилжүүлсэн. Тус байгууллага нь эдгээр 29 байрнаас 9 байрыг үндсэн зориулалтаар нь ашиглаж үлдсэн байруудад жижиг дунд бизнес эрхэлж, оёдол, ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Шинээр 87 хүн ажлын байртай боллоо.

“Бизнесийн орчныг шинэчлэх жил” -ийн төлөвлөгөөний хэрэгжилт, явц, үр дүнгийн тайланг улирал бүр, Бизнесийн орчны шинэтгэлийн жилийн хүрээнд Улаанбаатар хотод хийж хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд хүргүүлж хүргүүлсэн.

Хэрэгжилт –90%

60. Дэд бүлэг – 2.1
Зорилт – 2.1.27

Арга хэмжээ – 2.1.27.3 Шударга өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

Биелэлт : “Тээврийн хэрэгслийн өнгө үзэмж, дэг журам” үзлэг шалгалтийг 27 аж ахуйн нэгж, 57 чиглэлд 538 тээврийн хэрэгслийг хамруулан, Орон сууцны барилгын чанарт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн шинээр ашиглалтанд оруулсан барилгын стандартын зохих шаардлага хангаж буй эсэх, захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний үүргийн биелэлт, гэрээний тэгш байдал, сууцны талбайн хэмжээг бодит тооцсон эсэхийг тогтоох зорилгоор үзлэг шалгалт, Гоо сайхны үйлдвэр, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд,

гоо сайхны үйлчилгээ эрхэлж буй газруудад хяналт шалгалт хийсэн. хүнсний бүтээгдэхүүний хаяг шошго, хадгалалт тээвэрлэлт түгээлтийн горимын мөрдөлтийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт, “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад гарч буй зөрчил дутагдлыг арилгах зорилгоор нийслэлийн 97 сургуулийн гуанз цайны газарт үзлэг шалгалт, Монгол улсын засгийн газраас баталсан “Хүнсний баталгаат байдлыг хангах тухай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хэрэглэгч–Хаан” нэрэмжит үзлэгийг “Хэрэглэгчийн эрхийн хамгаалах тухай”, “Хүнсний тухай” хууль, Хоол үйлдвэрлэлтийн стандарт, ариун цэврийн шаардлагын дагуу 700 гаруй гуанз, цайны газар, кафед үзлэг шалгалтыг тус тус хийж ажилласан. Хэрэгжилт –70%

61. Дэд бүлэг – 2.1

Зорилт – 2.1.27

Арга хэмжээ – 2.1.27.4 Зах зээлийн өрсөлдөөний тухай ойлголт, соёлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, үндэсний болон олон улсын хэмжээний хурал, семинар зохион байгуулна.

Биелэлт: Үндэсний үйлдвэрлэгч, импортлогчдыг дэмжих, аж ахуйн нэгж байгууллагуудын брэнд бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэх зорилгоор “Цагаан сар-2010” сэдвээр үзэсгэлэн зохион байгуулж, хэрэглэгчдэд чанартай бараа бүтээгдэхүүнээр хангаж хэрэглэгчдэд үйлчилгээг ойртуулах ажил хийгдсэн.

Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 700 гаруй гуанз, цайны газар, кафед хийсэн “Хэрэглэгч–Хаан” нэрэмжит үзлэг, шалгалтын зорилго хоолны үйлдвэрлэлийн технологи ажиллагааг хэрэглэгчдэд нээлттэй үзүүлэх, хэрэглээний боловсрол олгоход чиглэгдсэн. Засгийн газрын зарим агентлагийн дэргэдэх 10 гаруй зөвлөлд сонгогдон ажиллаж хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлаар байр сууриа илэрхийлж ажилласан. Хэрэгжилт –50%

62. Дэд бүлэг – 2.1

Зорилт – 2.1.28

Арга хэмжээ – 2.1.28.4 Бүсийн болон аймгийн төвд сорилт, хэмжил зүйн үйлчилгээг нэг цэгийн зарчимд шилжүүлнэ. Хэрэглээний зүйлс, барилга, хүрээлэн буй орчны чанар, аюулгүй байдлын сорилт, шинжилгээг орчин үеийн шаардлагын хэмжээнд хийдэг сорилтын лабораторийн үндэсний тогтолцоог бий болгоно.

Биелэлт: МХЕГазартай 2010 онд хамтарч ажиллах нарийвчилсан төлөвлөгөөг гаргасны дагуу Хэмжил чиглэлийн хяналтын объектын заагийг тогтоож, “Хэрэглээний халуун хүйтэн усны тоолуурт тавигдах ерөнхий шаардлага” стандартын төслийг боловсрууллаа. Шинээр ашиглалтанд орж байгаа барилга байгууламжуудын цахилгаан, дулаан, цэвэр ус, ахуйн хэрэглээний халуун хүйтэн усны тоолуурын хэмжлийн нэгдмэл байдал болон архи спиртийн тоолуур, шингэрүүлсэн шатдаг хий болон нефтийн бүтээгдэхүүний хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдалд хяналт шалгалт хийх зэрэг ажлыг хийгээд байна.

Хэрэгжилт –90%

2.2. Үйлдвэржүүлэх бодлого

63. Дэд бүлэг – 2.2

Зорилт – 2.2.5

Арга хэмжээ – 2.2.5.1 Боловсруулах үйлдвэрийн үндсэн салбаруудыг харилцан уялдаа бүхий хоршилт, төрөлжсөн хэлбэрээр хөгжүүлж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах цогцолборууд байгуулна.

Биелэлт: Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Харгиа ХХК-ний урьдчилан цэвэрлэх байгууламжийг Нийслэлийн өмчид үнэгүй шилжүүлэх асуудлыг Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, НИТХ-ын тогтоолоор “Урьдчилан цэвэрлэх байгууламж” НӨҮГазар байгуулахаар шийдвэрлэж үйл ажиллагаагаа явуулж байна. Чех улсын буцалтгүй тусламжаар нийлүүлсэн цэвэрлэх байгууламжийг “Харгиа” ХХК-д шилжүүлэх талаар ажиллаж байна. Арьс шир, ноос ноолуур боловсруулах анхан шатны үйлдвэрүүдийг хотоос гаргах ажилтай холбогдуулан Эмээлт орчимд шинэ суурьшлын бүсийн газрыг сонгож, Мэргэжлийн комиссын хурлаар оруулах бэлтгэл ажил хийгдэж байгаа бөгөөд цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ боловсруулах тендерийн хөрөнгийн асуудлыг ХХААХҮЯам шийдвэрлэсэн. Уг тендерт ялсан төслийн баг ажиллаж байна.

Урьдчилан цэвэрлэх байгууламж НӨҮГ-ын технологийн шинэчлэлтийн эхний шатанд шаардлагатай байгаа хөрөнгийн асуудлыг НИТХ-ийн 2010 оны тогтоолоор 1740.0 сая төгрөгийг холбогдох хууль журамд нийцүүлэн өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгөөр хэрэгжүүлж, хөрөнгийн эх үүсвэрийг улс нийслэлийн төсөвт тусгах буюу холбогдох зээл тусламжинд хамруулахаар шийдвэрлэсэн. Нийслэлийн Засаг даргын захирамжаар дээрхи ажлыг хийж хэрэгжүүлэх үнэлгээний хороо байгуулагдан “Сант хаан” компани шалгарч ажил графикийн дагуу хийгдэж байна.

Хэрэгжилт –50%

64. Дэд бүлэг – 2.2

Зорилт – 2.2.5

Арга хэмжээ – 2.2.5.3 Салбарын эрдэм шинжилгээний байгууллагын чадавхийг дээшлүүлэн, шинжлэх ухаан үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.

Биелэлт: ШУ-ны академи, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хооронд байгуулагдсан гэрээний дагуу ШУА-ын дэргэдэх Инкубатор төвийн захиралтай эдийн засгийн өгөөж бүхий судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын ивээл дор "Бизнес инкубаторын олон улсын анхдугаар чуулга уулзалт"-ыг зохион байгуулсан. Нийслэлийн Жижиг бичил бизнесийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, үйлдвэрлэлийг өргөтгөх, мэргэжлийн байгууллага холбоод болон хувийн хэвшлийнхнээс гарсан санал санаачлагыг төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах зорилгоор Нийслэлийн Засаг дарга, Хас банкны гүйцэтгэх захирал, МБИНХолбооны ерөнхийлөгч нар хамтран ажиллах санамж бичиг үйлдлээ. Хас банкинд зээл, санхүүгийн механизмыг хэрэгжүүлэх зорилгоор 1.5 тэрбум төгрөг байршууллаа.

Хэрэгжилт –70%

Дэд бүлэг – 2.2

Зорилт – 2.2.5

Арга хэмжээ – 2.2.5.4 Боловсруулах үйлдвэрүүдийн мэргэжилтэй ажилчин, инженер техникийн ажилтан бэлтгэх тусгай хөтөлбөр баталж хэрэгжүүлнэ.

Биелэлт: Хөтөлбөр батлагдаагүй байна.

65. Дэд бүлэг – 2.2

Зорилт – 2.2.6

Арга хэмжээ – 2.2.6.1 Уул уурхайн үйлдвэрийг түшиглэн барилгын материалын үйлдвэр орон нутагт байгуулахыг дэмжинэ.

Биелэлт: Барилгын материалын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжийг бүрдүүлэх, тэдний үйл ажиллагааг дэмжих зорилгоор нийт 30 гаруй аж ахуйн нэгжийн нэг тэрбум гаруй төгрөгийн зээл хүссэн материалыг шалгаруулан арилжааны банкуудад уламжилсаны дагуу 8 аж ахуйн нэгжид 445,0 сая төгрөгийн зээл олгогдсон.

Хэрэгжилт –50%

66. Дэд бүлэг – 2.2

Зорилт – 2.2.7

Арга хэмжээ – 2.2.7.2 Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул,Завхан аймгуудад үйлдвэрлэл, технологийн парк байгуулахад шаардлагатай дэд бүтцийг байгуулна.

Биелэлт: Үйлдвэрлэл технологийн парк байгуулах, түүний газрын хэмжээг тогтоох асуудлаар НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны тогтоол гарсан. Алслагдсан дүүргүүдэд байгуулагдах үйлдвэрлэл технологийн паркийн зураг төсөлд дэд бүтцийн төлөвлөлтийн шийдлүүдийг тусгаж, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлсоны дагуу барьж байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх асуудлыг зохион байгуулах болно.

Багануур дүүрэгт Үйлдвэрлэл технологийн парк байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Багануурт Бионанотехнологийн, Багахангай, Налайх, Хан-Уул дүүргүүдэд "Үйлдвэрлэл, технологийн парк" -ийн үүрэг, аж ахуйн нэгжийн төлөөлөл ажлын хэсэгт ажиллан Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад санал өгөн оролцлоо. Паркийн ТЭЗҮ-г ХХААХҮЯ-наас Нийслэлд хүлээлгэн өглөө. ХХААХҮ-ийн сайдын 2010 оны А/81 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэг "Үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай" журмын төслийг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдаас гаргасан саналыг тусган дахин хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.

Нийслэлд байгуулагдах Үйлдвэрлэл технологийн паркыг Багануурын уурхайг дагалдуулан хөгжүүлэх тухай МУ-ын ЗГазарт асуудал оруулаад байна.

Биелэлт – 50%

67. Дэд бүлэг – 2.2

Зорилт – 2.2.20

Арга хэмжээ – 2.2.20.1 Улаанбаатар хотын гэр хорооллын хэрэглэгчдийг цэвэр түлшээр хангах эрх зүйн орчин бүрдүүлнэ.

Биелэлт: 2010-2011 оны өвлийн улиралд гэр хорооллын айл өрхөд үртсэн шахмал түлшний 6 аж ахуй нэгжийн нийт 16200 тн түлш нийлүүлэгдэх бөгөөд нийт 5034 тн үртсэн шахмал түлш борлуулагдаад байна. Түлш нөөцлөх агуулах түрээслэх, борлуулалтын нэгдсэн сүлжээ байгуулах ажлыг зохион

байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор “Бөөний худалдаа” ХХК-тай гэрээ байгуулж үртсэн шахмал түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн түлшийг нөөцөлж, борлуулалтын цэгүүдэд хүргэх ажлыг зохион байгуулж байна. Одоогийн байдлаар 1087 тн түлш нөөцлөөд байна.

Булган аймгийн Хялганат тосгонд Нийслэлийн 2009 оны хөрөнгө оруулалтаар баригдсан үртсэн шахмал түлшний иж бүрэн цогцолбор үйлдвэрийг ашиглалтанд хүлээн авсан ба улмаар НӨҮГ болгохоор асуудал боловсруулаад байна. Энэхүү үйлдвэр нь одоогийн байдлаар нийт 350 тн түлш үйлдвэрлэж, хуваарьтай 4 хорооны хэрэглэгчдэд түлшээ нийлүүлж байна.

Хэрэгжилт –50%

68. Дэд бүлэг – 2.2

Зорилт – 2.2.20

Арга хэмжээ – 2.2.20.2 Цэвэр түлш үйлдвэрлэх, ашиглахтай холбоотой стандарт, норм, дүрэм, журмыг боловсруулна.

Биелэлт: Нийслэлийн Засаг даргын захирамжаар агаарын бохирдлыг бууруулах 2-р бүсэд орших Баянгол дүүргийн 9,10,11,16 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 7,8,9,10,11 дүгээр хороо, Сүхбаатар дүүргийн 9,11,12 дугаар хороодын нийт 26000 өрхөд түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлаж, боловсруулсан түлшээр хангахаар заагдсан. Уг ажлын дагуу түүхий нүүрс түлэх, хог хаягдлыг ил задгай шатаах явдлыг таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор 3 дүүргийн 12 хороодод түлш нийлүүлэлт, түүхий нүүрсний хэрэглээний тал дээр хяналт тавих ажлыг 7 хоног бүр хийж ирлээ.

“Агаарын чанарыг сайжруулах” бүсийг тогтоох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор эхний ээлжинд хотын төвд ойрхон байршилтай гэр хороолол буюу Баянгол дүүргийн 16-р хороог Нийслэлээс “Агаарын чанарыг сайжруулах” бүс болгох зорилт тавьж байна. Ингэснээрээ үр дүнг иргэд болон олон нийт мэдрэх харах боломжтой болох тул энэхүү саналыг БОАЖЯ-тай хамтран боловсруулж байгаа “Агаарын чанарыг сайжруулах” бүсэд мөрдөх журамд тусгах санал оруулаад байна. ЭБЭХЯ-д “Цэвэр түлшийг ахуйн хэрэглээнд нэвтрүүлэх” хөтөлбөрийн төслийн санал өгсөн.

Хэрэгжилт –50%

69. Дэд бүлэг – 2.2

Зорилт – 2.2.20

Арга хэмжээ – 2.2.20.3 Цэвэр түлшний түгээлт, борлуулалт, хяналт, мэдээллийн тогтолцоог бий болгоно.

Биелэлт: Нийслэлийн Засаг даргын захирамжаар агаарын бохирдлыг бууруулах 2-р бүсэд орших 3 дүүргүүдийн 12 хороонд нийлүүлэгдэх боловсруулсан түлшний төрөл, гэрээгээр нийлүүлэх түлшний хэмжээг харгалзан Баянгол дүүрэгт 29, Сүхбаатар дүүрэгт 29, Чингэлтэй дүүрэгт 19 борлуулалтын цэгүүдийг айл өрхийн нягтаршил, байршлаас нь хамааруулан ажиллуулж байгаа бөгөөд дүүрэг, хороодын саналыг тусган 1:4000 масштабын зурагт оруулж, дээрхи борлуулалтын цэгүүдэд байнгын хяналт тавин ажиллаж байна.

Түлш борлуулах цэгт үртсэн шахмал түлш нь хэрэглэгчдэд гэрээний дагуу 1 тн 120,0 мянган төгрөгөөр нүүрсэн шахмал түлшийг 1 тонныг 70,0 мянган төгрөгөөр борлуулагдаж байна. Үнэ хөөрөгдөх асуудалд түлш үйлдвэрлэгчид, дүүрэг хороодтой хамтран онцгойлон анхааран ажиллаж байна. Боловсруулсан түлшний нөөцийн хэмжээ, хороодуудад нийлүүлэх төлөвлөгөөний биелэлт, стандартын хэрэгжилтэнд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах, судалгаа шинжилгээтэй хяналт шалгалт хийн, үнэлгээ дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах зорилгоор шалгалт хийсэн. Уг шалгалтанд үртсэн шахмал түлш үйлдвэрлэгч 6 компани, коксон түлш үйлдвэрлэгч 2 компани, нүүрсэн шахмал түлш үйлдвэрлэгч 4 компани хамрагдсан.

Хэрэгжилт –50%

70. Дэд бүлэг – 2.2

Зорилт – 2.2.25

Арга хэмжээ – 2.2.25.1 Өндөр технологи бүхий жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Биелэлт: Өндөр технологи бүхий жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр “Нийслэлийн инновацийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, 2011 оны 1-р сард НИТХ-ын тогтоолоор хөтөлбөрийг батлуулаад байна. Энэхүү бодлогод дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, шинэ технологид суурилсан үйлчилгээ, оюуны багтаамжтай, бага оврын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар нэн тэргүүнд мэдээллийн технологийг хөгжүүлэх, бизнесийн болон мэдээллийн технологийн аутсорсинг хөгжүүлэх чиглэл тусгагдсан. Үүний хүрээнд Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар, Мэдээллийн технологийн үндэсний паркт хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулан гарын үсэг зурах үйл ажиллагаа хүлээгдэж байна. Уг санамж бичиг баталгаажсанаар Улаанбаатар хотод

экспортын баримжаатай, хувийн хэвшилд түшиглэсэн мэдээлэл, харилцааны өндөр технологит суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, тогтвортой, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох нөхцөл бүрдэнэ.

Нийслэлийн харьяалалттай Сэлэнгэ аймгийн Бороогийн хөндийд байрлах "Шижир интернэшнл" ХХК-ийн био технологийн үйлдвэр, Багануур дүүргийн нутаг дэвсгэрт байрлах "Мон химо" ХХК-ийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаж, тус үйлдвэрүүдэд шаардлагатай байгаа санхүүгийн эх үүсвэрийн хүсэлтийг ХХААХҮЯ-д уламжилж тус бүрт 300.0 сая төгрөгний хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлээ.

Шинэ техник технологи нэвтрүүлэн ажиллаж байгаа 10 гаруй аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжин 20.0-100.0 сая хүртэлх төгрөгийн зээлийн төслийг арилжааны банкуудад уламжлан зээл олгогдсон. ХХААХҮЯам, ЖДҮГ, ЖДҮДСан, Нийслэл, дүүргүүдийн хамтарсан шалгалтаар үйл ажиллагаа нь амжилттай явагдлаа гэж дүгнэлээ.

Хэрэгжилт –50%

71. Дэд бүлэг – 2.2

Зорилт – 2.2.28

Арга хэмжээ – 2.2.28.1 "Сүү" хөтөлбөрийг хэрэгжүүлж, махны нөөцийн сан байгуулна.

Биелэлт: "Сүү" төслийн хүрээнд 4 ширхэг хөргөлтийн танкийг Налайх дүүргийн "Налайх сүү" ХХК, Баянзүрх дүүргийн Гачуурт тосгоны "Вайтпээрл" хоршоо, Хан-Уул дүүргийн "Монфреш" ХХК-д эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгоод байна. Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу саалийн үнээний ферм байгуулах 10 иргэн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан газрын гэрчилгээг олгож, газрын төлбөрөө бүрэн төлж аж ахуйн үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг хангаж байна.

Нийслэлийн хүн амын хавар, зуны хэрэгцээнд мах бэлтгэж нөөцлөх зардал, мах бэлтгэж борлуулсан байгууллагуудад олгох урамшуулалд шаардагдах хөрөнгийн тооцоо, бэлтгэх махны хэмжээний талаар санал боловсруулан НИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн, НИТХ-ын тогтоолоор 2010 онд 2800 тн мах бэлтгэх ба түүнд 1,4 тэрбум төгрөгийг зарцуулах шийдвэр гаргуулж, мах бэлтгэх гэрээг 10 аж ахуйн нэгжтэй байгуулан 4, 5-р сард борлуулж дуусгасан.

Засгийн газрын 2010 оны 138 дугаар тогтоолоор жил бүр нийслэлийн хүн амын хэрэгцээнд 12.000 тонноос багагүй хэмжээний мах нөөцлөх ажлыг зохион байгуулах, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг даргад даалгасан шийдвэр гарсаны дагуу 14 аж ахуйн нэгжийг шалгаруулан, мах бэлтгэлийн ажлын явц 92,5 хувьтай байна. Нөөцийн махыг хүн амын эрэлт хэрэгцээ, зах зээлийн байдалтай уялдуулан 2011 оны 1-р сараас худалдаанд гаргахаар бэлтгэж хороо бүрд 2 –оос доошгүй дэлгүүр байхаар төлөвлөж хуваарь хийгээд байна.

Хэрэгжилт –50%

72. Дэд бүлэг – 2.2

Зорилт – 2.2.30

Арга хэмжээ – 2.2.30.1 "Чацаргана" дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Биелэлт: "Чацарганы суулгац зээлээр олгох" төсөлд Нийслэлээс 44 иргэн, 16 аж ахуй нэгжид нийт 45000 ширхэг суулгац эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр гэрээ хийн олгож 2 удаагийн сургалт зохион байгуулж 170 иргэдийн хамрууллаа.

Хэрэгжилт –50%

2.3. Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын бодлого

73. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.1

Арга хэмжээ – 2.3.1.2 Сүүний хангамжийг нэмэгдүүлэн, сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулан, удаан хугацаагаар хадгалагдах сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.

Биелэлт: "Сүү" төслөөс гэрээний дагуу нийлүүлэх сүүний шинжилгээний 4 багажийг хүлээн авч "Саруул", "Бэлх" хүнсний захуудад худалдсан ба үлдсэн багажийг худалдах гэрээг 2 аж ахуйн нэгжтэй хийгээд байна. Мөн "Сүү" төслийн хүрээнд ариутгасан сүү борлуулах 1 загвар цэгийн төхөөрөмжийг энэ оны 2-р сард Энэтхэг улсаас авч ирсэн ба хэрэгжүүлэгчийг сонгох сонгон шалгаруулах шалгаруулалтанд "ГУМ" ХХК сонгогдон үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Хэрэгжилт –50%

74. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.1

Арга хэмжээ – 2.3.1.3 Малчид, фермерүүдийн сүүг сүү үйлдвэрлэгчид нэгдсэн байдлаар цуглуулах, хөргөх, боловсруулах сүү бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэн ажлын байр нэмэгдүүлж, хүн амын амьжиргаа, хүнсний аюулгүй байдлыг хангана.

Биелэлт: “Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд фермерийн аж ахуйгаас бэлтгэж, төвлөрсөн хэрэгцээнд нийлүүлсэн сүүнд урамшуулал олгох шийдвэр гарсан бөгөөд 2011 оны төсөвт шаардагдах хөрөнгийн асуудлыг тусгуулахаар ажиллаж байна.

ХХААХҮЯам, Европын холбооны “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл” төсөлтэй хамтран 2010 оны 11-р сарын 25-нд зохион байгуулагдсан “Хүнсний үйлдвэрүүдийн түүхий эд материалын бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулах арга зам” сэдэвт хэлэлцүүлэгт нийслэл орчмын фермерүүдийг хамруулан Нийслэлийн хүн амын хэрэгцээнд нийлүүлэгдэж буй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалтын талаар мэдээлэл хийлээ.

“Хүнсний үйлдвэрийн техник, технологи, эрүүл ахуйн нөхцөл, дотоодын хяналтын тогтолцоонд хийх шалгалт”-ын удирдамжийн дагуу сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч 41 аж ахуйн нэгж, иргэн, сүү цагаан идээ худалдан борлуулдаг 5 худалдааны төв, 11 хүнсний дэлгүүр, 12 хүнсний мухлаг, ил задгай худалдаа эрхэлдэг 82 иргэн, сүү нийлүүлэгч сүүний үхрийн 8 аж ахуйд хяналт шалгалт хийсэн. Шалгалтын явцад хүнсний үйлдвэр, худалдаа стандарт, эрүүл ахуйн шаардлагын дагуу эрхлээгүй, бүтээгдэхүүнийг стандартын шаардлагын дагуу шошголоогүй, үйлдвэрлэлд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан тухай мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтгүй түүхий эд хэрэглэж байсан зэрэг зөрчил гаргасан сүү, цагаан идээ худалдаалах 2 цэгийн үйл ажиллагааг бүрмөсөн зогсоож, 14 аж ахуйн нэгжид 69 заалт бүхий албан шаардлага өгч, 12 аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнд 1235.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж барагдуулснаас гадна иргэдэд зориулсан мэдээлэл, сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 8 удаа хийлээ. Шалгалтын дүнг Нийслэлийн МХГазрын дэд даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрүүдийг гаргуулан ажилласан.

Хэрэгжилт –50%

75. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.1

Арга хэмжээ – 2.3.1.5 “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2010 онд хөтөлбөрийн хүрээнд хийх ажилд шаардлагатай 15 сая төгрөгний санхүүжилтээс 3 сая төгрөгний санхүүжилтийг Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн. Хөтөлбөрийн хүрээнд 7 төрлийн хүнсний ногооны 392,7 кг үр, 44,3 тн үрийн төмс, 4 тн био бордоо, 5 боодол нийлэг хальсан хучлага, 45 ш хор шуршигчийг үнэ төлбөргүй, 17 ширхэг трактор техник, тоног төхөөрөмжийг 12 аж ахуйн нэгж, иргэнд 50% хөнгөлттэй үнээр, мөн 169 ширхэг хүлэмжийг 105 иргэн, аж ахуйн нэгжид 50 хувийн хөнгөлттэй үнээр хуваарилан олголоо.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны Ташир уулын өвөрт 300 га газрыг 13 аж ахуйн нэгж, 79 иргэнд, Баянзүрх дүүргийн 11-р хорооны Баян-Уул орчимд 100 га газрыг 3 аж ахуйн нэгж, 66 иргэнд төмс, хүнсний ногоо тариалах зориулалтаар эзэмшүүлэх гэрээ хийгээд байна.

2010 оны усалтын системийн тендерт шалгарсан 5 усалтын системийг техникийн комисст хүлээлгэн өгсөн. 1 га талбайн бороожуулагч 9 ширхэг, 0,5 га талбайн дуслын услагааны 10 системийг 16 иргэн, аж ахуйн нэгжид 50 хувийн хөнгөлттэй үнээр олгосон.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлттэй хүүтэй зээлийн төсөлд газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр 13 иргэн, аж ахуйн нэгжийн төсөл шалгарч 587,0 сая төгрөгний зээл, Органик Монгол төсөлд 28 өрхийн аж ахуй эрхлэгчид хамрагдаж 106,6 сая төгрөгний зээл авсан. Үр дүнд тариалалтын талбай урд оныхоос 175 га-гаар нэмэгдсэн.

Агропарк, төрийн бус байгууллага, холбоодоор дамжуулж 24 удаагийн сургалт зохион байгуулж, 836 иргэний хамруулан, ногоо тарих агротехнологийн мэдэгдэхүүнтэй болгосон. Сүхбаатар, Баянгол, Хан-Уул, Багануур, Багахангай дүүргүүдийн тариаланчдийн зөвлөгөөнийг зохион байгуулсан.

Нийслэлийн төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтын явц, агропаркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, өвчин хортонтой тэмцэх болон арчилгааны технологийн талаар зөвлөгөө, зөвлөмж өгөхөөс гадна тариалалтын мэдээний бодит байдлыг хангах, ургацын урьдчилсан баланс гаргах боломж бүрдүүлэх зорилготой 8-сарын 25-ны өдрөөс 9-р сарын 7-ны өдрүүдэд дүүргүүдийн хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн, статистикийн хэлтсийн мэргэжилтэнтэй хамтран тариалан эрхлэгчдийн үйл ажиллагаатай танилцаж газар дээр нь зөвлөгөө өгч ажиллаа. Нийслэлийн тариалалт, ургац хураалтын явцын талаар Ногоон суваг студитэй хамтран нэвтрүүлэг бэлтгэн 25-р суваг телевизээр цацлаа.

“Алтан намар 2010” шинэ ургацын үзэсгэлэн худалдааны зохион байгуулалтанд оролцож, нийслэлийн 14 иргэн, аж ахуйн нэгж борлуулалт хийлээ.

“Нийслэлийн намрын ногоон өдрүүд 2010” шинэ ургацын үзэсгэлэн худалдаанд хөдөө орон нутгийн тариалан эрхлэгчдийг урьж оролцуулан Баянзүрх, Хан-Уул, Баянгол, Чингэлтэй дүүргүүдэд борлуулалтын цэг гарган нийслэлийн иргэдийн шинэ ургацын төмс, хүнсний ногоогоор хангах ажлыг зохион байгууллаа.

Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан, Налайх дүүргүүдэд “Таримал ургамлын ургалтын үед анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг 10-р сард зохион байгууллаа.

Фермер эмэгтэйчүүдийн холбооноос 176 иргэнийг ногоочин цэцэрлэгчний мэргэжил олгох богино хугацааны сургалтанд хамруулж, мэргэжлийн гэрчилгээ олголоо.

Хэрэгжилт –50%

76. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.1

Арга хэмжээ – 2.3.1.6 Дотоодын хүнсний түүхий эдэд тулгуурласан нярай хүүхдийн хоол тэжээлийн болон түүнд чиглэсэн үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.

Биелэлт: Хүүхдийн хоол тэжээлийн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан БСШУЯаманд хүргүүлсэн. Хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүнээр хангах зорилгоор хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 70 гаруй аж ахуйн нэгжид 3,6 тэрбум төгрөгийн зээл олгосон. Нийслэлийн Засаг даргын захирамжаар саалийн үнээний фермерийн аж ахуй байгуулах зориулалтаар 16 иргэн, аж ахуй нэгж тус бүрт 2 га газар олгосноос 7 иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгууллаа.

Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн угж, түүнтэй адилтгах зүйлийн чанар, аюулгүй байдлыг хангах, тэдгээрт хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлж байна.

Хэрэгжилт –50%

77. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.5

Арга хэмжээ – 2.3.5.1 Тариалангийн талбайн бүртгэл тооллого явуулж, эзэмшилт ашиглалтыг сайжруулна.

Биелэлт: Хан-Уул дүүргийн 4, 14, 13-р хорооны тариалалтын явцтай танилцаж 12,69 га талбайд төмс, хүнсний ногоо, 0,692 га талбай бүхий 28 ширхэг хүлэмжинд тариалалт хийгдэж, 8 гүний худаг, 80 тоннын багтаамж бүхий 4 зоорь, бага оврын 3 трактор, 1411 чацаргана, 575 үхрийн нүд, 952 бусад жимс, жимсгэний мод бүртгэлд авлаа.

Баянгол, Багахангай дүүргүүдээс бусад 7 дүүргийн тариалалттай танилцаж нийт 113 өрх, аж ахуйн нэгжийн 902,9 га талбайг судалгаанд хамруулж 238 хүлэмж, 73 гүний худаг, нийт 1485 тоннын багтаамжтай 25 зоорь, бага оврын 12 трактор, МТ 80 маркийн 4 трактор, Юмз маркийн 2 трактор, 75 гинжит трактор, янмар, Жоондэр, үр тарианы комбайн, ДТ-25 маркийн трактор, 510 маркийн трактор тус бүр 1, төмсний 2 иж бүрдэлийг тооллоо.

Хэрэгжилт –50%

78. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.5

Арга хэмжээ – 2.3.5.2 Таримал ургамал, үр үржүүлгийн аж ахуй байгуулах, үрийн сорт, нэр төрлийг олшруулах, ганд тэсвэртэй болон усалгаатай нөхцөлд тариалах сортын үрийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Услалтын системийн тендерт 5 иргэн, аж ахуйн нэгжийн услалтын системийн төсөл шалгарч, гэрээ байгуулж ажиллаж, нийт 140 га услалтын систем шинээр барьж ашигласан.

“Баясах фүүдс” ХХК нь Польш улсаас боловсруулах үйлдвэрийн стандарт хангасан “парически корниска” богино сортын өргөст хэмхний үрийг оруулж ирэн томоохон өрх аж ахуйн нэгжүүдтэй гэрээ хийн тариалуулж ургацыг нь зах зээлийн ханшаар худалдан авч үйлдвэрлэлд оруулж байна.

Өрхийн тариаланчид уламжлал болсон цөөн хэдэн төрлийн ногоо тариалдаг байсан бол “Ногоон хувьсгал”, “Атарын 3 дахь аян” зэрэг хөтөлбөрийн хүрээнд сургалт, сурталчилгаа, дэмжлэг, төрийн бус болон олон улсын байгууллагын төсөл, туслалцааны үр дүнд салатны ногоо, хулуу, гоньд, хаш, чинжүү, цэцэгт байцаа, бууцай, жууцай, гүзээлзгэнэ, тоор гэх зэргийг тариалсанаар ногоо, жимс, жимсгэний нэр төрөл нэмэгдэхийн зэрэгцээ хэрэглээ, хангамж нэмэгдэж, сайжирсан.

Нийслэлийн хэмжээнд Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо, Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт хөх арвай, хошуу будаа, эрдэнэ шиш, царгас зэрэг тэжээлийн ургамлын тариалалт 2007 оноос 140 га-гаар нэмэгдсэн.

Хэрэгжилт –50%

79. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.5

Арга хэмжээ – 2.3.5.3 Улаан буудайн нөөц бүрдүүлэх хэрэгцээ хангамжийг сайжруулах зорилгоор борлуулалтын сүлжээ бий болгоно.

Биелэлт: Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ХХААХҮЯ-с хүнсний улаанбуудай, гурилын импортын гаалийн тарифыг нэмэгдүүлэх санал боловсруулан “Гаалийн тарифын зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэгдэн дэмжигдэж, Засгийн газрын хуралдаанд “Алтан тариа”ХК-аас ирүүлсэн саналыг үндэслэн дахин боловсруулахаар шийдвэр гаргасан. 2010 оны засгийн газрын хуралдааны 30-р тэмдэглэлийн 2 дахь заалтад заасны дагуу дотоодын үйлдвэрлэл, бүтээгдэхүүний зориулалт, улирлын нөөцтэй уялдуулан импортын гурил, улаанбуудайн гаалийн тарифыг өсгөх, тахиа, гахай, загасны махны гаалийн тарифыг тэглэх санал боловсруулан, ГЕГ-аас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээд байна.

Хэрэгжилт –50%

80. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.5

Арга хэмжээ – 2.3.5.4 “Атрын 3 дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2010 онд төмсний үр үржүүлэгчээр 9 иргэнийг сонгож 5,5 тн импала, каратоп, санта сортын төмсний үр, бордооны хамт олгон, гэрээний дагуу 11 тн сайн сортын үрийг үр үржүүлэгчдийн зооринд хадгалж байна. 2008-2010 онд нийт 11,5 тн нутагшсан сортыг үржүүлэхээр олгосон.

Өрхийн тариаланчид уламжлал болсон цөөн хэдэн төрлийн ногоо тариалдаг байсан бол “Ногоон хувьсгал”, “Атарын 3 дахь аян” зэрэг хөтөлбөрийн хүрээнд сургалт, сурталчилгаа, дэмжлэг, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төсөл, туслалцааны үр дүнд салатны ногоо, хулуу, гоньд, хаш, чинжүү, цэцэгт байцаа, бууцай, жууцай, гүзээлзгэнэ, тоор гэх зэргийг тариалсанаар ногоо, жимс, жимсгэний нэр төрөл нэмэгдэхийн зэрэгцээ хэрэглээ, хангамж нэмэгдэж, сайжирсан.

Хэрэгжилт –50%

81. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.6

Арга хэмжээ – 2.3.6.1.Нутгийн болон сайжирсан, цэвэр үүлдрийн малын удмын санг хамгаалах, өсгөх, мал үржүүлгийн болон биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Нийслэлд сүүний чиглэлийн үхэр өсгөн үржүүлж байгаа иргэдийн үнээний үүлдэрлэг байдал, ашиг шимийн судалгаа гаргах талаар дүүргүүдийн мал эмнэлэг үржлийн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна. Нийслэлийн 8 дүүрэгт үнээний зохиомол хээлтүүгийн 10 цэг ажиллаж 210 үнээ зохиомол хээлтүүлэгт хамрагдсан. Нийслэлийн Засаг даргын Захирамжаар томилогдсон ажлын хэсэг сүүний чиглэлийн үхэрт хувьсалийн ангилалт хийж анги чанарыг тогтоож, бүртгэл судалгаанд авлаа.

“Мал үржлийн ажлыг шинэчлэн сайжруулах” төслийн хаалтын семинарт Нийслэлээс 90 гаруй фермерүүд, 12 мэргэжилтэн оролцож хийсэн ажлаа дүгнэж цаашид хийх ажлын чиглэлээ тогтоосон. Төсөл хэрэгжснээр Нийслэлийн 120 иргэний 2534 үнээний үүлдэрлэг байдлын судалгаа мэдээллийн санд орсон байна. Ангилалтанд 438 үхэр хамрагдлаа.

Хэрэгжилт –50%

82. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.6

Арга хэмжээ – 2.3.6.3 Цөм сүргийн малыг үржлийн бүртгэлд бүрэн хамруулж, улсын хэмжээнд үржүүлж байгаа арвин ашиг шимт цөм сүргийн малын удам гарвал, ашиг шимийн мэдээллийн санг бий болгоно.

Биелэлт: Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны 3 аж ахуйн нэгжийн 150 үнээнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ангилалт хийсэн үнээний анги чанар, ашиг шимийн түвшинд хийсэн үзлэгийг хянан шалгаж, цөм сүрэг болгон батласнаар 150 үнээ бүхий 3 аж ахуйн нэгжид цөм сүрэг бүрдүүлээ.

Мөн нийслэлийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2 дүүргийн 2 иргэний үхэр сүрэгт ангилалт хийсэн үнээний анги чанар, ашиг шимийн түвшин тогтоож цөм сүргийн шаардлага хангаж байна гэж үзэж, бусад аж ахуйн нэгж, иргэдийн хэрэгцээнд стандартын шаардлага хангасан хээлтэгч, хээлтүүлэгчийг 2011 оноос нийлүүлэхээр бэлтгэж байна.

Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдээр дамжуулан үржлийн үйлчилгээний хүртээмжийг хүргэх бодлого барьж ажиллаж байна. Нийслэлийн төвийн 5 дүүргийн мал эмнэлэг үржлийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж мэргэжлийн зөвлөлгөө өгч ажилласан. Иргэдэд үнээний зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ үзүүлж байгаа хээлтүүлгийн техникчдийн ажлыг шалгаж хээлтүүлэгт хамрагдсан үнээнд нь хээлийн шалгалт хийлээ.

Хэрэгжилт –50%

83. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.8

Арга хэмжээ – 2.3.8.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бирж байгуулан ажиллуулна.

Биелэлт: ХХААХҮ-ийн сайд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд 2009-2012 онд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Эмээлт орчимд махны болон малын төрөлжсөн бирж байгууллахаар 5 га газрыг олгохоор шийдвэрлэсний дагуу сонгон шалгаруулалтаар “Эрдэнэт прогресс” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулан бэлтгэл ажлыг хангаж байна. Бирж байгуулах техник эдийн засгийн үндэслэлийг яамны төсвөөр боловсруулсан.

“Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бирж”-ийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан УИХ-аар хэлэлцүүлэн батлууллаа.

Хэрэгжилт –50%

84. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.10

Арга хэмжээ – 2.3.10.1. “Малын тэжээл” хөтөлбөрийг хэрэгжүүлэн тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Сонгинохайрхан дүүргийн 1 аж ахуйн нэгжид 150кг царгасны үр, 500 тн хошуу будааны үрийг гэрээгээр олгож малын тэжээл тариалахад нь дэмжлэг үзүүлсэн. Дүүргүүдийн нөөцөнд 2000 тн тэжээлийн арвай, 271,3 тн өвс бэлтгэсэн.

Хэрэгжилт –50%

85. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.10

Арга хэмжээ – 2.3.10.2 Хадлан болон тэжээл үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, тэжээлийн хангамж, чанарыг сайжруулах, хадгалалт тээвэрлэлтийн зардлыг бууруулах арга хэмжээ авна.

Биелэлт: ХХААХҮЯ-аас 6800 тн арвай будааг Нийслэлд хувиарласныг фермер, малчдад хүргүүлэх, дүүргийн нөөцөнд авах ажлыг зохион байгуулан ажилласан.

Нийслэлийн мал сүрэгт 2010 - 2011 оны өвөл хаврын улиралд шаардагдах 108,5 мянган тн өвс, 18,3 мянган тн хучит тэжээл, 905 тн давс хужир, үүнээс аюулгүйн нөөцөнд 1363 тн өвс бэлтгэх тооцоог гаргаж Улаанбаатар хотын ерөнхий менежерээр батлуулан дүүргүүдэд хүргүүлсэнээр хадлан 73,9 мянган тн, ногоон тэжээл 1,5 мянган тн, хүчит тэжээл 128 мянган тн, гар тэжээл 0,3 мянган тонныг бэлтгэсэн.

Хэрэгжилт –50%

86. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.12

Арга хэмжээ – 2.3.12.6 “Мал, эмнэлэг үржлийн анхан шатны үйлчилгээний нэгжийг дэмжих хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлж, сум дүүргийн мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжүүдийг бэхжүүлнэ.

Биелэлт: Лабораторийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор Европын холбооны “Малын эрүүл мэнд мал аж ахуйн зээл” хөтөлбөрөөс махны анализатор, махны хатуу хошуутай PH метр, хэмжих хэрэгсэл, шувууны томуугийн түргэн тест зэрэг тоног төхөөрөмж болон 12 төрлийн 2000 гаруй дагалдах хэрэгсэл, Нийслэл болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 5 шинжилгээний агар авч шинжилгээний тэжээлт орчины нөөцийг нэмэгдүүлсэн. Дүүргийн 20 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн дэргэдэх лаборатори, хүнсний зах, худалдааны төв, аж ахуйн нэгжийн дэргэдэх /давхардсан тоогоор/ 37 лабораториудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ олгосон.

Нийслэлийн Малын эрүүл мэнд нийслэлийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд 5,0 сая төгрөг батлагдаж, малын эмийн сангийн өрөө, нохой, жижиг амьтны өрөө, коридорт камерийн систем суурилуулсан, мал амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн болох сүүний 10 төрлийн үзүүлэлт тодорхойлох сүүний анализаторыг Монголын хувийн мал эмнэлгийн холбооноос авч ашиглаж байгаа зэрэг ажлууд хийгдсэн.

Нийслэлийн мал эмнэлгийн газрын лабораторийн шинжилгээний чадавхийг дээшлүүлэх зорилгоор Европын холбооны “Малын эрүүл мэнд мал аж ахуйн зах зээл” төслөөс нийт 89,0 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж олгосон. Шувууны томуу, хүний томуугийн цар тахалтай тэмцэх төслөөс халдварт өвчний оношлогооны 6,2 сая төгрөгийн ЕЛИЗА аппаратыг хүлээн авлаа. Төсөл хөтөлбөрөөс 95,2 сая төгрөгийн багаж төхөрөөмж хүлээн авч, лабораторийн чадавхийг дээшлүүллээ.

Хүнсний зах, худалдааны төвийн дэргэдэх мал эмнэлэг, ариун цэврийн лабораториудыг мэргэжил, арга зүй, шинжилгээний багаж хэрэгслээр хангах төлөвлөгөөг гарган нийт 23 багажыг хувиарлан, хүргүүлсэн.

Бруцеллёзын шинжилгээг 44060 толгой малд, адууны халдварт цус багасах өвчний тандалт шинжилгээг 979 адуунд, мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний тандалт шинжилгээг 930 толгой малд, сүүний цагирган урвалын шинжилгээг 5000 малд, ямын шинжилгээг 2000 адуунд, сүрьеэгийн шинжилгээг 3000 бодод, боомын шинжилгээг тус тус хийсэн. Нийслэл хот мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөр тайван болохыг баталгаажуулаа. Мөн мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, нян судлалын шинжилгээг тус тус хийж ажилласан.

Хэрэгжилт –50%

87. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.14

Арга хэмжээ – 2.3.14.1 “Хоршоог дэмжих хөтөлбөр” хэрэгжүүлж, мал борлуулах, түүхий эд бэлтгэх чиглэлээр сум, дүүрэг, тосгодоод иргэдийн хоршоо, нөхөрлөл байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Сүүний үхрийн цогцолбор аж ахуйг дэмжих зорилгоор ХХААХҮЯ-наас зарласан төсөл шалгаруулах тендерт нийслэлийн сүүний үхрийн аж ахуй эрхлэгчдийн 20 төслийг дэмжиж оролцуулснаас 9 төсөл шалгарч 210 сая төгрөгийн зээл авч, төсөл хэрэгжүүлэх ажлаа эхлээд байна.

Хэрэгжилт –50%

88. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.16

Арга хэмжээ – 2.3.16.1 “Мал сүргийг зарим зооноз халдварт өвчнөөс эрүүлжүүлэх” хөтөлөр боловсруулан хэрэгжүүлж, өрх, баг, сум, дүүрэг, аймгийн түвшинд эрүүлжилтийг баталгаажуулан гэрчилгээжүүлэх арга хэмжээ авна.

Биелэлт: Нийслэлийн нутаг дэвсгэрийн 40000 үхэрт зооноз халдварт өвчин дотроос гол халдварт бруцеллёз өвчний оношлогоо шинжилгээг хийх бэлтгэл ажлыг хангах ажлын дагуу 2264 үхрээс бруцеллёз өвчний цусны дээж авч шинжилсэн. Гарсан үр дүнгээс шалтгаалан дүүргийн мал эмнэлэгийн үржлийн нэгжүүд эрүүлжилтийг баталгаажуулах гэрчилгээ олгох ажил хийгдсэн.

Мөн “Бруцеллёз өвчний үед цус авах цагийн норм, норматив тогтоох ажлыг Налайх дүүрэгт, адууны цус багадах өвчний үед цус авахад зарцуулагдах зардлын норматив тогтоох ажлыг Багахангай, Хан-Уул дүүрэгт тус тус хийсэн. Цусны ийлдэс шинжлэхэд шаардлагатай эм урвалж багаж хэрэгсэл, ажиллах хүчний норм нормативын туршилт хийсэн. Туршилт хийсэн дээрх ажлуудын саналыг ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.

Хэрэгжилт –50%

89. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.18

Арга хэмжээ – 2.3.18.1 Зоорь, агуулахын төрөлжсөн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэн, томоохон хотуудад хүнсний нарийн ногооны төрөлжсөн бөөний худалдааны зах, биржийн тогтолцоо бүрдүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн Засаг даргын захирамжаар Баянзүрх дүүргийн 11-р хороонд “Ивээл” ХХК механикжсан зоорь, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд “Грийн сити гарден” ХХК, “Нэкско” ХХК, “Онюга” ХХК өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээлт хийж байнгын ажиллагаатай хүлэмж ногоон зоорь барих шийдвэр гарсаны дагуу 2 компани хашаа барьж, хөрс тэгшлэх, цахилгаан, дулаан ус хангамжийн асуудлаа шийдэж, зоорь барих бэлтгэл ажлаа хангаж байна. Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх дүүргүүдийн зоориудын үйл ажиллагаатай танилцан, судалгаа хийсэн.

Хэрэгжилт –50%

90. Дэд бүлэг – 2.3

Зорилт – 2.3.18

Арга хэмжээ – 2.3.18.2 Нийслэлд 90.0 мянган квадрат метр талбай бүхий хүлэмжийн аж ахуйг шинээр байгуулах, жимс, жимсгэний 50.0 мянган суулгац тариалахад дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн хэмжээнд дуслын усалгааны систем бүхий 120м.кв -139 ширхэг, 240м.кв – 41 ширхэг нийлэг хальсан хүлэмжийг 50 хувийн хөнгөлттэй үнээр 105 иргэн, аж ахуйн нэгжид олгож үйл ажиллагааг нь дэмжлээ. ХХААХҮЯ-наас зарласан “Чацарганы суулгац зээлээр олгох” төслийн хүрээнд 44 иргэн, 16 аж ахуйн нэгжид нийт 45000 суулгацыг 3 жилийн хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр гэрээ хийн олгож, сургалт зохион байгуулсан. Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл 6000м.кв-аар нэмэгдэж, 45000 ширхэг чацарганы суулгац шинээр суулгасан.

Хэрэгжилт –50%

2.4. Дэд бүтэц, хот байгуулалтын бодлого

91. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.3

Арга хэмжээ – 2.4.3.2 “Хотууд” хөтөлбөрийн хүрээнд хотын доторхи авто замын сүлжээг зөв зохистой төлөвлөх, газар ашиглалтыг сайжруулах талаар санал зөвлөмжүүд боловсруулна.

Биелэлт: “Хотууд” үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулахад хамтран оролцож, ЗТБХБЯ-с санал авч нэгтгэн ЗГХЭГ-т хөтөлбөрийн төслийг батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл, танилцуулга, батлагдсан үзэл баримтлал, саналын товъёог, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл зэрэг холбогдох материалуудын хамт хүргүүлээд байна.

Хэрэгжилт –50%

92. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.3

Арга хэмжээ – 2.4.3.4 Хот төлөвлөлтийн норм, дүрмийг шинэчлэн боловсруулна.

Биелэлт: ЗТБХБЯамны хэрэгжүүлэгч агентлаг, Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн төвөөс боловсруулж, ирүүлсэн “Зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, батлах магадлал хийх дүрэм”, “Орон сууцны барилгыг төлөвлөх норм ба дүрэм”-ийн төсөлд санал өгч хамтран ажилласан бөгөөд эдгээр баримт бичгүүд батлагдан мөрдөгдөж байна.

Мөн 2008 онд “Хот байгуулалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан хот байгуулалт, төлөвлөлтийн чиглэлийн дараахь норм, дүрмийг боловсруулж, батлах ажлыг ЭБХБЯ-аас зохион байгуулж, санал өгч, хамтран ажиллаж байна. Үүнд:

-“Орон нутаг дахь газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгжийн үлгэрчилсэн дүрэм”, “Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын дүрэм”, Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар”, “Хот, тосгоны жижүүрийн ерөнхий төлөвлөгөө хөтлөх үлгэрчилсэн заавар” ЗТБХБ-ын сайдын тушаалаар тус тус батлан мөрдөж ажиллаж байна.

-“Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм”-ийн төсөл, “Онцгой зохицуулалттай объект болон түүний нутаг дэвсгэрт хот байгуулалтын үйл ажиллагааны зохицуулалтын журам”; “Хот, суурин газарт улаан шугам тогтоох ба төсөллөх заавар (УББ30-201-07)”, “Хот, тосгоны барилгажилт, нутаг дэвсгэрийн бүсчлэлийн үлгэрчилсэн дүрэм”-ийн төслийг боловсруулахад санал өгч, ажиллаж байна.

“Хот тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын төсөлийн санал боловсруулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын харилцаа, барилга, геодези зураг зүйн газарт хүргүүлсэн.

Хэрэгжилт –50%

93. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.3

Арга хэмжээ – 2.4.3.5 Хотыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төсөл боловсруулж батлуулна.

Биелэлт : ЗТБХБЯаманд Хотыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулж байгаа бөгөөд үзэл баримтлалаа батлуулахаар ХЗДХЯаманд хүргүүлсэн. Энэхүү хуулиар хотыг дахин хөгжүүлэх төрийн нэгдсэн бодлого боловсруулах, зөв зохистой тогтолцоог бий болгох, үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн өөрчлөлт, түүнтэй холбоотой нөхөн төлбөр, нүүлгэн шилжүүлэлт, газрыг албадан болон төлбөртэйгээр хураан авах, нийтийн эзэмшлийн байгууламжуудыг шинээр бий болгох, сайжруулах бодлого боловсруулахад иргэд, олон нийтийн оролцоог хангах, тэдгээрийн үйл ажиллагаа нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хэрхэн уялдах талаархи харилцааг зохицуулна. Уг хууль боловсруулагдсантай холбогдуулж, “Хөрөнгийн үнэлгээний тухай”, “Газрын үнэлгээний тухай”, “Шинэ хотхон, хороолол барьж, хөгжүүлэх тухай”, “Хот, суурины ногоон байгууламжийн тухай”, “Авто зогсоолын тухай” зэрэг хуулиудын төслүүд шинээр боловсруулагдана.

ЗТБХБЯам, Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагатай 2010 - 2013 онд хамтран хэрэгжүүлэх “Монгол улсын хот байгуулалтын салбарын чадавхийг сайжруулах” төслийн хүрээнд төслийн зохицуулах зөвлөл, хууль эрх зүйн болон хот байгуулалтын ажлын хэсгийг тус тус байгуулж, холбогдох хурлуудыг зохион байгуулсан. Энэхүү төслийн хүрээнд “Хотыг дахин хөгжүүлэх тухай” хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах ажлын хэсгийн гишүүд Японы ЖАЙКА-ын төслийн багийн мэргэжилтнүүдтэй хуулийн бүлэг тус бүрээр санал солилцож, хамтран ажилласан.

ЗТБХБ-ын сайдын тушаалаар “Хотыг дахин хөгжүүлэх тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Уг ажлын хэсэг нь Япон улсын Жайка байгууллага болон ХБНГУ-ын GTZ байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтарсан уулзалт, зөвлөгөөн хийж, эдгээр улсын ижил төстэй хуулийн талаар болон хуулийн төсөл үзэл баримтлалд санал солилцон, зарим оновчтой саналыг тусгах, хэлэлцүүлэх үйл ажиллагааг зохион байгуулснаар “Хот байгуулалтын тухай” хуульд суурилсан 5 бүлэг,

18 зүйлтэй “Хотыг дахин хөгжүүлэх тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулсан. Эцсийн хэлэлцүүлгийг 2010 оны 11-р сард зохион байгуулж, боловсруулалт хийн, хуулийн төсөл, үзэл баримтлалыг ХЗДХЯаманд хүргүүлээд байна.

Хэрэгжилт –50%

94. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.3

Арга хэмжээ – 2.4.3.7 “Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын хөтөлбөрийн судалгаа” төслийг боловсруулж, Улаанбаатар хотыг хөгжүүлэхэд шаардлагатай 115 төсөл, хөтөлбөрийг санал болгоно.

Биелэлт : “Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын хөтөлбөрийн судалгаа”-ны ажлын хүрээнд хөгжлийн 16 салбарын чиглэлээр 9,894 сая ам.долларын өртөг бүхий 115 төсөл, үүнээс 50 төслийг нэн тэргүүний ач холбогдолтой гэж үзэж хэрэгжүүлэх саналыг дэвшүүлсэн. Эдгээр төслийг нарийвчлан судлаж, ач холбогдлоор нь эрэмбэлэх, тодотгох зорилгоор 50 төслийг орчуулан, холбогдох 15 байгууллагад албан тоотоор хүргүүлэн санал авч эцэслэн шийдвэрлэх ажил хийгдсэн.

Тус судалгаанд тулгуурлан хотын хөгжлийн томоохон төслүүдийг нийслэлийн төрийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусган боловсруулсан. Улаанбаатар хотыг томоохон төслүүдээр дамжуулан хөгжүүлэх бодлогыг томъёолсны үндсэн дээр “Улаанбаатар хот–Түншүүдийн зөвлөлдөх уулзалт”-ыг Дэлхийн банктай хамтран 2010 оны 5-р сард зохион байгуулсан. Уулзалтанд Монгол улсын Ерөнхий сайд С.Батболд, Монгол улсад суугаа Элчин сайдууд, олон улсын байгууллагууд, гадаадын банк, санхүүгийн байгууллагуудын 55 төлөөлөгч, НЗДТГ, НИТХ-ын Тэргүүлэгчид, нутгийн захиргааны байгууллагуудын удирдлага, банк, санхүүгийн байгууллагуудын 50 төлөөлөгч оролцсон.

Улаанбаатар хотын дэд бүтцийн хөгжил, экологийн тэнцвэрт байдал, агаар хөрсний бохирдлыг бууруулах, аюулгүй, тав тухтай ажиллаж амьдрах орчинг бүрдүүлэх, нийтийн тээвэр, гэр хорооллын барилгажилт зэрэг томоохон асуудлуудыг шийдвэрлэхэд санхүүгийн нэмэлт эх үүсвэр тодорхойлох шаардлагатай болсны үндсэн дээр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон олон улсын судалгааны байгууллагаас тодорхойлсон хэрэгцээний үндсэн дээр Нийгмийн хөгжил, Үйлдвэрлэл, экологи, Барилга, хот байгуулалт, дэд бүтэц, Хот нийтийн аж ахуй гэсэн дөрвөн салбарын хүрээнд нэн тэргүүний 47 төслийн танилцуулга бэлтгэсэн. Уг төслийн танилцуулгыг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудад танилцуулж, санхүүжилтийн эх үүсвэр олохоор ажилласны үр дүнд Хөнгөн төмөр замын систем, тусгай замын автобусны төсөл, нийтийн тээврийг хөгжүүлэх төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөгдөн, 4 чиглэлээр ажлын хэсгүүд байгуулагдсан. Энэхүү ажлын хэсгүүдээр дамжуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад танилцуулж, хөрөнгийн шинэ эх үүсвэрийг бий болгох зорилгоор ажлын хэсгүүдийн уулзалтыг 2010 оны 12 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд зохион байгуулан, хуралдаж, зам тээврийн, ус, ариутгах татуургын, гэр хорооллын талаар, агаарын бохирдол, нийгмийн хөгжлийн, үйлдвэр экологийн гэсэн 6 чиглэлээр дэд хэсгүүдийг байгуулсан.

Ажлын хэсгүүдийн зорилго, ажиллах хүрээ, үүрэг хариуцлагын талаар хэлэлцэж, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй гадаад доноруудын үйл ажиллагааг зохицуулах, хот төлөвлөлттэй уялдуулах, нэн тэргүүний шаардлагатай төслүүдийг дэмжих зорилготойгоор Улаанбаатар хот-Гадаад түншүүдийн ажлын хэсгийн энэхүү анхны хуралдааныг зохион байгуулж, ажлын хэсгийн хуралдаанаас гарсан зорилтыг хангах ажлыг эхлүүлээд байна.

Хэрэгжилт –50%

95. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.4

Арга хэмжээ – 2.4.4.1 “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд орон сууцны 14,7, МҮОНРТ орчмын хорооллын инженерийн дэд бүтцийг барина.

Биелэлт: Монгол улсын Засгийн газрын 2008 оны 303 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийн нэгдүгээр үе үат /2008-2011 он/ хэрэгжүүлэх хорооллуудын дэд бүтэц, барилгажилтыг ажлыг эхлүүлэн, хэрэгжүүлэх эхний үе шатны ажлуудыг холбогдох байгууллагатай хамран хэрэгжүүлж байна. Үүнд:

Хөтөлбөрийн 1-р шатанд баригдах инженерийн дэд бүтэц, барилгажилтийн ажлыг эрчимжүүлэх, хөрөнгийг шийдвэрлэх хүсэлтийг 2009 онд Засгийн газарт оруулж, БНХАУ-аас авах 300,0 сая ам долларын хөнгөлттэй зээлээс “Орон сууцны 7-р хороолол” /23,258 сая ам доллар/, “МҮОНРТ орчмын хороолол” /16,742 сая ам доллар/-ын инженерийн шугам сүлжээнд 40,0 сая ам доллар, “Орон сууцны 14-р хороолол, “Орон сууцны 7-р хороолол”-д 2152 айлын орон сууц, нийгмийн үйлчилгээний барига байгууламж, сургалт, үйлдвэрлэлийн төвийн хамт орон сууцны 14-р хорооллын эхний ээлжийн 8,08 га газарт, 7-р хороололд 3,6 га газарт тус тус барих ажил 60,0 сая ам долларыг тус тус зарцуулахаар

шийдвэрлүүлсэн. Үүний дагуу 2 хорооллын техникийн нөхцлийг авч, холбогдох шугам сүлжээний зураг төслийг боловсруулан, улсын экспертиз хийлгэсэн.

1. Орон сууцны 14-р хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг боловсруулж НИТХ-ын 2007 оны тогтоолоор батлуулсан. Хорооллын дэд бүтцийг барьж байгуулах ажил бүрэн хийгдэж, 2010 оны 9-р сард техникийн комисс хүлээн авсан. Эхний ээлжийн 6-р хэсгийн барилгажилтын ажил хийгдэж дууссан. Газар өмчлөгч эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө оруулалтаар 780 айлын орон сууцны барилга угсралт хийгдэж байна. Үүнд: "Кэй энд Ти Констракшн" ХХК-ийн 282 айлын 4 орон сууц, "Бэрэн Констракшн" ХХК-ийн 168 айлын орон сууц, "Баян хайрхан трейд" ХХК-ийн 140 айлын 2 орон сууц, "ББНЛС" ХХК-ийн 130 айлын орон сууц баригдаж байна.

2. Орон сууцны 7-р хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг боловсруулж, НИТХ-ын 2008 оны тогтоолоор батлуулсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу "Г" хэсгийн эхний ээлжийн 340 айлын орон сууц баригдаж байна. тус хорооллын дэд бүтэц, шугам сүлжээний трасст орсон 854 нэгж талбарын айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, газар чөлөөлөхөд 20,0 тэрбум төгрөгийг зарцуулахаар 2011 оны төсөвт тусгуулж, шийдвэрлүүлсний дагуу бэлтгэл ажлыг хангуулж байна.

3. МҮОНРТ орчмын хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг боловсруулж НИТХ-ын 2006 оны тогтоолоор батлуулсан. Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөрийн 1-р үе шатанд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу ажил хийгдэж эхэлсэн. Төлөвлөлтийн 6-р хэсэгт эхний ээлжийн барилгажилт эхлэн, 60 айлын орон сууцны барилга угсралтын ажил дуусч байгаа боловч дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ баригдаж эхлээгүй тул түр зогсоод байна.

Дээрх хорооллуудын дэд бүтцийн хангамжийг шийдвэрлэх бэлтгэл ажлын хүрээнд дулааны ба,б,в,г гол шугам, бохир усны 25 дугаар коллектор зэрэг шугамын өргөтгөл шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгээд байна. НЗДТГ-аас орон сууцны VII дугаар хороолол, МҮОНРТ-ын орчмын хорооллын инженерийн шугам сүлжээний зураг төслийг захиалан боловсруулсныг ЗТБХБЯ-д хүлээлгэн өгсөн. Уг зураг төслийн дагуу Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг ЗТБХБЯ-аас зарлаж гүйцэтгэгчээр "Бээжин констракшн" ХХК шалгарсан. Одоогоор техник тоног төхөөрөмж, бараа материал татах бэлтгэл ажил хийгдэж байна.

Хэрэгжилт –50%

96. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.4

Арга хэмжээ – 2.4.4.2 "Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө"-ний хүрээнд Дамбадаржаалин хийд орчмын хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг хийж бие даасан инженерийн дэд бүтцийн эх үүсвэр \дулаан- цахилгаан хослон үйлдвэрлэх жижиг оврын станц цэвэрлэх байгууламж\ шугам сүлжээг барьж, барилгажилтийн ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: "Нийтийн аж ахуйг сайжруулах-2" төслийн хүрээнд Сүхбаатар дүүргийн Дамбадаржаагийн гэр хорооллын 80 айл, 8 албан байгууллагыг цэвэр, бохир усны системд холбох шугам сүлжээг барих гүйцэтгэгчээр "Монинжбар" ХХК-ний түншлэл шалгаран ажлаа эхлүүлэн ажиллаж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна. 2011 онд угаалт, шахалт туршилтын ажлыг хийж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

Хэрэгжилт –50%

97. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.4

Арга хэмжээ – 2.4.4.3 Өнөр хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг олон нийтийн оролцоотой боловсруулан инженерийн дэд бүтцийг барьж эхэлнэ.

Биелэлт: "Өнөр хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг тендерт шалгарсан компани боловсруулаад байна. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл батлагдаагүй байгаа тул инженерийн шугам сүлжээний зураг төсөв боловсруулах улмаар барьж байгуулах хөрөнгийн асуудал шийдвэрлэгдэх боломжгүй байна.

Хэрэгжилт –50%

98. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.4

Арга хэмжээ – 2.4.4.4 Улаанбаатар хотын бохир усны 21, 22, 25, 31 дүгээр коллекторуудын шугам сүлжээг шинэчлэн өргөтгөж, шинээр барьж байгуулна.

Биелэлт: Бохир усны 25-р коллекторын ажил улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж 2009 онд ашиглалтанд орсон. 21-р коллектор, 31-III коллекторын шугамын трасс, хамгаалалтын зурвасыг тогтоож, шугамын угсралтын ажлын зөвшөөрлийг нийслэлийн Засаг даргын захирамжаар олгосон.

31-III коллекторын ф500-н бохирын усны 556м урт шугам угсралтын ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажил бүрэн дуусч, 11-р сард улсын комисст хүлээлгэн өгсөн.

21-р коллектор барих ажил 7-р хорооллын инженерийн шугам сүлжээний багцад багтаж байгаа бөгөөд ажлын зураг төсөл боловсруулагдаж дууссан. Одоогоор техник тоног төхөөрөмж, бараа материал татах бэлтгэл ажил хийгдэж байна.

22-р коллекторын ажил нийт 1,6 км барилга угсралтын ажил гүйцэтгэхээс одоогийн байдлаар 1,14 км шугам угсралтын ажил гүйцэтгээд байна. Гүйцэтгэгчээр "Байгуламж" ХХК ажиллаж байна.

Хэрэгжилт –50%

99. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.4

Арга хэмжээ – 2.4.4.5 Багануур дүүргийн цэвэрлэх байгууламжийг засварлан шинэчлэнэ.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгөөр Багануур дүүргийн цэвэрлэх байгууламжийн өргөтгөл шинэчлэл, усны лабораторийн барилгыг барих ажлыг "Сан" ХХК, "Байгууламж" ХХК-ийн түншлэл 1,3 тэрбум төгрөгийн өртөгтэйгээр барьж, дуусган улсын комисст хүлээлгэн өгсөн. Цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажилд 10,000м³/хон хүчин чадалтай 2 блокийг сэргээн засварлаж ашиглалтанд оруулахаар төлөвлөсөн бөгөөд биологи цэвэрлэгээний био шүүлтүүрийг аеротенк болгон өөрчлөх зэрэг ажлууд хийгдсэн.

Хэрэгжилт –100%

100. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.4

Арга хэмжээ – 2.4.4.6 Баянголын аманд баригдах шинэ хотхон, хорооллын инженерийн шугам сүлжээ, Улаанбаатар хотын ТЭЦ 4-ийн илүүдэл уурын станцын барилга барина.

Биелэлт: Баянголын аманд баригдсан цэвэр, бохир усны шугамын угсралтын ажил дууссан. Одоогоор цахилгаан, дулааны шугам сүлжээ бүрэн баригдаагүй, шугаманд холбогдох хэрэглэгч цөөн зэрэг шалтгаанаас ашиглалтанд хүлээж аваагүй байна. Дулааны эх үүсвэртэй холбох шугам сүлжээний 3-р ээлжийг барих ажлын гүйцэтгэгчээр "Одкон холдинг" ХХК 2008 оноос ажиллаж ф800 мм-ийн 1,35 км хос дулааны шугам шинэчилж байна.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр Баянголын амны дулааны салбар шугам, цахилгаан хангамжийн дэд өртөөний зураг төсөл боловсруулах хөрөнгө, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдсан гүйцэтгэгчийг шалгаруулан зураг хийлгэж байна. ТЭЦ-4-ийн илүүдэл уурын станцын барилгын зураг төсөл хийгдэж байна.

Хэрэгжилт –50%

101. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.4

Арга хэмжээ – 2.4.4.8 Буянт Ухаа 14 дүгээр хороолол, Зүүн сэлбэ хорооллыг цахилгаанаар хангах шугам сүлжээ татна.

Биелэлт: БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлд хамрагдаж 14 дүгээр хорооллын зураг төсөл хийгдсэн. Зүүн сэлбэ хорооллын хөрөнгийн асуудал Улсын төсвөөс шийдэгдээгүй байна.

Хэрэгжилт –50%

102. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.4

Арга хэмжээ – 2.4.4.9 Гандантэгчилэн хийдийн гэр хорооллын дулаан хангамж, цэвэр усны салбар шугамыг барина.

Биелэлт: Гандантэгчилэн хийдийн гэр хорооллын дулаан хангамж, цэвэр, бохир усны салбар шугамын зураг төслийг НЗДТГазрын захиалгаар "Инж байгууламж" ХХК боловсруулж дуусган, ерөнхий төлөвлөгөө батлагдсан. Хэсэгчилэн холбогдож байна. Иргэн, аж ахуйн нэгжүүд өөрсдийн хөрөнгөөр салбар шугам барих ажил хийж эхлээд байна.

Хэрэгжилт –50%

103. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.4

Арга хэмжээ – 2.4.4.10 Хайлаастын үерийн далан шугамыг шинэчлэнэ.

Биелэлт: Хайлаастын үерийн хамгаалалтын даланг шинээр барьсан боловч үер усанд эвдэрч сүйдсэнийг дахин шинээр сэргээхээр ЗТБХБЯ-ны захиалгаар 2008 онд Чингэлтэй, Хайлаастын үерийн далан сувгийг шинэчлэх зураг төслийг боловсруулах ажлыг хийж дуусган, экспертээр хянуулж баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Далан сувгийг барих хөрөнгийг 2011 оны улсын төсөвт 300,0 сая төгрөг тусган шийдвэрлүүлсэн.

Нийслэлийн төсвөөс 2010 онд 692.0 сая төгрөгийн хөрөнгө гарган нийт 20 байршилд шинээр баригдах болон шинэчлэх шаардлагатай үерийн хамгаалалтын барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн байгууллагуудаар хийж гүйцэтгүүлээд байна. Сонгинохайрхан дүүргийн Толгойтын голын

авто замын гүүрнээс дээш 400 метр үерийн хамгаалалтын далангийн шинэчлэлтийн ажлыг "НААСТ-2" төслийн хүрээнд "ЧММ" ХХК хийж гүйцэтгэлээ.

Улаанбаатар хотын иргэд, оршин суугчдыг болзошгүй үер, усны гамшгаас хамгаалах зорилгоор урьдчилсан барилга байгууламж барих ажилд Нийслэлийн төсвөөс 600.0 сая төгрөг гарган барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна. Урьдчилсан арга хэмжээний үерийн хамгаалалтын барилга байгууламжийг байршлаар тодорхойлбол:

1. Баянзүрх дүүргийн 13,14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт авто болон төмөр зам доогуурх нүхэн гаргалгаа
2. Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо Биокомбинатын үерийн хамгаалалтын далангийн шинэчлэлт авто зам доогуурх гаргалгаа 400 м габион далан
3. Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны үерийн хамгаалалтын сувгийг цэвэрлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тус хорооны хөрсний ус доошлуулах шугмын барилга угсралтын ажлыг дараа төлөгдөх нөхцөлтэйгээр "Хангилцаг" ХХК гүйцэтгэн дуусгаад байна.

Хэрэгжилт –100%

104. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.4

Арга хэмжээ – 2.4.4.11 Буянт-Ухаа хороолол дахь оюутны хотхоны гадна болон салбар инженерийн шугам сүлжээг барина.

Биелэлт: Орон сууцны Буянт-Ухаа хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдах "Оюутны хотхон"-ны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг 30.0 га газарт боловсруулж НИТХ-ын тогтоолоор батлагдсан. Нийслэлийн Засаг даргын захирамжаар Буянт-Ухаа хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдах оюутны хотхоны 7.5 га газрыг ЗТБХЯ, нийслэлийн Хүүхдийн төлөө газарт олгосон.

Орон сууцны Буянт-Ухаа хорооллыг дулаанаар хангахын тулд 11.6 км урттай 8.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13 дугаар магистралийг ф700 мм-ийн голчтой болгон өргөтгөж ашиглалтанд оруулсан. Мөн 1.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ф150-ф250 мм-ын гочтой 2.5 км урт 11 ширхэг салбар шугамыг барьж ашиглалтанд оруулсан болно. Цахилгаан хангамжийн хувьд ЗТБХБЯ-ны захиалгаар 110/35/10 кВ-ын дэд өртөө, 6.3 км 110 кВт-ын агаарын шугамын ажлын зураг төслийг боловсруулж дуусгасан.

Цэвэр усны шинэ эх үүсвэрийн хайгуул судалгааг "Экос" ХХК боловсруулж Усны салбарын шинжлэх ухааны технологийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр зөвшөөрсөн дүгнэлт гарсан. Орон сууцны хорооллын ф100-300 мм-ийн голчтой 2.9 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй цэвэр усны, ф350-800 мм-ийн голчтой 1.7 тэрбум төгрөгийн өртөгтэй бохир усны шугам сүлжээний ажлын зураг төслийг Инж байгууламж ХХК боловсруулан батлуулсан. ХБНГУ-ын техник туслалцааны хүрээнд тус хорооллын техник эдийн засгийн үндэслэлийг Сэргээн босголт банкны буцалтгүй тусламжаар Gitec компани хийж гүйцэтгэхээр шийдвэрлэгдсэн.

Хэрэгжилт –50%

105. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.4

Арга хэмжээ – 2.4.4.12 Орон сууцны компаниудын харьяанд байгаа хорооллын доторх цэвэр ус, дулаан хангамжийн шугам сүлжээг өргөтгөн шинэчлэнэ.

Биелэлт: Улаанбаатар хотын хорооллын доторхи гадна дулаан, усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг шинээр барих өргөтгөх, шинэчлэх хөрөнгийн асуудлыг улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар хэрэгжүүлэхээр ажиллаж байна. 2010 онд хорооллын доторхи гадна дулаан, усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх ажилд нийслэлийн төсвөөс 827,7 сая төгрөг зарцуулж 12,6 км шугам сүлжээг шинэчлэх ажлыг хийсэн бөгөөд 2011 онд уг ажилд 1,0 тэрбум төгрөг батлагдсан.

Жил бүр инженерийн шугам сүлжээг солих, шинэчлэх ажлыг хийхэд өмнө ихээхэн хөрөнгө зарцуулж хийсэн нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийг эвдэх, ус, дулаан түгээлтийн хэвийн найдвартай ажиллагаанд доголдол үүсгэх, үүнээс шалтгаалан айл өрхийг халаалт, хэрэгцээний халуун, хүйтэн усаар тасалдуулах зэрэг хүндрэлүүд гардаг. Дээрх хүндрэлүүдийг арилгахын тулд Улаанбаатар хотын газар доорх инженерийн шугам сүлжээнүүдийг хонгилын системд ээлж дараатайгаар шилжүүлэх ажлыг хийхээр төлөвлөж 2011 оны нийслэлийн төсөвт 1,0 тэрбум төгрөгийг тусгасан. ОСНАУГ-ын харьяа 16 компаний дулаан хангамжийн ажлыг "Инж байгууламж" ХХК бүрэн хийж дууссан.

Хэрэгжилт –50%

106. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.4

Арга хэмжээ – 2.4.4.13 Гэр хорооллын доторхи авто замыг үе шаттай сайжруулах

Биелэлт: 2010 онд гэр хорооллын нөхцлийг сайжруулахад улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 11 км авто зам баригдсан. 2010-2011 онд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих “Хот байгуулалтын салбар” төслийн дотоод эх үүсвэрт 298,0 сая төгрөгийг төлөвлөсөн. Хөнгөлөлттэй зээлээр нийт 3.194.0 сая төгрөгийн хүрээнд 12.3 км авто замын 3 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж байна. Үүнд: Хайлаастын 1,1км авто зам, Баруун салааны 4,1км авто зам, Орбит-Тахилтын 7,1км авто замын ажлуудыг шинээр хийхээр төлөвлөсний дагуу зам барилгын ажлууд эхэлсэн. Мөн Баянзүрх дүүргийн Ботаник-Шархадны чиглэлийн 6,5 км авто замыг шинээр барихаар ажлаа эхэлсэн. /гэрээ ёсоор 2011 онд дуусна/

Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар :

1. Чингэлтэй дүүргийн 10-р хороо 39-р сургуулийн баруун талын үерийн суваг дээгүүр 10,6 у/м төмөрбетон гүүр, 167 м авто зам шинээр барих ажлыг хийж, улсын комисст хүлээлгэн өгсөн.
2. Баянзүрх дүүргийн Энхтайваны өргөн чөлөөнөөс Жанжин клуб хүртэл 0.8 км авто зам шинээр барих ажлыг хийсэн. Үүнд: авто замын ул хөрсийг нийт уртад хуулан зайлуулах, далангийн дүүргэлт, холбоо, цахилгааны шугам шилжүүлэх ажлууд болон хашлага суулгах, асфальтобетон хучилтын ажлууд хийгдсэн.

Бус орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар

1. Баянзүрх дүүргийн Кино үйлдвэрийн урдурх замын үргэлжлэл 0.57 км авто замын ажлыг бүрэн хийж дууссан. Авто замын нийт уртад хөрс хуулалт, далангийн дүүргэлтийн ажлууд, борооны ус зайлуулах шугам сүлжээний худгийн тагуудыг бүрэн сэргээх ажлууд болон авто замын хашлага, явган замын хашлага ажлууд болон хучилтын ажлууд бүрэн хийгдсэн.
2. Сүхбаатар дүүргийн 15-р хороо Хандгайт-Санзайн төв замын уулзвараас хүүхдийн Хандгайт зуслан хүртэлх 1.6 км хатуу хучилттай авто замын ажлыг бүрэн дуусгасан. Ажлын хүрээнд авто замын нийт уртад хөрс хуулалт, 4 цэгт төмөрбетон хоолойн суурийн цутгалт, арматурчлалын ажлууд, далангийн ажлууд болон асфальтобетон хучилтын ажлууд хийгдсэн.
3. Баянзүрх дүүргийн Алтан Өлгий, Монелийн задгай, Моносын хэсгийн 2 км авто замын далан дүүргэлтийн болон газар чөлөөлөх, хашлага тавих ажлууд хийгдэж, хучилтийн ажил хийгдсэн ба газар чөлөөлөлтийн асуудлаас шалтгаалан 100 метрт хучилтын ажил хийгдээгүй үлдсэн.
4. Баянгол дүүргийн 9-р хорооны 1.2 км авто замын барилгын ажлын хүрээнд суурь болон өнгө асфальтобетон хучилт, хэвтээ тэмдэглэгээ, явган замын ажил хийгдэж дууссан. 2010 оны 11-р сард техникийн комисс ажилласан.
5. Баянгол дүүргийн 10-р хорооны 0.9 км авто замын барилгын ажлын хүрээнд суурь болон өнгө асфальтобетон хучилт, явган хүний зам, заслын ажлууд хийгдэж дууссан. 2010 оны 11-р сард техникийн комисс ажилласан.
6. Баянгол дүүргийн 11-р хороо 1.4км авто замын далан дүүргэлтийн болон газар чөлөөлөх, хашлага тавих ажлууд хийгдэн, суурь хучилтийн ажил бүрэн хийгдэж, өнгө хучилт 400 м-т дутуу хийгдсэн. Гүйцэтгэгчээр “УБЗЗАК” ажиллан ажлын явц газар чөлөөлөлтийн асуудлаас шалтгаалан 90 хувьтай хийгдсэн.

2010 онд Улаанбаатар хотын авто замын сүлжээг сайжруулахаар өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн

Улсын төсвөөс дараа төлөгдөх нөхцлөөр:

1. “УБ хотын хуурай хог хаягдлын мастер төлөвлөгөө боловсруулах” төсөл, Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэг хүртэлх авто замын гэрэлтүүлэг, хиймэл байгууламж, газар шорооны ажил, асфальтобетон хучилтын ажлууд бүрэн хийгдсэн.
2. Дамбын замаас Сэлбийн зүүн эргээр Шадивлан хүртэлх 6 км, Сансарын ШТС-аас Дамбадаржаа хүртэлх 6.7 км авто замын газар шорооны ажлууд болон барилгын ажлын талбай чөлөөлөх, шугам сүлжээ шилжүүлэх ажлууд хийгдсэн.

Улаанбаатар хотын авто замын сүлжээг сайжруулах ажлын хүрээнд

- Анх удаа нийслэлийн замын салбарт хөрөнгө оруулалтын шинэ хэлбэр болох Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэй 60,606.2 сая төгрөгийн 20 төсөл, арга хэмжээ
- Бус орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр улсын төсвийн 4,065.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 14 төсөл арга хэмжээ
- Нийслэлийн замын сангийн 6,467.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 75 төсөл арга хэмжээ
- Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн 3,194.0 сая төгрөгийн хөрөнгөөр 3 төсөл, арга хэмжээ

- Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 377.7 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ
- Он дамжин 3 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж нийт 74.705.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг гүйцэтгэлээ.

Хэрэгжилт –50%

107. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.5

Арга хэмжээ – 2.4.5.2 Монгол улсын иргэн бүрт үнэгүй өмчлүүлэх боломжтой газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоож, газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт: 2010 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэдэд одоо байгаа 86.27 га газрыг 1416 иргэнд өмчлүүлэх, шинээр суурьшлын бүс бий болгох замаар иргэдэд 8.5 га газрыг эзэмшүүлж, өмчлүүлэх, нийслэлийн ногоон бүсэд зуслангийн зориулалтаар эзэмшиж буй 156.8 га газрыг тус тус өмчлүүлэхээр тусгасан. Нийслэлийн Засаг даргын 6 удаагийн захирамжаар 4031 иргэнд 2229,9 га газрыг үнэгүйгээр, 20 иргэнд 860 м2 илүү газрыг үнээр өмчлүүлээд байна. өмнө нь гэр бүлээрээ хамтран өмчилсөн 915 өрхийн шийдвэрээс хамтран өмчлөгчийн эрхийг хасуулах шийдвэрийг гаргуулсан бөгөөд 1678 иргэнд нийслэлийн нутаг дэвсгэрт газар өмчилж аваагүй тодорхойлолтыг гаргаж өгсөн.

Хэрэгжилт –50%

Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.5

Арга хэмжээ – 2.4.5.3 Нийслэлийг аймгийн төвүүдтэй холбосон улсын чанартай авто замын дагуу иргэдэд өмчлүүлэх боломжтой газрын хэмжээ байршил, зориулалтыг тогтоож, өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Нийслэлийг аймгийн төвүүдтэй холбосон улсын чанартай авто замын дагуух газрыг Нийслэлийн эдэлбэр газарт шилжүүлсний дараа иргэдэд өмчлүүлэх боломжтой тул нутгийн захиргааны байгууллагаас үл хамаарна.

108. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.5

Арга хэмжээ – 2.4.5.4 Аж ахуйн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан өмчлүүлэх газар, тариалангийн болон эрчимжсэн фермерийн аж ахуйн зориулалтын газрын хэмжээ, байршлыг тогтоон, өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.,

Биелэлт: Нийслэлийн иргэдийг экологийн цэвэр, органик хүнсний бүтээгдэхүүнээр хангах зорилгоор 55 га газрыг Фермерийн болон эрчимжсэн хөдөө аж ахуйг дэмжих, 12 га газрыг жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр тус тус эзэмшүүлэхээр Нийслэлийн газар зохион байгуулалтын 2010 оны төлөвлөгөөнд тусгаж батлалсны дагуу хөдөө аж ахуйн зориулалтаар эзэмшүүлэх газрын байршлыг шийдэж, иргэдэд хуваарилах газрын байршил хэмжээг тогтоосон.

Хэрэгжилт –50%

109. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.6

Арга хэмжээ – 2.4.6.5 Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг эргэлтийн цэгийн солбицлуудаар тодорхойлон баталгаажуулах ажлыг шат дараатай хийж, солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлнэ.

Биелэлт: Улаанбаатар хот, Төв аймгийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийн олон жилийн турш үргэлжилсэн маргаан, нийслэл, дүүрэг, хороодын нутаг дэвсгэрийн хилийн цэсийн давхардсан, орхигдсон газрын асуудлыг шийдвэрлүүлэх тухай санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, боловсруулсан саналыг ЗТБХБЯ-нд хүргүүлсэн. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газарт Мянганы сорилтын сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй хөрөнгийн эрхийн төслийн хүрээнд УБ хотод GPS –ийн байнгын ажиглалтын 3 станц шинээр байрлуулахаар шийдвэрлэж одоогийн байдлаар уг станцуудын хамрах хүрээ болон үр дүнг нь бүрэн ашиглаж байхаар суурилуулах байршлыг сонгох тал дээр ажиллаж байна.

Хэрэгжилт –50%

110. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.7

Арга хэмжээ – 2.4.7.1 Шинэ хотхон хорооллыг барих ажлын хүрээнд 37.0 мянган орон сууц барина.

Биелэлт: 2008-2009 онд хотын захын нөөц газар Баянголын аманд 18.000; “Буянт-Ухаа” хороололд 10.000; “Яармаг” хороололд 5.000; “Ургах наран” хороололд 10.750; “Хотын шинэ төв”-д 12.000; Дүнжингарав хороололд 5.000; нийт 60.750 айлын орон сууцны хороолол барьж байгуулах хэсэгчилсэн

ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, НИТХ-аар батлуулан, газар олголт, инженерийн хангамж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх, шинэчлэн байгуулах зэрэг тодорхой ажлуудыг хийж эхлүүлсэн.

Дээрх хорооллуудын инженерийн шугам сүлжээг иж бүрэн барих ажил хийгдээгүйгээс барилгажилтын ажил ерөнхий төлөвлөгөөний дагуу иж бүрэн хийгдэж чадахгүй байна. Одоогийн байдлаар Дүнжингарав хороолол ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдаж 540 айлын орон сууц ашиглалтанд орсон. Харин бусад хорооллын хувьд Ургах наран хороололд 120, Баянголын аманд 24, яармаг 2 хороололд 140 айлын орон сууцны барилгын угсралтын ажил гадаад дотоодын хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байна. Маршал таун хороололд 90 айлын орон сууц, Дөрвөн улирлын цэцэрлэг хороололд 372 айлын орон сууц ашиглалтанд орсон.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар Баянголын амны дулааны салбар шугам, цахилгаан хангамжийн дэд өртөө, Буянт-Ухаа хорооллын цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ, Ургах наран хорооллын барилгажилтын төсөл, Улаанбаатар-Налайхын зам дагуух, Налайх-Багахангайн замын тойруу орчмын зам дагасан хөгжлийг тэтгэсэн орон сууцны хороолол байгуулах ТЭЗҮ боловсруулах зураг төсвийн ажлын хөрөнгө, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдан гүйцэтгэгчийн тендер зарлаж гүйцэтгэгч нар шалгарсан.

- Улаанбаатар-Налайхын зам дагуух, Налайх-Багахангайн замын тойруу орчмын зам дагасан хөгжлийг тэтгэсэн орон сууцны хороолол байгуулах ТЭЗҮ боловсруулах ажлыг "ХБХДТ" ХХК,
- "Ургах наран хорооллын барилгажилтын төсөл боловсруулах ажлыг "Архитектур нэгдэл" ХХК
- Буянт-Ухаа хорооллын цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ боловсруулах ажлын хувьд гүйцэтгэгчийн тендерийг ЗТБХБЯамнаас зарлаж ХБНГУ-ын KfW банкны санхүүжилтээр "GITEC Консалт" ХХК, "Монгол Эрдэм" ХХК хамтран
- Баянголын амны цахилгааны 110/35/10 кВ-ын дэд өртөө, 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төслийн ажлыг "Эрчим инженеринг" ХХК тус тус шалгарсан.

Хэрэгжилт –50%

111. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.7

Арга хэмжээ – 2.4.7.2 Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх чиглэлийн хүрээнд 24.5 мянган орон сууц барина.

Биелэлт: Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 7-р хорооллын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Баянгол дүүргийн 9, 10, 11-р хорооны нутаг дэвсгэрт хамрагдаж буй нийт 2880 газар эзэмшигч, ашиглагч аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн судалгааг гаргаж шинээр тавигдах болон өргөтгөх замын трасст орсон 854 аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн эзэмшиж байгаа газрын судалгааг тус тус гаргасан. Тус хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууц барих барилгажуулах ажил үргэлжлэн явагдаж байгаа бөгөөд 2010 онд 96 айлын орон сууцны эхний ээлжийн барилга ашиглалтанд орсон. 300 айлан түр оршин суух орон сууцны барилгын ажил эхэлсэн. Мөн Орон сууц санхүүжилтийн корпораци, Анд интернешнл ХХК орон сууц барих газраа чөлөлөх ажил хийгдэж байна.

Иргэд олон нийтийн оролцоонд түшиглэн амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулж тэдний амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор нийслэлийн төвийн 6 дүүрэгт гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах, дахин төлөвлөх загвар төсөл хэрэгжиж байна.

Орон сууцны VII, XIV, Зүүн Сэлбэ, Яармаг, Гандан, РТХЭГ, Алтан өлгий, Дарь-Эх, Дэнжийн 1000, VII бичил, Цэргийн хотхон, Ханын материал орчмын ерөнхий төлөвлөгөөг НИТХ-р батлуулан газар өмчлөгч, эзэмшигчдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ажил эхлээд байна. Тухайлбал: Зүүн Сэлбэ, орон сууцны XIV, VII хороолол, РТХЭГ орчим, Гандан, Дарь-Эх, Алтан-Өлгий орчмын гэр хорооллын газарт 2000 айлын орон сууц, үйлчилгээний барилга баригдаж байгаагаас 650 айлын орон сууцны барилга ашиглалтанд орсон.

Монгол улсыг хөгжүүлэх сан болон улс, нийлэлийн 11.25 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Орон сууцны VII, Дэнжийн-1000 хорооллын бохир усыг татан зайлуулах шугамыг шинээр барих, дулаанаар хангах шугамыг өргөтгөх, хотын төвийн болон хойд хэсгийн хөрсний ус зайлуулах барилга байгууламжийг барих ажлыг гүйцэтгэж, ашиглалтанд оруулсан. Мөн 5.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1.6 км урт дулааны шугам, 2.4 км урт ба шугамыг өргөтгөн шинэчлэх ажлыг гүйцэтгэж 2010 оны 9 дүгээр сард ашиглалтанд оруулсан. Хорооллыг цэвэр усаар хангах 2.3 км урт шугам, бохирыг татан зайлуулах 1.6 км урт шугам /21-р коллектор/-ын ажлын зураг төслийг тус тус боловсруулж дуусгасан.

БНХАУ-ын Засгийн газрын 300.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөс 60.0 сая ам. долларыг “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 1 дүгээр шатны зорилтын хүрээнд орон сууцны VII хорооллын 3.6 га, XIV хорооллын 8.08 га газарт 2152 айлын орон сууц, нийгмийн үйлчилгээний барилга байгууламж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хамт барихад зарцуулахаар шийдвэрлэсэн.

Гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд айл өрхийг түр суурьшуулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын захирамжаар орон сууцны 7-р хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Сүхбаатар дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт нийслэлийн өмчийн харилцааны газрын аж ахуйн хашаанд байршлыг тогтоон 300 айлын орон сууцны барилга барих шийдвэр гарсан. Үүний дагуу зураг төслийг боловсруулж, 2010 онд Нийслэлийн төсвөөс 2,5 тэрбум төгрөг гарган барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. 2011 оны төсөвт 8,5 тэрбум төгрөгийг тусгуулан НИТХ-ын хуралдаанаар батлуулан 2011 онд барилга угсралтын ажлыг дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. Цаашид төвийн 6 дүүрэгт түр суурьшуулах орон сууц барих бэлтгэл ажлын хүрээнд Баянгол, Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт нийт 1200 айлын орон сууц барихаар төлөвлөн, нийслэлийн Засаг даргын захирамж гарч, хөрөнгийн асуудлыг шийдвэрлээд байна.

Хэрэгжилт –30%

112. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.7

Арга хэмжээ – 2.4.7.3 Нягтрал сайжруулах чиглэлээр баригдах бичил хороолол, цогцолборуудын хүрээнд 38.5 мянган орон сууц барина.

Биелэлт: Хотын инженерийн шугам сүлжээ бүхий төвийн хэсэгт 2008-2009 онд 13.000 гаруй айлын орон сууцны барилга дотоод, гадаадын хувийн хэвшлийн болон улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтанд орсон.

2010 онд Улсын комисс нийт 319 барилга, объектыг хүлээн авсанаас 10024 айлын 134 орон сууцны барилгыг ашиглалтанд оруулсан. Мөн хотын 1 дүгээр бүсэд аж ахуйн хашаа, агуулахын зориулалтаар газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг Мэргэжлийн комиссын хурлаар орон сууц, олон нийт, үйлдвэрлэл үйлчилгээ, конторын нийт 221 барилга байгууламжийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө оруулалтаар барих зөвшөөрлийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлээ.

Хэрэгжилт –30%

113. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.8

Арга хэмжээ – 2.4.8.6 Нийслэл хотыг хөгжүүлэх орон сууцны хороолол, суурин газруудыг байгуулахад шаардагдах цэвэр усны хайгуул хийж нөөцийг тогтооно.

Биелэлт: Нисэх, Яармаг, Буянт ухаагийн хороололд 20000м³ /хонгот, дээд эх үүсвэрийн Уу булангаас Туул бэлчирийн хооронд 40000м³/хон ус хангамжийн эх үүсвэрүүдэд тус тус хайгуулж хийж нөөц тогтоогоод байна.

Япон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын судалгааны баг ирж, Гачууртын дээд хэсэгт "Гачуурт" ус хангамжийн шинэ эх үүсвэр барихаар төлөвлөсөн газарт судалгааны ажлыг хийсэн. Үүний дагуу байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийж, 25200 шоо метр усны нөөцтэйг тогтоож Усны газрын комиссоор баталгаажуулж дүгнэлтийг БОАЖЯ-р хэлэлцүүлэн Жайка олон улсын байгууллагад хүлээлгэн өгсөн. Уг ажлыг Японы засгийн газрын буцалтгүй тусламжаар 32 сая долларын хөрөнгөөр 2012-2014 онд хийж гүйцэтгэн, ашиглалтанд оруулахаар төлөвлөж байна.

Энэхүү ундны усны шинэ эх үүсвэрийг байгуулахдаа ус татах 21 худгаар дамжуулан, 25200 метр куб ус хоногт олборлох бөгөөд 4.8 км урттай ус цуглуулах шугам хоолой, 8000 метр кубын багтаамжтай усан сан, 19.5 км урт ус дамжуулах магистраль шугам хоолойтой байхаар төлөвлөж байна. Ингэснээр Улаанбаатар хотын ус хангамжийн хүчин чадал хоногт 20.000м³-ээр нэмэгдэх боломж бүрдэн, нийслэл хотын хангамжийн асуудал сайжрах юм.

Хэрэгжилт –70%

114. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.9

Арга хэмжээ – 2.4.9.1 Нийслэл хотын хөгжлийн тулгамдсан асуудлыг иж бүрнээр шийдвэрлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулан үе шаттай хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

Биелэлт: “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг боловсруулж, Улсын Их Хурлын хаврын чуулганы 2010 оны 6 дугаар сарын хуралдаанаар хэлэлцэгдэн, дэмжигдсэн. Хөтөлбөрт Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Хотууд”, “Шинэ Улаанбаатар-Ногоон нийслэл”, “Хөдөөгийн хөгжил”, “Орон сууц” зэрэг бодлогын баримт бичгүүдийн

хүрээнд хийгдэх ажлууд болон “100 мянган айлын орон сууц”, “Нийслэлийн орон сууц”, “Барилгын материалын үйлдвэр” зэрэг төслүүдийн хүрээнд хийгдэх ажлуудыг нэгтгэсэн.

“100 мянган айлын орон сууц” төсөлд хамрагдаж буй хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор Баянголын амны дулааны салбар шугам, цахилгаан хангамжийн дэд өртөө, Буянт-Ухаа хорооллын цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ, Дэнжийн 1000 хорооллын инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, мөн Ургах наран, Зүүн Сэлбэ хорооллын барилгажилтын төсөл, Улаанбаатар-Налайхын зам дагуух, Налайх-Багахангайн замын тойруу орчмын зам дагасан хөгжлийг тэтгэсэн орон сууцны хороолол байгуулах ТЭЗҮ боловсруулах зураг төсвийн ажлын хөрөнгийг шийдвэрлэсэн ба гүйцэтгэгчийн тендерийг зарлаж гүйцэтгэгчдийг шалгаруулсан.

Нийслэл хотын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд нэн тэргүүнд шаардлагатай агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, гэр хорооллыг барилгажуулах, дэд бүтцийг барьж байгуулах, иргэдэд өмчлөгдсөн газрыг орон сууцаар солих бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулагдсан 15 төслийн танилцуулгыг СЯ болон ҮХШХороонд хүргүүлээ. Эдгээр төслүүдээс 6 нэр төрлийн ажил МУ-ын хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан.

“Шинэ Улаанбаатар-Ногоон нийслэл” хөтөлбөрийн төслийг боловсруулж, санал авч нэгтгэн ЗГХЭГ-т “Шинэ Улаанбаатар-ногоон нийслэл” хөтөлбөрийн төслийг батлах тухай Засгийн Газрын тогтоолын төсөл, танилцуулга, саналын товъёог, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл зэрэг холбогдох материалуудын хамт хүргүүлсэн. “100 мянган орон сууц” төслийн хүрээнд Улаанбаатар хотын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх “Улаанбаатар хотын орон сууц” нийслэлийн дэд хөтөлбөрийн төсөл боловсруулж байна.

Засгийн газрын тогтоолоор “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр” батлагдсан. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх орон сууцны хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүд боловсруулагдаж төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр Нийслэлийн Засаг даргаар ахлуулсан “Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хотын инженерийн хангамжийн эх үүсвэр, дэд бүтэц, техникийн шийдэл гаргах, хөрөнгө оруулалтын тооцоо судалгаа, инженерийн дэд бүтцийн ерөнхий схем гаргах” ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Хэрэгжилт –50%

115. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.12

Арга хэмжээ – 2.4.12.1 Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны шинэ буудлыг түшиглэн “Airport city” байгуулах ажлын иж бүрэн зураг төслийн ажлыг боловсруулж хэрэгжүүлж эхэлнэ.

Биелэлт: Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах AIRPORT CITY төслийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврыг ЗТБХБЯ-ны сайдаар батлуулан, “AIRPORT CITY” байгуулах ТЭЗҮ-г боловсруулах тендер зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан компани ажлыг гүйцэтгэж байна. 2010 оны 2-р сард ТЭЗҮ-ийг боловсруулах ажлын явцыг ЗТБХБЯ-ны сайдад танилцуулсан. Тус ажлын хүрээнд Хөшигийн хөндий рүү ТЭЦ 4-өөс татах 110 кВт-ын цахилгааны шугамын болон хурдны авто зам тавих ажлын зураг, техникийн зураг төсөл бүрэн дууссан. Хөшигийн хөндий рүү төмөр зам тавих төсөл хийгдэж байна.

Монгол улс болон Япон улсын Засгийн Газар хооронд байгуулсан гэрээний дагуу Жайка байгууллагын төслийн хүрээнд Хөшигийн хөндийд баригдах Шинэ нисэх буудлын төв байр, туслах барилга байгууламж, дэд бүтцийн хангамжийн зураг төслийг Япон улсын “Ориентал консалтанс” ХХК, “Азуса Секкей” ХХК-иуд боловсруулан, Монгол талын зөвлөхөөр “Эм Си Пи Си” ХХК, “Гоби травэл” ХХК-иуд сонгогдон, хамтран ажиллаж байна.

Хэрэгжилт –50%

116. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.13

Арга хэмжээ – 2.4.13.1 Улаанбаатар хот болон томоохон суурин газрын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг хөдөлгөөний аюулгүй байдал, стандартын шаардлага хангасан их багтаамжийн 500 автобусаар шинэчилнэ.

Биелэлт: Монгол улсыг хөгжүүлэх сан, Улсын төсвөөс нийт 31,7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр БНСУ-ын “ДЭУ” корпорацаас их багтаамжийн BS-106 маркийн 400 автобус шинээр нийлүүлэгдэж Улаанбаатар хотын зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллаж байна. 2009 оны эхэн үетэй харьцуулахад нийтийн тээврийн үйлчилгээний үндсэн чиглэлийн тоо 26 хувиар буюу 14 чиглэлээр, их багтаамжийн автобусны гаралтын тоо 192-оор буюу 46,4 хувиар нэмэгдэж 717-д хүрч парк шинэчлэлт 56 хувьд хүрсэн.

Москва хотын Тээвэр холбооны газар, нийслэлийн нийтийн Тээврийн газрын хамтын ажиллагааны гэрээний дагуу 2009, 2010 онд нийслэлийн төсвөөс 1.0 тэрбум төгрөг батлагдан 10 электробус угсран

үйлчилгээнд гаргаад байна. Азийн хөгжлийн банкинд "Цахилгаан тээврийг хөгжүүлэх төсөл"-ийг боловсруулан хүргүүлсэн.

Нийслэлийн төвийн 6 дүүрэгт автомашиныг шингэрүүлсэн нефтийн хийгээр цэнэглэгч станц байгуулах 5 газрын байршлыг Нийслэлийн Засаг даргын 2010.01.25 ны өдрийн 63 тоот захирамж гаргуулан шийдвэрлэсэн. Дээрх газруудыг дуудлага худалдаагаар оруулж "Дашваанжил" ХХК нь 3, "Газ промт" ХХК нь 2 газрыг худалдан авсан.

Хэрэгжилт –70%

117. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.13

Арга хэмжээ – 2.4.13.2 Нийтийн тээврийн үйлчилгээг хийн түлшээр ажилладаг 2000-с доошгүй таксигаар хангахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 200 ширхэг таксид шингэрүүлсэн нефтийн хийн төхөөрөмж суурилуулах ажлыг "Юнигаз" ХХК, "ББНА" ХХК –уудтай гэрээ байгуулан гүйцэтгэсэн.

Хийн түлшээр ажилладаг 2000 таксийг нийтийн тээврийн үйлчилгээнд оруулах ажил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2011 оноос хэрэгжиж эхэлнэ.

Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд шингэрүүлсэн нефть хийн төхөөрөмжийг суурилуулах ажлыг "Юнигаз", "Дашваанжил", "ББНА" ХХК –ууд гүйцэтгэж байна. Мөн "УБТТС" компаниас шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээ бүхий 1200 такси БНСУ-аас оруулахаар төсөл боловсруулан ЗТБХБЯамтай хамтран ажиллах гэрээг байгуулсан. Уг гэрээг үндэслэн УБТТС компанитай тус газартай хамтран ажиллах гэрээ байгуулан 2011 онд шинэ таксийг шугамын үйлчилгээнд гаргахаар бэлтгэж байна. "Сити", "Тэбэ сервис", "ЦББ", "Эс Кей-Эм" зэрэг 7 аж ахуйн нэгж байгууллагуудын 160 тээврийн хэрэгсэлд шингэрүүлсэн шатдаг хийн төхөөрөмж суурилуулсан.

"Биодизель" түлшний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор нийтийн тээврийн том оврын автобусны 15-20%-ийг, биодизель түлшний хольцтой дизель түлшээр хангахаар "Эн Би Эф" ХХК –тай хамтран ажиллахаар гэрээ байгуулан ажиллаж байна. Экологид ээлтэй, утаа бууруулагч "Биоэтанол" буюу "ЭКО" - 92" бензинийг автомашины хэрэглээнд нэвтрүүлэх, үйлдвэрлэлийг өргөжүүлэх зорилгоор "Оргил Ойл" ХХК- тай гэрээ байгуулан ажилласан бөгөөд 8 колонкоор дамжуулан 1000 тн түлш хэрэглээнд нэвтрүүлэн ажиллалаа.

Хэрэгжилт –50%

118. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.23

Арга хэмжээ – 2.4.23.1 Орчин үеийн тээвэр ложистикийн төв, терминал аж ахуйг Замын-Үүд, Алтанбулаг боомт, Улаанбаатар хот, бүсийн төвүүдэд барина.

Биелэлт: Нийслэлийн төвийн 6 дүүрэгт автомашиныг шингэрүүлсэн нефтийн хийгээр цэнэглэгч станц байгуулах 5 газрын байршлыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн. Дээрх газруудыг дуудлага худалдаагаар оруулж "Дашваанжил" ХХК нь 3, "Газ промт" ХХК нь 2 газрыг худалдан авсан.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Хонхор өртөө орчимд олон улсын ачаа тээврийн терминалын зориулалтаар 130 га газар эзэмшүүлэх шийдвэр гарсан.

Хэрэгжилт –50%

119. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.35

Арга хэмжээ – 2.4.35.2 Эрчим хүч хэмнэсэн эко-орон сууц барих шинэ технологийг нэвтрүүлнэ.

Биелэлт: Хан-Уул дүүргийн 9-р хорооны нутаг дэвсгэрт Германы Засгийн газрын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн хүрээнд туршилтын журмаар 2 давхар орон сууцны барилга барьсан бөгөөд 1 га газрыг баталгаажуулан өгч төслийг үргэлжлүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.

Хэрэгжилт –50%

120. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.35

Арга хэмжээ – 2.4.35.3 Олон нийтийн парк ногоон байгууламжийг байгуулна.

Биелэлт: Утаагүй Улаанбаатар хөтөлбөрт хотын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, тухайлбал Туул, Сэлбэ голын хөндий болон оршуулгын газруудыг ойжуулах, дүүрэг бүрт цэцэрлэгт хүрээлэн байгуулах, гудамж талбайд мод сөөг ихээр тарьж зүлэгжүүлэх асуудлыг тодорхой тусган БОАЖЯаманд хүргүүлээд байна.

Төвийн Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул, Баянгол, Сүхбаатар дүүрэгт 9 бичил цэцэрлэг, алсын Багануур, Багахангай, Налайх дүүрэгт тус бүр нэг бичил цэцэрлэг байгуулахаар төлөвлөн зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн хэдий ч Чингэлтэй дүүрэгт 400 сая төгрөгийн эрхийг

шилжүүлснээр бичил тохижилтыг хийх боломжгүй болсон. Иймд дүүргийн Засаг дарга нарт өөрсдийн хөрөнгөөр бичил цэцэрлэгүүдийг байгуулах үүрэг өгч тохижилтын ажлын зураг төсвийг Нийслэлийн Зураг төслийн хүрээлэнд захиалан хийлгэж дүүргүүдэд хүлээлгэн өгсөн. Үүний дагуу Баянгол дүүрэг 16 бичил цэцэрлэг, Баянзүрх дүүрэг 1 бичил цэцэрлэг, Налайх Багахангай, Багануур дүүргүүд тус бүр 1, Чингэлтэй дүүрэг 3 бичил цэцэрлэг, Сүхбаатар дүүрэг 2 бичил цэцэрлэгийг тус тус шинээр байгуулсан.

Мөн нийслэлийн хөрөнгө оруулалтаар Алдарт эх Норжмаагийн хөшөө, хөшөөний орчны тохижилт, Жанжин Д.Сүхбаатарын төрсөн гэрийн буйрыг тохижуулсан зэрэг бичил тохижилтуудын ажлууд хийлээ.

Хэрэгжилт –50%

121. Дэд бүлэг – 2.4

Зорилт – 2.4.35

Арга хэмжээ – 2.4.35.4 Барилга, орон сууцны хорооллууд, гудамж, талбайг цэцэрлэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг боловсруулна.

Биелэлт: “Шинэ Улаанбаатар- Ногоон нийслэл” хөтөлбөр боловсруулагдан ЗТБХБЯаманд хүргүүлсэн. Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх Монгол Улсын Засгийн газрын “Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрийг боловсруулахад оролцон саналаа өгч холбогдох газарт хүргүүлсэн.

Зайсан толгойн Танктай хөшөө орчимд 1300 мод, сөөг тариж, “Учрал хөшөө” орчмын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжуудыг сэргээн тохижуулан, Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт 58,3 га талбайд нөхөн сэргээлт хийж, 0.5-1,0 метрийн гүнтэй 18 газарт техникийн нөхөн сэргээлт хийж, ТЭЦ-4-ийн баруун урд талд 2 га талбайн хөрсөнд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж 1200 шар хуайс, 240 улиас, 900 хайлаас тарьж, Баянзүрх ууланд 270 га, Чингэлтэй ууланд 5 га газрыг ойжуулан, Япон улсын буцалтгүй тусламжийн хүрээнд “Нарангийн энгэр”-т шинэ төвлөрсөн хогийн цэг нээгдсэнээр Улаанчулуутын хогийн цэгийг хааж байгаатай холбогдуулан “Ландфилл” технологийн дагуу хог хаягдалыг дарж булан хөрсөөр хучиж газрыг эрүүлжүүлэн 19 га талбайн 1 га талбайд зүлэгжүүлэлт хийж 250 улиас мод, “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-д 111860 мод бут тарьж, 13 төрлийн 21420 мод сөөгний нөхөн тарилтын ажлууд хийгдлээ.

Хэрэгжилт –90%

2.5. Орон нутгийн хөгжлийн бодлого

122. Дэд бүлэг – 2.5

Зорилт – 2.5.9

Арга хэмжээ – 2.5.9.1 Сургуулийн дотуур байр, эмнэлэг, соёлын төвийг шинээр барих буюу өргөтгөж, засварлах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн салбарын нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлэг, заварын ажилтай холбоотой 32 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 30 төсөл арга хэмжээ бүрэн дууссан.

Нийслэлийн эрүүл мэндийн нэгдэл, төв, эмнэлэг, өрхийн эмнэлгүүдэд 5,6 тэрбум төгрөгийн засварын ажил хийгдсэн.

2010 оны 1 сард 1-р амаржих газарт нярайн халдвар гарсантай холбогдуулан шуурхай баг хуралдаж тус газарт өндөржүүлсэн бэлэн байдал зарлан ажиллалаа. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шаардлага нийцсэн эрх бүхий компанийг сонгон шууд гэрээ байгуулж ажиллалаа. Ажлын нэр төрөл, барилгын байршлаар 6 багц болгон, багц тус бүрт нэг гүйцэтгэгч сонгон 2010 оны 3-р сард засварын ажлыг эхлүүлсэн. Клиникийн нэгдүгээр амаржих газрын Бохирын шугам хоолойг засахад төсөвлөгдсөн 17,3 сая төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахаар шийдвэрлэсэн. 2010 оны 6-р сараас эхчүүдээ хүлээн авч эхэллээ.

Хан-Уул дүүрэгт баригдах 300 ортой 4 дүгээр амаржих газрын барилгын зураг төслийн талаарх саналаа ЭМЯ-ны Барилга захиалагчийн газарт хүргүүлсэн бөгөөд зургийн ажил бэлэн болсон.

“Тогтвортой амжиргаа-2” төслийн 9,2 сая төгрөгийн санхүүжилтээр Багахангай дүүргийн Соёлын төвийн барилгын тохижилт, Багануур дүүргийн соёлын төвд 27 сая төгрөгийн санхүүжилтээр үзэгчдийн танхимын сандлыг бүрэн шинэчилж, УИХ-ын гишүүн Ц.Батбаярын дэмжлэгтэйгээр Налайх дүүргийн Соёлын төвд 10 сая төгрөгийн техник хэрэгсэл олгож, Хануул дүүргийн дүүргийн соёлын төвийн барилгад эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 180 сая төгрөгийн барилгын засвар, орон нутгийн төсвөөс 18 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн ажлууд хийгдсэн.

Хэрэгжилт –70%

Бүлэг – Гурав. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТЭНЦВЭРТ ХАРЬЦААГ ХАНГАХ ЗОРИЛТ

123. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.2

Арга хэмжээ – 3.2.1 Агаарын бохирдлыг бууруулах чанарыг хангах эрх зүйн орчныг шинэчилж, агаарын бохирдлыг бууруулах талаар хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Ерөнхий сайдын 2010 оны 6 дугаар захирамжаар “Утаагүй Улаанбаатар” үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулах үүрэг бүхий 6 ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Уг ажлын хэсэг нь “Утаагүй Улаанбаатар” үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар оруулж хэлэлцүүлж, УИХ-д өргөн барьсан нь УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот үндэсний хөтөлбөр болж батлагдан гарсан. Энэүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдаад байна.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чадавхийг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлж эхэлээд байна.

Хэрэгжилт –90%

124. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.2

Арга хэмжээ – 3.2.2 Ногоон байгууламжийн төлөвлөлт, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.

Биелэлт: Ногоон байгууламжийн арчилгааны ажлын менежментийг сайжруулах, арчилгааг хариуцдаг мэргэжлийн байгууллагыг байгуулах зорилгоор Цэцэрлэгжилтийн албыг Нийслэлийн Хот тохижилтын газрын дэргэд шинээр байгуулах асуудлыг судлан боловсруулж, уг асуудлыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Хот тохижилтын газрын дэргэд ногоон байгууламжийн албыг 2011 онд байгуулахаар шийдвэрлэн хөрөнгө санхүүжилтийн асуудлыг тусгуулаад байна.

Хот, нийтийн эзэмшлийн гудамж, талбай, орон сууц, гэр хорооллыг цэцэрлэгжүүлэх ажлыг тодорхой төлөвлөгөө, зохион байгуулалттай хийх талаар анхааран ажиллаж байна. Арчилгааны асуудал дээр илүү анхааран 10-р сар хүртэл хугацаанд нийслэлийн Хот, тохижилтын газар болон дүүргүүдийн тохижилт үйлчилгээний компаниудыг үнэгүй усаар ханган батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу услалтын ажлыг хийсэн.

Байгууллага, аж ахуйн нэгжүүдийг нийтийн эзэмшлийн хуваарьт талбайгаа арчлан, жил бүрийн төсөвтөө арчилгааны зардлыг тусгадаг болгох, мэргэжлийн байгууллагуудад гудамж талбайг хариуцуулан ажиллуулдаг болох зэрэг менежментийн дорвитой өөрчлөлтүүд хийх талаар Нийслэлийн Засаг даргын албан даалгаврын дагуу Худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагуудад гадна тохижилт, цэвэрлэгээг сайжруулах заалт оруулж, үзэж шалган гадна хаяг, реклам, гэрэлтүүлэг, зүлэг, явган зам, фасадны өнгө үзэмж зэргийг сайжруулах ажлыг хийж байна.

“Сайхан хот–Сайхан амьдрал” тохижилтын болзолт уралдааныг дүүрэг, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хот тохижилтын ажилд идэвхитэй оролцуулахаар зарлан зохион байгуулж болзолт уралдааны хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбайг үлгэр жишээ тохижуулсан 2 дүүрэг, өөрсдийн гаднах орчноо үлгэр жишээ тохижуулсан 20 гаруй аж ахуйн нэгж байгууллага, хашаандаа үлгэр жишээ тохижилт хийсэн 8 иргэнийг тус тус шалгаруулан нийслэлийн Засаг даргын нэрэмжит шагналаар шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулсан.

Хэрэгжилт –70%

125. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.2

Арга хэмжээ – 3.2.3 Ахуйн зориулалтаар түлшинд ашиглах түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах арга хэмжээ авна.

Биелэлт: Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай Нийслэлийн Засаг даргын захирамжаар Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 12 хороонд боловсруулсан түлш нийлүүлэх ажил хийгдэж байна. Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 12 хороонд боловсруулсан түлш нийлүүлэх ажлыг хороодод түлш нийлүүлэх болон түлш нөөцлөх гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. 3 дүүргийн 12 хороонд нийт 77 цэгээр дамжуулан үртсэн шахмал түлш 1770 тн, нүүрсэн шахмал түлш 3265 тн, хагас коксон түлш 20 тн нийлүүлэгдээд байна.

Хэрэгжилт –50%

126. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.2

Арга хэмжээ – 3.2.4 Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас агаарт гаргах тоосонцорын хаягдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт : Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа асфальтын болон тоосгоны үйлдвэрүүд, элс хайрганы карьерын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас агаарт гарах тоосонцорын хаягдлыг бууруулах зорилгоор Нийслэлийн хэрэгжүүлэгч 5 агентлаг, “Монголын Байгаль эхийн аврал сан”, “Хан хэнтийн аав, хатан онон ээжийг хамгаалах холбоо” ТББ-уудтай хамтран нийслэлийн 9 дүүрэгт хяналт шалгалтын ажлыг хийж зохион байгуулж 6 тоосгоны үйлдвэрүүдэд хэмжилт, шалтгалтын ажлыг гүйцэтгээд байна.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд суурин болон хөдөлгөөнт эх үүсвэрүүдийн хаягдал хийн хэмжээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас агаарт гаргах тоосонцорын хаягдлын хэмжээг тогтоох, яндангийн байрлал, ажиллах хэлбэр, түлшний хэрэглээ одоо байгаа үнс баригчийн Ашигт үйлийн кофецентийг тодорхойлох, мэдээллийн сан бүрдүүлэх, агаарын бохирдлыг бууруулах чадавхийг сайжруулах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Хэрэгжилт –50%

127. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.3

Арга хэмжээ – 3.3.1 Аюултай хог, хаягдлыг устгах, хяналт тавих зориулалтын байгууламж бүхий төвлөрсөн цэгийг Улаанбаатар хотод байгуулна.

Биелэлт : Улаанбаатар хотын хөрс усны бохирдлын талаар хийгдсэн судалгаануудыг нэгтгэх ажил хийгдэж байна. Мөн нийслэлийн нутаг дэвсгэрт химийн бодис импортлогч, худалдаалагч, ашиглагч аж ахуйн нэгж, иргэдэд хяналт тавих шалгалтыг холбогдох байгууллагуудтай хамтарч хийн гарсан зөрчлийг арилгуулж, холбогдох санал дүгнэлтийг боловсруулж БОАЖЯ-ны сайдын зөвлөлд танилцуулсан.

Эмнэлгийн болон тусгай хог хаягдлын зориулалтын цэг байгуулах ажлын хүрээнд Нарангийн энгэрийн төвлөрсөн цэгт зориулалтын 274м² байгууламжийг бүрэн ашиглалтанд оруулан, Эрүүл мэндийн сайдын багцаас 400.0 сая төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн хог хаягдал устгах тоног төхөөрөмж суурилуулан ажилуулж байна. Тус цэг нь нийслэлд үйл ажиллагаа явуулдаг 300 гаруй эмнэлгийн байгууллагуудтай гэрээ байгуулж эмнэлгийн хог хаягдлыг хуваарь гарган цуглуулж, 497,2 тн эмнэлгийн хог хаягдлыг хүлээн авч устгах үйл ажиллагааг явуулсан.

Химийн хортой болон аюултай хог хаягдлын цэгийн ТЭЗҮ боловсруулах олон улсын тендерийг БОАЖЯ-тай хамтран зохион байгуулж Унгар улсын “Корнезет” компани шалгаран химийн хортой болон аюултай хог хаягдал хаях цэг байгуулах ажлын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан. Химийн хортой болон аюултай хог хаягдал хаях цэгийг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт барихаар төлөвлөөд байгаа бөгөөд байгууламжийг барих хөрөнгийн асуудлыг “Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөр”-ийн хүрээнд шийдвэрлүүлэх саналаа өгөөд байна.

Хэрэгжилт –70%

128. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.3

Арга хэмжээ – 3.3.2 Томоохон хот суурин газрын цэвэрлэх байгууламжид техник технологийн шинэчлэлт хийж, ашиглалтыг сайжруулан стандартын шаардлагад нийцсэн усыг байгальд нийлүүлэх

Биелэлт: 2010 оны 2-р сарын 8-аас 25-ны өдрүүдэд Екобиоблок үйлдвэрлэгчийн мэргэжилтэнүүдтэй хамтран Төв цэвэрлэх байгууламжийн албаны задлах лабораторид туршилт судалгааг хийж гүйцэтгэн, судалгааны дүнг Япон улс руу хүргүүлсэн. Биопрудын өндөржилт зураг схемийг шинээр хийлгэж ОХУ-ын “Сибгипрокоммунводканал” компанид явуулсан. Лаг усгүйжүүлэх технологи нэвтрүүлж, аэротенкэд 500 ширхэг дифузер суурилуулсан. Мөн хэт ягаан туяагаар халдваргүйжүүлэх төхөөрөмжийг ашиглалтанд оруулсан.

Төв цэвэрлэх байгууламжийн хуучин ашиглаж байсан 2 ширхэг Ф28 тунгаагуурыг Испани улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжсэн төслийн хүрээнд лаг нягтруулагч болгон тоноглож, лаг нягтруулагчийг битүүмжлэх, үнэргүйжүүлэх төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж дууссан.

Урьдчилан цэвэрлэх байгууламж НӨҮГазрыг Нийслэлийн засгийн даргын захирамжаар байгуулж тоног төхөөрөмжийн их засвар, техник технологийн шинэчлэлтийн ажлыг эхлүүлсэн. Үүнд: Сульфид болон хромын шугамнуудад засвар үйлчилгээ хийж шинээр 200м шугам хоолой хэсэгчлэн сольсон. 04,06,08 дугаар станцуудын резервуарт засвар үйлчилгээ, элс баригч, цацраг тунгаагууруудад их засварын ажил хийгдсэн. Мөн хэвтээ тунгаагууруудад засвар үйлчилгээний ажлыг хийж байна.

Хэрэгжилт –50%

129. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.3

Арга хэмжээ – 3.3.9 Туул голын Улаанбаатар хотын дэргэдүүр урсдаг хэсгийг бохирдлоос хамгаалах, экологийн байдлыг сэргээх, голын усны горимыг зохицуулах замаар эргийн дагуу хот төлөвлөлтийн орчин үеийн шаардлагад нийцсэн хамгаалалт, инженерийн байгууламж барих боломжийг судалж хэрэгжүүлнэ.

Биелэлт: Туул голын ариун цэврийн хамгаалалтын гадаад дотоод мужийг шинэчлэн тогтоосон. Ус хангамжийн ариун цэврийн зоныг дотоодын цэргийн 805 дугаар анги иж бүрдлээр нь хамгаалалтанд авсан.

Хамгаалалтын хашлагын тендер зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулан Баянзүрхийн гүүрнээс Баянзүрхийн товчоо хүртэл замын 2 талаар болон Махын станцын 8 дугаар худгийн урдуур нийт 2 км хашлага угсарсан. Уг ажилд нийт 90.5 сая төгрөг зарцуулсан. Усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс дотор суурьшсан аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж тухайн газраа үйл ажиллагаа явуулаагүй газрын газар эзэмших эрхийг цуцлах тухай нийслэлийн Засаг даргын захирамжаар 165 иргэн аж ахуйн нэгж, байгууллагуудын газар эзэмших ашиглах эрхийг хүчингүй болгосон.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-гийн ТЭЗҮ-г боловсруулах олон улсын зөвлөх үйлчилгээний тендер зохион байгуулах гүйцэтгэгчээр Япон улсын “Art & Architects Network” компани шалгарч төслийг хэрэгжүүлж байна. Төслийн багаас дунд шатны тайлангаа НИТХ, нийслэлийн удирдлагуудад танилцуулсан. Захирагчийн ажлын албатай гэрээ байгуулсан 44 аж ахуйн нэгж, байгууллагын талбайд тарьсан мод, бут сөөгийг тоолох ажлыг Ойн газар, Эрдэмтэдийн зөвлөлийн төлөөллийг оролцуулан гүйцэтгэлээ. Тооллогын дүнгээр 111860 мод бут тарьж, стандартын шаардлага хангаагүй, модны нэр төрөл сольсон, ургаагүй үхсэн болон тарилт хийгээгүй шалтгаанаар 141693 мод бутыг нөхөн тариулахаар болсон. Гэрээг дүгнэж 85 хувиас дээш ургалттай 15 байгууллагад санхүүжилт олгосон. Мөн НҮБ-ын Байгаль хамгаалах хөтөлбөрийн Солонгос улс дахь хорооны санхүүжилтээр хүрээлэнд нэрэмжит төгөл байгуулах гэрээ байгуулан 16,3 га талбайд 15 мянган долларын хөрөнгө оруулалтаар 4326 мод бут, сөөг тарисан.

Туул голыг хамгаалах ажлын хүрээнд “Хатан Туул ба цаг хугацаа” 2 сарын аяныг Ногоон суваг ТББ-тай хамтран зохион байгуулж Гачууртын Хар усан тохойгоос Баянзүрхийн гүүр, Баянзүрхийн гүүрнээс Маршалын гүүр, Маршалын гүүрнээс Яармагийн гүүр, Яармагийн гүүрнээс Сонсголонгийн гүүр, Сонсголонгийн гүүрнээс Сонгины булан хүртэл 5 газарт пост байгуулсан. Баянзүрхийн гүүрний орчимд Туул голын эрэгт аяны явцын талаар хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, аяны нэгдүгээр шатны ажлаа дүгнэж, дараагийн шатны хэрэгжүүлэх ажлын бодлогоо тодорхойлсон.

Хэрэгжилт –50%

130. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.4

Арга хэмжээ – 3.4.2 Бүх аймгуудын хатуу хог хаягдлын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.

Биелэлт: Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд 2004-2008 оны хугацаанд Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах 2020 он хүртлэх мастер төлөвлөгөөг боловсруулсан. Мастер төлөвлөгөөний хүрээнд 10 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар 52 хог тээврийн зориулалттай машин техник, төвлөрсөн цэг дээр ажиллах хүнд машин механизмыг олгосон.

2009 оны 10 дугаар сараас эхлэн Жайка байгууллагаас 3 сая долларын хөрөнгө оруулалттайгаар Техник хамтын ажиллагааны төслийг 3 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлнэ. Техник хамтын ажиллагааны төслийн 2 дугаар үе шатыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт Хог хаягдлыг гар аргаар болон конвеороор ангилан ялгах цехийн байгууламжийг барьж байгуулсан бөгөөд гар аргаар ангилан ялгах талбай дээр хог хаягдал ангилан ялагч туршилтын төслийг хэрэгжүүлсэн. Конвейороор ангилан ялгах туршилтын төслийг 2011 оны 2-р улирлаас эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Мөн Баянзүрх дүүргийн 1, 7-р хороо, Сүхбаатар дүүргийн 5, 7-р хорооны 5000 өрхийн дунд хог хаягдлыг анхан шатанд ангилан ялгах, хог хаягдлыг зүй зохистой хаях дадлыг иргэдэд бий болгох, хог хаягдлыг анхан шатанд ангилах туршилтын төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү туршилтын төслийн хамрах хүрээг өргөжүүлэх зорилгоор нэмж 4 хороог сонгосон. Үүнд: Баянзүрх дүүргийн 15, Баянгол дүүргийн 3, Чингэлтэй дүүргийн 4, Хан Уул дүүргийн 2 дугаар хороог тус тус сонгож бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Техник хамтын ажиллагааны төслийн 2-р үе шатанд туршилтын төсөл хэрэгжүүлж байгаа хороод дээр хог тээвэрлэлт, цуглуулалтын үйл ажиллагааны зураг авалтын судалгаа, электрон хог хаягдлын судалгаа, хог хаягдлын хэмжээ тогтоох судалгаа, боловсон хүчний чадавхийг тогтоох судалгаа зэргийг хийж гүйцэтгэсэн бөгөөд хог хаягдлын бүтцийн судалгааг 2011 оны 1-р сард хийхээр төлөвлөж байгаа бөгөөд мөн хогийн цэгийн мэдээллийн баазыг шинэчлэх ажлыг хийж гүйцэтэж байна.

Хэрэгжилт –50%

131. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.4

Арга хэмжээ – 3.4.4 Бүсийн тулгуур төв хотуудад хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулах, томоохон хот суурин газрын хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулж, хог хаягдлыг булшлах ландфилын аргыг нэвтрүүлнэ.

Биелэлт : БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны KOICA байгууллагатай “Улаанбаатар хотод хатуу хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах” төслийг хэрэгжүүлэхээр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж Монгол улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар нийтдээ 3,5 сая америк долларын төслийг хэрэгжүүлэх нот бичигт гарын үсэг зурсан. Энэ төслийн хүрээнд RPF буюу өндөр даралтын зууханд шатаах зориулалт бүхий хог хаягдлаар хийсэн хатуу түлшний үйлдвэр барих ажлыг 20 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ.

ТЭЗҮ-г KOICA байгууллагатай хамтран боловсруулахаар төлөвлөж байгаа бөгөөд ТЭЗҮ-г сонгон шалгаруулах ажлыг 6-р сараас эхлэн 3 сарын дотор хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж 50 хувьтай хэрэгжсэн.

Япон улсын техникийн хамтын ажиллагааны төслийн эхний үе шат 2009 оны 1-р улиралд бүрэн хэрэгжиж СХД-ийн 4-р хорооны нутаг дэвсгэр Нарангийн энгэрт 2020 он хүртэл ашиглах төлөвлөлттэй 19 нэр төрлийн барилга байгууламж бүхий шинэ хогийн цэг байгуулсан. Шинэ хогийн цэгийг 3,5 сая америк долларын өртгөөр байгуулан Монголын талд хүлээлгэн өгсөн. Шинэ хогийн цэгт 2,1 км урт хатуу хүчилттай зам, 60 см диаметртэй метан хий зайлуулах 16 ш хоолой, бохир шингэн цуглуулах сан, 2,4 км урт гадна хамгаалалтын хашаа, 2,2 км урт дотор талын хашаа, хяналтын байр, Автопүү, нийтийн бие засах газар, оффисын барилга, авто граж зэргийг нийт 19 нэр төрлийн барилга байгууламжийг барьж байгуулсан. Хогийн цэгийг ашиглалтанд хүлээж авах бэлтгэл ажлын хүрээнд хог хүлээн авч, ландфил технологи хийх зохион байгуулалтын диаграм, авто замын тэмдэг тэмдэглэгээ, бүртгэлийн шинэ програм зэргийг хийж гүйцэтгэсэн. Метан хий зайлуулах 13 хоолойг сунгаж өндөрлөсөн. Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэг 2009 оны 04 дүгээр сарын 29-ээс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхлээд байгаа бөгөөд хөрсөөр хучих үйл ажиллагааг Ландфил технологийн дагуу өдөр бүр хийж гүйцэтгэж байна. 2009 оны байдлаар Нарангийн энгэрийн хогийн цэгт ирсэн 288290,35 тонн хог хаягдлыг өдөр бүр 10 тонны 3 машинаар 6085 рейс хийж, 60850 тонн шороогоор хог хаягдлыг дарж булсан.

Шинэ хогийн цэгийн үйл ажиллагааны нэг онцлог нь өдөрт ирсэн хогийг тухайн өдөрт нь "Ландфилл" технологийн дагуу дарж булан хөрсөөр хучдаг. Энэ нь хог хаягдал салхиар тархан хийсэх, гал гарах зэрэг байгаль орчинд болон оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хор нөлөөг багасгах юм.

Хэрэгжилт –50%

132. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.5

Арга хэмжээ – 3.5.2 Гол мөрний сав газрын зөвлөлүүдийг байгуулан ажиллуулж, сав газрын усны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас зохион байгуулсан “Туул голын сав газрын усны нэгдсэн менежмент” зөвлөлдөх уулзалтаар Туул голын сав газрын зөвлөлийг байгуулахтай холбогдуулан Улаанбаатар хотоос 9, Төв аймгаас 6, Булган аймгаас 1, Сэлэнгэ аймгаас 1 төлөөлөлтэй нийт 17 төлөөлөгч оруулахаар тогтож, зөвлөл орон нутгийн төр захиргааны байгууллагаас 4, төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэдийн 5 төлөөлөл оруулахаар санал гаргасаны дагуу БОАЖ-ын сайдын тушаалаар Туул голын сав газрын зөвлөлийг 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Усны газар, “Монгол оронд усны нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх” төслийн газартай хамтран уулзалт ярилцлагыг зохион байгуулж, Туул голын сав газрын зөвлөлийн дүрмийн төсөл, 2010-2011 онд хийх ажлын төлөвлөгөөний төслийг хэлэлцсэн. Төлөвлөгөө батлагдах шатандаа байна.

Хэрэгжилт –50%

133. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.5

Арга хэмжээ – 3.5.10 Усан сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг шинэчлэн тогтоож дэглэмийг мөрдүүлнэ.

Биелэлт : Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг тогтоох талаар дүгнэлт гаргах, газар доорхи ус ашигладаг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тооллого, бүртгэлийг хийж, судалгаа гаргах, “Усны тухай”, “Ус рашаан ашигласны төлбөрийн тухай” бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах, илэрсэн зөрчлийг арилгах зорилгоор Усны газартай хамтран санхүүжүүлж, удирдамж батлан тооллого судалгааны ажлыг 1 сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн. Судалгаагаар нийслэлийн хэмжээнд гүний 1611 худаг тоологдсон. УМХГ, Усны газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Монголын Байгаль орчин иргэний зөвлөл, 9 дүүрэг, Ус сувгийн

удирдах газар, нийслэлийн Байгаль хамгаалах газар хамтран Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс”-ийг тогтоох координатжуулан дүгнэлт гаргаж дүүргүүдийн Засаг даргын захирамжаар баталгаажууллаа.

Хэрэгжилт –90%

Дэд бүлэг – 3

Зорилт – 3.14

Арга хэмжээ – 3.14.2 Орон нутгаас тусгай хамгаалалтанд авах газар нутгийн шалгуур үзүүлэлт, үндэслэлийг шинэчлэн тогтоож, бүртгэл, тооцоог улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн сүлжээнд хамруулна.

Биелэлт: 2010 онд улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газар байхгүй болно.

134. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.14

Арга хэмжээ – 3.14.8 Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны төлөв, байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гарган тухайн газрын онцлог, нөөц, даацад тохируулан аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах арга зүйг боловсруулан мөрдүүлнэ.

Биелэлт: БОАЖЯам, нийслэлийн Засаг даргын хамтран ажиллах санамж бичигт тус ажлын хүрээнд хийх ажлын саналыг БОАЖЯаманд хүргүүлсэн. Их тэнгэрийн амны зүүн хажуугийн элгэн хадны зургийг сэргээх ажлыг хийсэн.

Хэрэгжилт –50%

135. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.15

Арга хэмжээ – 3.15.4 Нэн тэргүүнд ойжуулах, нөхөн сэргээх шаардлагатай газрыг тодорхойлж нийтэд зарлан, жилд 10.0 мянган га-аас доошгүй талбайг ойжуулж, нөхөн сэргээнэ.

Биелэлт: Нийслэлийн ногоон бүс Туул голын сав газар Улиастайн ам, Гүнжийн хоолой, Шар хоолойд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 100.0 га талбайд ойн нөхөн сэргээлтийн ажлыг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянзүрх ууланд 270.0 га талбайд ойжуулалтын ажлыг тус тус хийж ойжуулалтын ажилд нийслэл, дүүргээс хамгаалалтанд анхаарч 4750 метр хашаа барьж хамгаалсан.

Мөн нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо Сэлбэ голын дагуу 25,0 га газарт ойжуулалтыг “Баянзүрх эмэгтэйчүүд хөгжил төв” төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн ба намрын тооллогоор ургамлын амьдралтын хувь 76.1 хувьтай байна. Сэлбэ голын сав газарт 16.0 га талбайг хашиж хайсан хашаа барьж хамгаалан 2000 гаруй мод бут сөөг тарьсан.

Хотын агаарын бохирдлыг бууруулж чанарыг сайжруулах, тоосжилтыг багасгах, иргэдийн ажиллаж амьдрах ая тухтай нөхцлийг дээшлүүлэх үүднээс хотод тарих мод, сөөгний тоо хэмжээг нэмэгдүүлэх бодлого барин ажиллаж нийслэлийн хэмжээнд 285,190 м/кв талбайг зүлэгжүүлэн, 1.100.411 мод, 499.222 сөөг шинээр тарьж, 33,742 м/кв талбайд цэцгийн мандал байгуулсанаар нийт зүлэгжүүлсэн талбай 1.295.249 м/кв буюу өмнөх оноос ногоон байгууламжийн хэмжээ 22 хувиар нэмэгдсэн. 2010 онд Нийслэлийн хэмжээнд нийт цэцэрлэгжүүлсэн талбай /ойжуулалт ороод/ 467 га, ногоон бүсийн ойн сангийн талбайн хэмжээг 395.0 га нэмэгдүүлсэн. Ингэснээр нэг хүнд ногдох ногоон байгууламж 5.7 м/кв буюу 4,6 хувь болж байна. Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хийсэн талбайд нийт 7086 уртааш метр хамгаалалтын хашаа барьсан нь хамгаалалтанд анхаарсан чухал ажил болсон.

Хэрэгжилт –90%

136. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.15

Арга хэмжээ – 3.15.9 Хууль бусаар мод бэлтгэхтэй тэмцэх, хянах үйл ажиллагааг орчин үеийн технологи ашиглан боловсронгуй болгож, орон нутгийн ойн байгууллага болон нутгийн иргэдийн оролцоонд түшиглэн тэмцэнэ.

Биелэлт: Хууль бусаар мод бэлтгэлтэй тэмцэх, хянах үйл ажиллагааг орон нутгийн ойн байгууллага болон нутгийн иргэдийн оролцоонд түшиглэн зохион байгуулах менежментийг түлхүү анхааран ажиллаж, нийслэлийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа 7 нөхөрлөлийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

Нутгийн иргэдэд оролцоонд түшиглэн ногоон бүсэд оршин суугч **20** хүнийг ажлын түр байраар ханган идэвхтэн байгаль хамгаалагчаар, 36 урамшуулалт морин эргүүлийг 4 сарын хугацаанд ажиллуулж хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр ой хээрийн түймэр гаргаагүй бөгөөд хууль бусаар мод бэлтгэлийн ажил 2 дахин багасч, нойтон мод огтолдог үйл ажиллагааг таслан зогсоож чадсан гэсэн үнэлэлтийг Ойн газар, МХЕГазраас өглөө.

Байгаль хамгаалагч нар 4200 удаагийн үзлэг шалгалтыг хийж, 620 зөрчил илрүүлэн, торгууль, нөхөн төлбөр, гоожингийн борлуулалтын орлогоор нийт 86.0 сая төгрөг Нийслэлийн төсөвт төвлөрүүлээд байна. Нийслэлийн Байгаль хамгаалах газрын цагдаагийн гэрээт ажилтан болон улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хамтран 22 удаагийн үзлэг шалгалтыг хийлээ.

Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 7 мотоцикл нутаг дэвсгэр томтой, унаагүй байгаль хамгаалагчдад олгосон. Ойн сан бүхий газрыг гэрээгээр эзэмших, хамгаалах, зүй зохистой ашиглуулах, нөхөн сэргээх, хууль бусаар мод бэлтгэгчидтэй тэмцэх зорилгоор иргэдийн нөхөрлөлүүд, байгаль хамгаалагчдыг оролцуулан сургалт зохион байгууллаа.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан байнгийн удирдамжийн дагуу орон нутгаас орж ирж байгаа мод, модон материалд, ногоон бүсэд хамтарсан 250 удаагийн шалгалт хийж 190 зөрчил илрүүлж зөрчил бүхий иргэн, аж ахуй нэгжид 14.330.000 төгрөгийн торгууль ногдуулж 240 нарсан палк, 516 шургааг, 54.5 м3 түлээ, 1357 шуудайлсан түлээ хурааж улсын орлого болгож, 48.901.500 төгрөгийн мод модон материалыг захиргааны журмаар хурааж, 50 акт, 3 албан шаардлага, 11 дүгнэлт хүргүүлэн ажилласан.

Ойгоос хууль бусаар мод бэлтгэх ажиллагааг таслан зогсоохын тулд ойн нөхөрлөлийг олноор байгуулж иргэдийг, үүсгэл санаачилгыг дэмжиж, хариуцсан талбайн хил кординатыг JPS-ээр зурган мэдээлэл явуулж сургахад Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэг, Ойн газар, МХЕГ-аас зохион явуулсан байгалийн нөөцийн тогтвортой менежментийн багтай хамтран ажилласан.

“Нийслэл хотод баригдаж байгаа барилгын хэв хашмалын тулаасанд залуу мод хэрэглэж байгаа байдалд хяналт хийх” удирдамжийн дагуу шалгалтыг Нийслэлийн бүх дүүргийн нутаг дэвсгэрт барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа орон сууцны нэг давхрын өргөтгөлөөс авахуулаад орчин үеийн орон сууцны болон үйлчилгээний зориулалттай ихэнх барилгад хийсэн.

Хэрэгжилт –50%

137. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.16

Арга хэмжээ – 3.16.4 Ховордсон амьтныг хамгаалах ажлыг сайжруулж, мазаалай, баавгай, хавтгай, тэмээ, баданга, хүдэр, монгол бөхөн, буган цаа, голын халиу, хар мөрний хилэм зэрэг нэн ховор амьтдыг идээшил нутагт нь өсгөн үржүүлэх, тэдгээрийн генийн санг хамгаалахад био технологийн ололтыг ашиглана.

Биелэлт: Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутга дэвсгэр Шар хоолойн аманд Уламжлалт анагаах ухаан, эрдэм шинжилгээний корпораци эрдэм шинжилгээний зориулалтаар 13 хүдэр, Улиастайн Баянголын аманд “Гео Транс” ХХК 3 буга өсгөн үржүүлж байна. Цаашид ховордсон ан, амьтдыг хамгаалах нөхөн үржүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг дэмжин ажиллах чиглэл баримталж байна.

Хэрэгжилт –50%

138. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.17

Арга хэмжээ – 3.17.3 Газрын нэгдмэл сангийн тайлангийн өгөгдлүүдийг боловсронгуй болгох түүнд газрын ангилалын шилжилт хөдөлгөөнийг байнга тусгах, байгаль орчны даац, чадавхид нийцүүлсэн газар зохион байгуулалтын урт хугацааны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Нийслэлийн газрын үнэлгээний бүсчлэлийг шинэчлэн тогтоох /7 бүс/, захын дүүргүүдэд хүнсний ногоо, малын тэжээл тариалах зориулалтаар олгосон газрыг төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх, “Газрын тухай” болон холбогдох хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх тухай санал боловсруулж, НИТХ-д оруулж дэмжигдсэн.

Газрын нэгдмэл сан нь шинэчилэн найруулсан Монгол улсын Газрын тухай хуулийн 10-р зүйлд заасны дагуу үндсэн 6 санд хуваагдаж байгаа бөгөөд ангилал тус бүрийн нийт газарт эзлэх хэмжээ, хувийг гаргаж тайланд тусгасан. Нийслэлийн газрын нэгдмэл сан нийт 470444 га байна. Үүнээс хөдөө аж ахуйн газар 261634.3 га буюу 55.6 хувь, хот тосгон бусад суурины газар 45337.9 га буюу 9.6 хувь, зам шугам сүлжээний газар 5691.3 га буюу 1.2 хувь, ойн сан бүхий газар 77046.6 га буюу 16.4 хувь, усны сан бүхий газар 4078.1 га буюу 0.9 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 76655.3 га буюу 16.3 хувийг тус тус эзэлж байна.

Нийслэлийн газрын албаны 2009 оны кадастрын улсын бүртгэлд үндэслэн энэхүү тайланг өмчлөл, эзэмшил, ашиглалтанд байгаа газрын хэмжээгээр гаргасан бөгөөд нийт 470444 га газраас иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилсөн 4624.16 га, иргэний гэр хорооллын болон аж ахуйн зориулалттай эзэмшилд 8976.18177 га газраас гэр хорооллыг зориулалтаар 4458.64 га, төрийн байгууллагын эзэмшилд 15218.3597 га, аж ахуйн нэгжийн эзэмшилд 18416.98 га, бусдын эзэмшиж буй газрыг ашиглагч Монгол улсын аж ахуйн нэгжийн 1222.38 га, гадаадын иргэн болон харьяалалгүй хүний

ашиглалтанд 31.5 га, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж, гадаадын хуулийн этгээдийн ашиглалтанд 797.3531 га, хөдөө аж ахуйн эзэмшил ашиглалтанд 6089.7089 га, хот тосгон бусад суурины газрын эзэмшил, ашиглалтанд 30479.856 га, зам шугам шүлжээний газрын эзэмшил ашиглалтанд 845.31 га, ойн сан бүхий газрын эзэмшил ашиглалтанд 756.33 га, улсын тусгай хэрэгцээний газрын эзэмшил ашиглалтанд 10431 га тус тус байна.

Хэрэгжилт –50%

139. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.17

Арга хэмжээ – 3.17.5 Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр дамжуулан байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Биелэлт : Нийслэлийн ногоон бүс Туул голын сав газар Улиастайн ам, Гүнжийн хоолой, Шар хоолойд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 100.0 га талбайд ойн нөхөн сэргээлтийн ажлыг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянзүрх ууланд 270.0 га талбайд ойжуулалтын ажлыг тус тус хийж ойжуулалтын ажилд нийслэл, дүүргээс хамгаалалтанд анхаарч 4750 метр хашаа барьж хамгаалсан.

Мөн нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо Сэлбэ голын дагуу 25,0 га газарт ойжуулалтын ажлыг “Баянзүрх эмэгтэйчүүд хөгжил төв” төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн ба намрын тооллогоор ургамлын амьдралтын хувь 76.1 хувьтай байна. Сэлбэ голын сав газарт 16.0 га талбайг хашиж хайсан хашаа барьж хамгаалан 2000 гаруй мод бут сөөг тарьсан.

Хэрэгжилт –50%

140. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.18

Арга хэмжээ – 3.18.2 Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр” боловсруулж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: Үндэсний хөтөлбөр батлагдаагүй байна. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Жуулчдын гудамжинд “Гар урлалын төв” байгуулсан.

Хэрэгжилт –50%

141. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.18

Арга хэмжээ – 3.18.3.” Аялал жуулчлалын марктенгийн стратеги төлөвлөгөө” боловсруулж, Монгол Улсыг нэгдсэн бодлоготойгоор гадаадад сурталчлах ажлыг зохион байгуулна.

Биелэлт: “Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгаа, маркетинг 2010-2013” төлөвлөгөө гарган ажилласан. Улаанбаатар хотын аялал жуулчлалын бэлэгдэл, урианы уралдаан зохион байгуулж шалгаруулсан.

Аялал жуулчлал, спортын салбарт хамтарч ажиллахаар Эстони Улсын Маарду хоттой, соёл урлаг, аялал жуулчлалын салбарт хамтарч ажиллахаар Итали Улсын Милан хоттой хамтын ажиллагааны гэрээ тус тус байгуулсан. 2011 оны 6 дугаар сард Милан хотын Соёлын өдрүүдийг Улаанбаатар хотноо зохион байгуулна.

Жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжүүдийг оролцуулсан “Монголд үйлдвэрлэл” үзэсгэлэн худалдааг ОХУ-ын Улаан-Үд, Эрхүү хотноо, “Улаанбаатарын соёлын өдрүүд” арга хэмжээг БНУУ-ын Будапешт хотноо тус тус зохион байгуулсан.

Мөн жуулчны улирлын үеэр Улаанбаатар хотын аялал жуулчлалын төлөв байдал болон хотын аялал жуулчлалаас орж байгаа эдийн засгийн үр өгөөжийг олж тогтоох судалгааг 5 хэл дээр нийт 1500 гаруй жуулчдаас авсан. Судалгааны мэдээллийн боловсруулалт хийгдэж анхан шатны дүн гарсан.

Улаанбаатар хотын аялал жуулчлалын тухай “UB guide book – 2010/11” жуулчидад зориулсан хөтөч ном, Улаанбаатар хотын тухай сурталчилгааны DVD киног тус тус эрхлэн гаргасан.

Хэрэгжилт –50%

142. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.18

Арга хэмжээ – 3.18.4 Аялал жуулчлалын мэдээллийн сан бий болгож,салбарын статистик бүртгэлийг сайжруулна.

Биелэлт: Улаанбаатар хотын “Жуулчдад үйлчлэх мэдээллийн төв”-д жуулчдад зориулсан хэрэгцээт мэдээллийн санг бий болгоод байгаа бөгөөд БОАЖЯамтай хамтран цахим мэдээллийн санг бий болгохоор хэлэлцэж байна. Мэдээллийн санг жил болгон шинэчлэн өргөжүүлнэ.

Салбарын статистик мэдээллийг 2009 онд Хил хамгаалах газар, БОАЖЯамнаас гаргасан статистик мэдээ болон “Жуулчны мэдээллийн төв”-өөр авсан санал асуулгын дүнг нэгтгэн гаргасан. 2010 онд тус үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүднээс жуулчдаас сэтгэл ханамжын болон жуулчид Улаанбаатар хотын эдийн засагт оруулж буй хувь хэмжээг тогтоох судалгааг явуулж, анхан шатны дүн гарсан.

Хэрэгжилт –90%

143. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.18

Арга хэмжээ – 3.18.5 Жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэн, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт ойртуулна.

Биелэлт: Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6043:2009 шинэчлэгдсэн стандартыг 2009 онд шинээр батлаган гарсантай холбогдуулан аж ахуйн нэгжүүдэд сурталчилан таниулах, хэрэгжүүлэн мөрдүүлэх зорилго бүхий сургалт, семинарыг Баянзүрх дүүргийн мэрэжлийн хяналтын хэлтэс, Монголын зочлох үйлчилгээний холбоо зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

Нийслэлийн нутаг дэвсгэрт анхлан үйл ажиллагаа эрхэлж буй зочид буудал, амралтын газруудын хүний нөөцийн чадавхи, үйлчилгээний чанар, зохион байгуулалт, маркетинг, эдийн засагийн менежментийг сайжруулахад чиглэсэн сургалтыг БНСУ-ын Зочид буудлын холбоо, Монголын зочлох үйлчилгээний холбоотой хамтран зохион байгуулсан. Сургалт монголын зочид буудал, амралт зугаалгын газруудыг олон улсын жишигт хүргэх, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, жуулчдыг татах зэрэг сэдвүүдийн хүрээнд 2 өдөр явагдсан.

Хэрэгжилт –50%

144. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.18

Арга хэмжээ – 3.18.6 Аялал жуулчлалын томоохон цогцолбор барьж байгуулна.

Биелэлт: Нийслэлийн 6 дүүрэгт баригдах спорт цогцолборын ажлыг хэрэгжүүлэхээр зураг төсвийн ажлыг бэлэн болгосон. Аялал жуулчлалын томоохон цогцолбор барьж байгуулах ажлыг судалж байна.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа түүх соёлын дурсгалт газруудыг аялал жуулчлалын эргэлтэнд оруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүнүүдийг бий болгох зорилтын хүрээнд Улаанбаатар хотын нутаг дэвсгэт байгаа түүх соёлын дурсгалт газруудыг аялал жуулчлалын эргэлтэнд оруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүнүүдийг бий болгох зорилтын хүрээнд жуулчдын сонирхолыг татах “Чингис хааны 3-р ордон” түүх аялал жуулчлалын цогцолбор байгуулах төслийг болвсруулсан. Газрын асуудал шийдэгдээгүй байна. Жуулчны гудамжинд “Урт цагаан” гар урлалын төвийг ажилуулж байгаа бөгөөд 2-р хэсгийг бий болгохоор төлөвлөгөөнд оруулан зураг, төслийг болосруулж байна.

Хэрэгжилт –70%

145. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.18

Арга хэмжээ – 3.18.7 Түүх соёлын болон адал явдалт, тусгай сонирхлын аялал, жуулчлалыг түлхүү хөгжүүлж, аялал жуулчлалын эвент, арга хэмжээнүүдийг зохион байгуулах ажлыг дэмжинэ.

Биелэлт: МАЖХолбоо болон бусад төрийн бус байгууллагуудтай хамтран жил бүрийн 7-р сарын 13-ны өдөр “Дээлтэй Монгол” үндэсний хувцасны парад арга хэмжээ, 7-р сарын сүүлийн амралтын өдрүүдэд “Тал нутгийн марафон” олон улсын гүйлтийн тэмцээн, хүүхдүүдийн авьяасыг хөгжүүлэх жуулчдыг татан оролцуулах зорилгоор “T-shirt art” задгай талбайн үзэсгэлэн, жуулчны улиралыг уртасгах үүднээс Сар шинийн 6-ны өдөр “Олон улсын мөсөн шагайн наадам” тэмцээнүүдийн тус тус зохион байгуулж байна.

Хэрэгжилт –50%

146. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.19

Арга хэмжээ – 3.19.2 Байгалийн нөөц, баялагийг хамгаалах, зохистой ашиглахтай холбогдуулан аймаг, сумын Засаг даргын үүрэг хариуцлагыг өндөржүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн ногоон бүсийн ойн сан газарт иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд Монгол Улсын “Ойн тухай хууль”, “Усны тухай хууль”-ийг зөрчин хашаа байшин барих зөрчил их хэмжээгээр гарч, ойн сан газарт барилга байшин барьснаар ногоон бүсийн ой байгалийн аясаар сэргэн ургах чадваргүй болж, ойн ургамалжилтын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөж, улмаар ойн өвчин, хөнөөлт хортон шавьж олшрох экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүргэж байна. Энэ байдлыг таслан зогсоохоор дүүргүүдийн Засаг дарга нарын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн ногоон бүсийн ойн сан газарт газар олголт хийхгүй байх тухай албан мэдэгдлийг Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдийн Газрын албанд хүргүүлэн ажиллаж байна.

Баянзүрх дүүргийн Засаг дарга болон түүний Тамгын газар, нийслэлийн Байгаль хамгаалах газар хамтран Баянзүрх ууланд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ойжуулалтын ажлын хамгаалалтыг шийдвэрлэх зорилгоор 4750 уртааш метр хашаа барьж хамгаалж байна.

Ойн газраас зарласан “Монголоо ногоорууль” аяныг 2010 оны 3-р сарын 18-ны өдрөөс 6 дүүргийн Засаг даргын Тамгын газарт тугийг аялуулж эхэлээд байна. Үүний үр дүнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд орчноо тохижуулах, ногооруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим, ХААН банк хамтран “Green awards-2010” болзолт уралдааныг 2010 оны 6 сарын 5-ны өдөр Дэлхийн байгаль хамгаалах өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатайгаар зарласан. Дээрх уралдаанд дүүргүүдийн Засаг дарга нарыг байгаль хамгаалах үйлсэд оруулах хувь нэмэр, үүрэг оролцоог нэмэгдүүлэх, ногоон тохилог орчинг бүрдүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулахыг уриалсан. Нийслэлийн Байгаль хамгаалах газраас Дүүргүүдийн Засаг дарга нарт уралдааны болзлыг хүргүүлж, хамтран ажиллах санал хүргүүлээд байна.

Хэрэгжилт –50%

147. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.19

Арга хэмжээ – 3.19.3 Ашигт малтмал олзворлосон эдэлбэр газрыг нөхөн сэргээх стандартыг баритлан хяналт, хариуцлагын механизмыг боловсронгуй болгоно.

Биелэлт: БОАЖЯ-ны дүгнэлтийг үндэслэн Ашиг Малтмалын Газрын Геологи, уул уурхай кадастрийн хэлтсийн даргын 2009 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 262 тоот шийдвэрээр суурьшлийн бүсэд байгалийн түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтэй 13 аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа явуулах эрхийг цуцлуулсан бөгөөд тухайн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа бүрэн зогсож, нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж, газар чөлөөлүүлэх ажил хийгдэж байгаа ба “Баярсканстракшн” ХХК техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 80 хувьтай гүйцэтгэж, нөхөн сэргээлт хийсэн талбайд 1100 ширхэг улиасны суулгацыг орос болон хятадаас оруулж ирж суулгаж байна. “Даян-Оргил” ХХК эвдрэлд орсон газрынхаа 75 хувьд техникийн нөхөн сэргээлт хийж, шороо дарж түрж тэгшлэх ажил хийж гадны байгууллага аж ахуйн нэгжүүдийн хог хаягдал хаяхаас хамгаалан хайс тор татсан зэрэг ажил хийсэн. “Арбадрах” ХХК эвдрэлд оруулсан газартаа техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 70 хувьтай хийж олборлолтын явцад үүсэж бий болсон нууранд 4 төрөл зүйлийн 500 орчим загас байршуулан нутагшуулж, 200 гаруй бут сөөг суулгац суулгасан зэрэг ололттой ажлууд хийгдсэн. Үлдсэн аж ахуйн нэгжүүдийг хотын суурьшлын бүсээс гаргах шийдвэрийг шалгалтын материалын хамт, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулж шийдвэр гаргуулахаар бэлтгэж байна.

Хэрэгжилт –50%

148. Дэд бүлэг – 3

Зорилт – 3.19

Арга хэмжээ – 3.19.4 Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээнд тавих байгаль орчны болон олон нийтийн хяналтыг сайжруулна.

Биелэлт: Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, халдваргүйжүүлэх, устгах ажил үйлчилгээ эрхэлж буй 2 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 11 удаагийн шалгалт, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүн, зардлын гүйцэтгэл болон агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа байдлыг холбогдох байгууллагуудтай хамтран шалгаж, нэгдсэн дүгнэлт гаргах хяналт шалгалтыг 45 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тус тус хийсэн. Хяналт шалгалтын танилцуулгыг МХЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар оруулж асуудлыг холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлсэн.

Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгж, байгууллага, авто замын болон барилгын материалын асфальт бетон, хайрга бутлан ангилах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг шалгаж илэрсэн зөрчлийг арилгуулан нөхөн сэргээлтийн ажлын явцыг эрчимжүүлэх зорилгоор хамтарсан шалгалтыг хийж гүйцэтгэн, нийт 235 зөрчил илрүүлэн газар дээр нь 188 зөрчлийг арилгуулж, Тоосгоны үйлдвэрийн үйл ажиллагаанд шалгалт хийж 4 компанийг 4 сая төгрөгөөр, элс хайрга бутлан ангилдаг 5 компанийг 2.5 сая төгрөгөөр, асфальт бетон үйлдвэрлэдэг 2 компанийг 400.0 мянган төгрөгөөр, хаягдал төмөр боловсруулах 1 компанид 200.0 мянган төгрөгийн торгууль ногдуулан зөрчлийг арилгуулж, 3 компани үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоосон.

Усыг бохирдохоос хамгаалах шаардлагыг биелүүлээгүй 1 аж ахуйн нэгж байгууллага, зөвшөөрөлгүй худаг гаргаж байсан 1 иргэн, 1 аж ахуйн нэгж байгууллагыг нийт 370000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авлаа.

Чингэлтэй дүүргийн 19-р хороо Ар согоотын амны уулзвар дээр уул ухаж дайрга ачиж байсан 2 иргэнд 90000 төргөний торгуулийн арга хэмжээ авч үйл ажиллагааг нь зогсоолоо. Тус дүүргийн Шадивлангийн амны наад талд Шатахуун түгээх станц барих зорилгоор уул ухаж дайрга олборлож

байгаа Өргөн говь ХХК-ны үйл ажиллагааг шалгаж бичиг баримт бүрдтэл нь түр зогсоох арга хэмжээ авч ажиллаа.

СХД-ийн 20-р хороо Шижир ойл ХХК-ны арын дэнжийг зөвшөөрөлгүй ухаж байсан Вагнер ази ХХК-ны үйл ажиллагааг зогсоож “Ашигт малтмал”-ын тухай хуулиар 1.000.000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч 2.000.000 төгрөгний нөөц ашигласны төлбөр ноогдуулаж ажилласан.

Хэрэгжилт –50%

Бүлэг – Дөрөв. ЭРХ ЗҮЙТ ТӨРИЙГ ТӨЛӨВШҮҮЛЖ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОЛГОХ ЗОРИЛТ

4.1 Эрх зүйн бодлого

149. Дэд бүлэг – 4.1

Зорилт – 4.1.3

Арга хэмжээ – 4.1.3.2 Эрх зүйн хэм хэмжээг тогтоосон захиргааны актыг нийтэлдэг “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраар дамжуулан засаг, захиргааны анхан, дунд шатны нэгж, байгууллага бүрт хүргэх арга хэмжээ авна.

Биелэлт: Хууль зүйн мэдээлэл сэтгүүлийг нийслэлийн хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газар, дүүрэг, хорооны хэмжээнд захиалах талаар Тамгын газрын даргаас албан бичгээр үүрэг өгөгдсөн. Дүүрэг, харьяа газрын хуулийн зөвлөх, эрх зүйн мэргэжилтэнүүдэд зориулсан семинар дээр ХЗДХЯамнаас ирүүлсэн Хууль зүйн мэдээлэл сэтгүүлийн 2010 оны 1 дугаарыг өгсөн.

Хэрэгжилт –50%

150. Дэд бүлэг – 4.1

Зорилт – 4.1.3

Арга хэмжээ – 4.1.3.5 “Эрх зүйн туслалцааны төв”-ийг 21 аймаг, 9 дүүрэгт НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн туслалцаатайгаар байгуулж, үйлчилгээний хүрээг өргөжүүлнэ.

Биелэлт: ХЗДХЯ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн туслалцаатайгаар “Эрх зүйн туслалцааны төв”-ийг 9 дүүрэгт байгуулсан. Тус төвд одоогийн байдлаар Дүүргийн ЗДТГазрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, өмгөөлөгч иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэн, төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилж байна. Төлбөрийн чадваргүй 500 гаруй иргэнд хууль зүйн зөвлөлгөө өгсөн. Эрх зүйн туслалцааны төвийн эрх зүйн мэргэжилтэнүүдтэй 1, 3-р сард уулзаж арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан. Эрх зүйн туслалцааны төвийг цаашид бэхжүүлэх талаар дүүргийн Засаг дарга нарт чиглэл өгч ажиллаж байна.

ХЗДХЯ-наас зохион байгуулсан “Эрх зүйн туслалцааны үндэсний тогтолцоог боловсронгуй болгох арга зам” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож, дүүргүүдэд ажиллаж байгаа Эрх зүйн туслалцааны төвийн ажиллах нөхцөл, тэнд ажиллаж буй хуульчид, өмгөөлөгчдийн хийж байгаа ажлын талаар танилцуулан, цаашид анхаарч ажил, энэ чиглэлээр өөрийн бие даасан хуультай байх талаар саналаа танилцуулсан.

ХЗДХЯ-тай хамтран Сүхбаатарын талбайд “Шударга ёс” нээлттэй өдөрлөг зохион явуулж, дүүргийн “Эрх зүйн туслалцааны төв”-ийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж, “Эрх зүйн туслалцааны төв”-ийн тухай 500 гаруй гарын авлагыг иргэдэд олгосон.

ХЗДХЯ, НҮБ-ийн Хүний эрхийн төслөөс зохион байгуулсан сургалт семинарт 9 дүүргийн “Эрх зүйн туслалцааны төв”-ийн эрх зүйн ажилтан, өмгөөлөгч нарыг бүрэн хамруулан ажилласан.

Хэрэгжилт –50%

4.2. Гэмт хэрэгтэй тэмцэх

151. Дэд бүлэг – 4.2

Зорилт – 4.2.1

Арга хэмжээ – 4.2.1.3 Нийслэл хотын гудамж, талбай олон нийтийн газарт телекамер суурилуулах ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.

Биелэлт: Хууль зүй дотоод хэргийн яамны Мон-7 төслийн хяналтын баг, Цагдаагийн ерөнхий газар, нийслэлийн Онцгой байдлын газар, нийслэлийн Цагдаагийн газар, Төслийг гүйцэтгэгч LG CNS байгууллагууд хамтран нийслэлийн хэмжээний ой хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, түргэн шуурхай арга хэмжээ авах зорилгоор ногоон бүсийг телекамержуулах зорилгоор Соёмбо толгой, Чингэлтэй хайрхан ууланд тус бүр 1 камер суурилуулсан.

Морин даваан дээр байрлах Радио холбооны бааз станц, “CCTV” камерыг хүлээн авч, Чингэлтэй хайрхан уулан дах камерыг тестлэж, кониверторыг тог баригчтай холбох, Соёмботой толгойд байрлуулсан камерт цахилгаан тэжээлийн шугам татаж, Яргайтын богины аманд гал гаргаж тестлэх, Тамгын өндөр уул, Чингэлтэй уул, Худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг газруудад байрлах дахин дамжуулах станцууд дээр үелзлэлийн тохиргоог 2 удаа, сувгийн зохицуулалтыг 1 удаа, техник үйлчилгээ

зэргийг тус тус хийж ажиллаа. Дээрх төслийн хүрээнд Онцгой байдлын албан хаагчдыг сургалтанд бүрэн хамруулж ажиллаа.

Нийслэлийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг телекамерын системд үе шаттайгаар оруулах төслийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдэрлүүлэхээр холбогдох судалгаа тооцоог хийж, бэлтгэл ажлыг хангаж байна.

Нийслэлийн хэмжээнд эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хүндэрдэг 5 дүүргийн нутаг дэвсгэрт хяналтын камер байрлуулах төсөл шийдвэрлэгдэн хэрэгжиж байна. Баянгол дүүрэгт 24, Сонгинохайрхан дүүрэгт 44, Сүхбаатар дүүрэгт 61, Хан-Уул дүүрэгт 11, Чингэлтэй дүүрэгт 43, Багануур дүүрэгт 19 аж ахуйн нэгжийн гадна талбайд шинээр камер байрлуулж Шуурхай удирдлага зохицуулалтын төв дээр үйл ажиллагааг нь хянан явуулж байна.

“Нийслэлийн байгууллага, аж ахуйн нэгжийн орчны гэрэлтүүлэг, камержуулалт, дохиололд хамруулсан өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ”-ний талаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Нийгмийн хэв журам хамгаалах бодлогын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр мэдээлэл бэлтгэн, Нийгмийн хэв журам хамгаалах газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.

“Энричмент” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2010 оны 8 дугаар сараас эхлэн GSM/GPS сүлжээ ашиглан гэмт халдлагаас хамгаалах системийг 27 объектод туршилтын журмаар байрлуулан, 24 цагийн хяналт тавин ажиллаж байна. Орчин үеийн мэдээллийн “Alarm” программ хангамж, дохиоллын тоног төхөөрөмжийн тусламжтайгаар хамгаалалтын объектод гэмт халдлага гарсан тохиолдолд Нийслэлийн цагдаагийн газар болон “Энричмент” ХХК-ний хяналтын нэгдсэн төвд нэгэн зэрэг мэдээлэл ирсний дагуу Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газрын машинт эргүүл, дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн алба хаагчид цаг алдалгүй тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Орчин үеийн шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник технологийг байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, олон нийтэд сурталчлан, таниулах, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан холбох зорилгоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд шинжлэх ухаан, техникийн ололтыг нэвтрүүлэх нь” сэдэвт, сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж, дохиолол хамгаалалт, гэрэлтүүлэг, камержуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын танилцуулга, үзэсгэлэнг зохион байгуулж, нийт 800 хүнийг хамруулсан.

Хэрэгжилт –50%

152. Дэд бүлэг – 4.2

Зорилт – 4.2.4

Арга хэмжээ – 4.2.4.1 Замын хөдөлгөөнд хяналт тавих телекамерын хяналтын системийг Улаанбаатар хотод бий болгох асуудлаар төсөл хэрэгжүүлж, уг ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.

Биелэлт: Улаанбаатар хотын замын хөдөлгөөний зохион байгуулалтыг сайжруулах, замын хөдөлгөөний түгжрэлийг багасгах зорилгоор Монгол улс, БНСУ-ын Засгийн газар хоорондын гэрээний дагуу хэрэгжүүлсэн “Зам тээврийн оновчтой систем” төслийн ажил бүрэн дуусч ашиглалтанд хүлээн аваад байна. Төслийн хүрээнд замын хөдөлгөөний удирдлагын нэгдсэн төвийн программ хангамж, техник хангамж, хөдөлгөөн зохицуулах иж бүрэн гэрэл дохио 47 уулзварт, хөдөлгөөнийг хянах телекамер 26 цэгт, мэдрэгч 52 цэгт, хурдны зөрчил илрүүлэх эрэн сурвалжлах 7 камер, гэрэл дохио зөрчлийн 4 иж бүрдэл, тээврийн хэрэгсэл мэдрэгч 44 газарт, мэдээллийн самбарыг 2 цэгт бүрэн суурилуулж, тоног төхөөрөмжүүдийг удирдлагын төвтэй холбосон 65 км шилэн кабелийн сүлжээг суурилуулах ажлууд бүрэн хийгдлээ.

Төслийг хэрэгжүүлэгч байгууллагад нийслэлийн гудамж замын 22 уулзварт тээврийн хэрэгслийн улсын дугаар, замын хөдөлгөөний дүрэм зөрчигчийг илрүүлэгч телехяналтын камер тавиулах санал хүргүүлж графикайн дагуу гүйцэтгүүлсэн. Мөн 19 уулзвар замуудад байрлуулсан гэрлэн дохионы ажиллагааны горимд өөрчлөлт оруулан ажилд оруулсан. Гэрлэн дохионы ажиллах горим нь өнөөгийн манай замын хөдөлгөөний нягтрал, хөдөлгөөний эрчимтэй уялдаагүй тул зохиомол түгжрэл саатал бий болгож байна. Иймд шинчлэгдсэн 13 гэрлэн дохионы ажиллагааны горимыг өөрчилж уулзварын нэвтрэн өнгөрөх чадварыг сайжруулах хэмжээ авахуулж ажилласан.

Төсөл хэрэгжсэнтэй холбогдуулан НИТХ-ын тогтоолоор “Замын хөдөлгөөний удирдлагын төв” НӨУҮГазар шинээр байгуулагдаж, Нийслэлийн Засаг даргын захирамжаар тус төвийн даргыг томилж, байгууллагын дүрмийг баталсан. Мөн нийслэлийн Засаг даргын захирамжаар төслөөр хэрэгжсэн ажлыг болон Монгол талын санхүүжилтээр гүйцэтгэсэн ажлуудыг ашиглалтанд хүлээн авах техникийн комиссыг Улаанбаатар хотын ерөнхий менежер ахлан ажиллаж, улсын комисст хүлээлгэн өгсөн.

Тус төв дээр замын цагдаагийн газраас хөдөлгөөний хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа удирдан зохион байгуулах зорилгоор ашиглагдаж байгаа хэт богино долгионы станцын 3 суваг, гэмт хэрэг, зөрчил, үйл ажиллагааны талаар мэдээлэл хүлээн авах 124, 70112100, 98000124 дугаар бүхий үүрэн

болон суурин телефон утаснуудыг тус тус байршуулж, ЗЦГ-ын Тусгай хамгаалалтын тасгийн байцаагч нарыг 24 цагаар, дүүргүүдийн Замын цагдаагийн газрын тасгийн байцаагч нарыг өдрийн 8 цагаар хуваарийн дагуу ажиллуулж удирдлагын төв дээр хөдөлгөөний аюулгүй байдлын хяналт тавих, хөдөлгөөнийг зохион байгуулах ажлыг тасралтгүй зохион байгуулж байна. 2010 оны 9-р сараас эхлэн "Авто радио" FM 96,3 радиогаар Замын хөдөлгөөний хяналтын удирдлагын төвөөс мэдээлэл өгөх ажлыг эхлүүлээд байна.

Замын цагдаагийн газрын "Шуурхай удирдлагын төв" замын хөдөлгөөнд түгрэл саатал үүсч байгаа мэдээллийг тухайн дүүргийн Замын цагдаагийн тасагт дамжуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн тус төв дээр гарсан зөрчлийг бүртгэх, зөрчил гаргагчийн гэрийн хаягаар зөрчлийн бүртгэлийг хүргүүлэх зорилгоор байршуулагдаж байгаа зөрчлийн бүртгэлийн хяналтын камеруудийг Замын цагдаагийн газрын жолооч, тээврийн хэрэгслийн мэдээллийн сантай холбох асуудлаар харилцан судалгаа хийж өндөр хурдны шилэн кабелийн сүлжээгээр холбох, нэгдсэн систем бий болгох техникийн нөхцлийг боловсруулаад байна.

Хэрэгжилт –90%

153. Дэд бүлэг – 4.2

Зорилт – 4.2.10

Арга хэмжээ – 4.2.10.3 Согтууруулах ундааны үйлдвэрлэл, үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг шалгалт тогтмол явуулж, гаргасан санал дүгнэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээ авна.

Биелэлт: "Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй болон шинээр хүсэлт гаргасан хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад аттестатчилал явуулах тухай" удирдамжийн дагуу 9 ажлын хэсэг 2402 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийсэн.

Улаанбаатар хотын ерөнхий менежерийн баталсан тушаалаар 1875 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 1-3 жилийн хугацаагаар сунгаж, 91 аж ахуйн нэгжид шинээр зөвшөөрөл олгож, 400 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна. Мөн хууль бус үйл ажиллагаа явуулсан 61 аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Архи, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшдэг 64 аж ахуйн нэгж байгууллагад зуны сүүдрэвчтэй үйлчилгээ явуулах 3 сарын хугацаатай зөвшөөрөл олгож, тухайн байгууллагуудын үйл ажиллагааг шалгаж 4 байгууллагад захиргааны арга хэмжээ авч ажилласан.

Нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн хэлтсээс 60947 байгууллага, аж ахуйн нэгжид батлагдсан удирдамжийн дагуу үзлэг шалгалт хийж 1652 иргэн, 129 албан тушаалтан, 346 байгууллага, аж ахуйн нэгжийг 89463.9 мянган төгрөгөөр торгож, 13863 албан мэдэгдэл өгч, дутагдлыг засуулж 9348 хариуг авсан байна.

Архины 70, спиртийн 6, пивоны 97, дарсны 129, ресторан зоогийн газар 5761, диско 5477, караоке 2321, кафе 2500, хүнсний дэлгүүр 19016, бөөний 591 төвийг шалгаж, 9330 зөрчил илрүүлж, арилгуулах арга хэмжээ авсан.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаалаар нийслэлийн хэмжээнд согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн эрхийг сэргээсэн 10, хүчингүй болгосон 37, сунгасан 171, шинээр олгосон 25, нийт 196 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавиж ажиллах үүргийг дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдэд хүргэн ажилласан.

Улсын стандартын хэрэгжилт, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг орон нутгийн засаг захиргааны нэгж болох хороодын Засаг дарга, хэсгийн байцаагчтай хамтран хяналт шалгалтын ажлыг 33 удаа хийж ажилласан.

2010 оны байдлаар 3034 аж ахуйн нэгжийг хамруулан шалгаж, шалгалтын явцад худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний 1296 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг сунгах, стандартын шаардлага хангаагүй, аж ахуйн нэгж нь татан буугдсан, үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 461 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг гаргаж, шийдвэрлүүлсэн. Шалгалтын явцад 627 зөрчил илрүүлж, 344 буюу 54.8 хувийг газар дээр нь арилгуулан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор 120 албан шаардлагыг аж ахуйн нэгжид өгч, гүйцэтгэлийг хангуулж, 117 байгууллагад 7 сая 800 мянган төгрөг, 58 албан тушаалтанд 1 сая 520 мянган төгрөг, 30 иргэнд 280 мянган төгрөгийн нийт 9 сая 600 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авлаа.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, нийслэлийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдтэй хамтран нийслэлийн 39 бөөний худалдааны газруудад хамтарсан хяналт шалгалтыг хийж, дүнг дэд даргын зөвлөлийн хуралд танилцуулж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр 18 удаа сурталчилгаа хийж, хэрэглэгчдэд мэдээ мэдээллийг өгч ажиллаа.

МХЕГ, ХЗЯ, Стандарт хэмжил зүйн үндэсний газартай хамтран архи, согтууруулах ундаа импортолдог 8 аж ахуйн нэгж байгууллагуудад хамтарсан хяналт шалгалтын хийж гүйцэтгэн, шалгалтаар илэрсэн зөрчилд 2 аж ахуй нэгж байгууллагад 500 мянган төгрөгний торгууль ногдуулсан.

Хэрэгжилт –50%

154. Дэд бүлэг – 4.2

Зорилт – 4.2.12

Арга хэмжээ – 4.2.12.3 Ялтны мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв байгуулж, ялтныг байнгын ажлын байраар хангах асуудлыг шийдвэрлэнэ.

Биелэлт: “Захиргааны хяналтыг сайжруулья” сэдэвт арга хэмжээг зохион байгуулж, хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн, ял хойшлогдсон хүмүүст тавих захиргааны хяналтыг сайжруулах чиглэлээр дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүд ажилласан.

Нийслэлийн прокурорын газартай хамтран төвийн 6 дүүргийн хэмжээнд “Тулгалт” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, захиргааны хяналтанд байгаа хорих ял эдлээд суллагдсан 505, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдэж, ял хойшлогдсон 632, нийт 1137 ялтангийн хяналтын хувийн хэрэгтэй танилцан захиргааны хяналтанд байгаа хүмүүсийг нийгэмшүүлэх, амьдралын зөв замд оруулан дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлыг шалган, хэсгийн байцаагч, хяналтын прокуроруудтай уулзалт, ярилцлага хийж санал хүсэлтийг сонсож, зааварчилга өгсөн. Цагдаагийн байгууллагаас урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээний хүрээнд хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн 1926 ялтанд захиргааны хяналт тавьж, хугацаа дууссан-10, шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгуулсан-1, захиргааны хяналтыг зогсоосон 8, харьяаллын дагуу шилжүүлсэн 19 ялтан байна. Хорих ял эдлээд суллагдсан 2029 хүнд хяналт тавьж ажилласнаас 40 хүний захиргааны хяналтын хугацаа дууссан тул хяналтын картыг хааж, 25 хүнийг харьяаллын дагуу шилжүүлсэн байна.

Хэрэгжилт –50%

4.5. Иргэний нийгэм, төрийн удирдлагын бодлого

155. Дэд бүлэг – 4.5

Зорилт – 4.5.4

Арга хэмжээ – 4.5.4.4 Төсвийн байгууллагын Ерөнхий менежерүүдийг манлайлах ур чадвар дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт хамруулан сургаж, чадавхийг бэхжүүлнэ.

Биелэлт: Удирдлагын Академийн магистрийн сургуулийг 2 хүн төгсч шинээр 3 хүн элсэн орж, Төрийн алба, удирдлагын сургуулийн “Удирдлагын менежментийг сайжруулах, хүний нөөцийн асуудлын тухай”, “Нутгийн захиргааны шинэчлэл, хандлага” сэдэвт захиалгат сургалтанд нийслэл, дүүргийн 21 төрийн албан хаагч хамрагдсан.

“Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу энэ онд ерөнхий менежерүүдийн сонгон шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулж нийт 75 хүн оролцож 24 хүнийг тухайн албан тушаалд томилуулахаар нэрийг нь дэвшүүлж 47 хүн удирдах албан тушаалтны нөөцөнд бүртгэсэн. Сонгон шалгаруулалт нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч зарим агентлагийн дарга, дүүргүүдийн Тамгын газрын дарга, дүүргийн Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтсийн дарга, Халамж үйлчилгээний хэлтсийн дарга, Хөдөлмөр эрхлэлтийн албаны даргын ажлын байруудад явагдлаа.

Нутгийн захиргааны байгууллагын дунд шатны дарга, менежерийн удирдлагын орчин үеийн арга барилыг төлөвшүүлэх, ажлын байранд богино хугацаанд дадлагажуулах, шинэ мэдээлэл, мэдлэг олгох сургалтыг ХБНГУ-ын Конрад Аденаурын сангийн санхүүжилтээр Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газарт зохион байгуулав. Сургалтанд нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-ын хэлтэс, албадын дарга нар оролцож, Удирдлагын Академийн багш нар удирдан явуулав.

Хэрэгжилт –50%

156. Дэд бүлэг – 4.5

Зорилт – 4.5.4

Арга хэмжээ – 4.5.4.5 Төсвийн байгууллагын тогтолцоо, бүтцэд судалгаа хийсний үндсэн дээр тэдгээрийн үйл ажиллагааны уялдааг хангах, иргэдэд үзүүлэх төрийн суурь үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр боловсронгуй болгох арга хэмжээ авна.

Биелэлт: Нийслэлийн Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын бүтцэд судалгаа хийж бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийснээр нийслэлийн Барилга хот байгуулалт, төлөвлөлтийн газар, Хөрөнгө оруулалтын газар, Зураг төслийн хүрээлэнг байгууллаа. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Зураг төслийн хүрээлэн нь нийслэлийн өмчит улсын үйлдвэрийн газар байхаар зохион байгуулагдаж нийслэлийн Засаг даргын захирамжаар дүрэм, бүтэц орон тоог нь баталсан.

Иргэдэд үзүүлэх төрийн суурь үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор нийслэлийн дүүргүүдийн 132 хороонд Халамжийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан, бүртгэлийн ажилтны орон тоог шинээр бий болгож ажиллуулж байна.

Нийслэлийн удирдлагуудын иргэдтэй уулзах уулзалтын хуваарийг Нийслэлийн Засаг даргаар батлуулан 3 дугаар сараас эхлэн мөрдөж нийслэлийн Засаг даргын 4 орлогч, Улаанбаатар хотын ерөнхий менежер, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нийт 3941 иргэнийг хүлээн авч уулзаж, санал хүсэлтийг нь сонсон асуудлыг нь шийдлээ.

Нийслэлийн Засаг даргын баталсан хуваарийн дагуу нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд 347 удаа "Ажлаа танилцуулах өдөр"-ийг зохион байгуулж, давхардсан тоогоор 669.887 иргэнд үйлчилсэн. Нийслэлийн хэмжээнд "Ажлаа танилцуулах өдөр"-ийг зохион байгуулж, үйлчлүүлсэн иргэдийн тоо 2007 онд 100000, 2008 онд 212700, 2009 онд 342994, 2010 онд 669887 болж өслөө.

2010 онд Баянгол, Налайх дүүрэгт "Нэг цонхны үйлчилгээ"-г шинээр нэвтрүүлж өргөдөл гомдол, иргэний бүртгэл, үйлдвэрлэл үйлчилгээний зөвшөөрөл олгох, хууль эрх зүйн зөвлөгөө, нийгмийн даатгал, хөдөлмөр халамж, газрын харилцаа, нотариатын үйлчилгээ зэрэг асуудлаар иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ үзүүлж байна. Нийслэлийн 6 дүүрэг /Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Налайх/ энэ онд давхардсан тоогоор 26 нэр төрлийн үйлчилгээг 603779 иргэнд хүргэсэн.

Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлэх, өрх хүн амын тоог тэнцвэржүүлэх, нутаг дэвсгэрийн харьяаллыг тодорхой болгох зорилгоор дүүргүүдийн саналыг авч, шинээр хороо байгуулах, нэгтгэх, өөрчлөх саналыг боловсруулах ажлын хэсгийг нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулан ажиллаа. Сонгинохайрхан дүүрэгт 7, Баянзүрх дүүрэгт 4, Баянгол дүүрэгт 3, Хан-Уул дүүрэгт 2, Сүхбаатар дүүрэгт 2, Налайх дүүрэгт 1, Багануур дүүрэгт 1 нийт 20 хороо шинээр байгуулах асуудлыг НИТХ-ын 6 дугаар хуралдаанаар оруулан шийдвэрлүүлээд байна. 2011 оноос эхлэн нийслэлийн дүүргүүдэд шинээр 20 хороо нэмэгдэж нийслэлийн хэмжээнд нийт 152 хороо ажиллахаар болоод байна.

Хэрэгжилт –50%

157. Дэд бүлэг – 4.5

Зорилт – 4.5.5

Арга хэмжээ – 4.5.5.2 Төрийн албан тушаал (ажлын байр)-ын чиг үүргийн шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр хүлээх үүрэг хариуцлагыг нь тодорхой тусгасан ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулан баталж мөрдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн "Нийслэлийн дүүргүүд, түүний харьяа зарим байгууллагын төрийн албан хаагчийн хэрэгцээ, хангалтын үйл ажиллагааг шалган зааварлах тухай" удирдамжийн дагуу Төрийн албаны зөвлөлтэй хамтран нийт 1067 албан хаагчийг хамарсан 9 дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газар, хороод, дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Боловсролын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Статистикийн хэлтэс, Татварын хэлтэс, зэрэг байгууллагууд хамрагдаж нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан байдалтай танилцаж зөвлөгөө өгч ажилласан.

Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгээс төрийн албан хаагчдын ажил үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг жигдрүүлэх, ажлын байрны зураг авалт хийх, хүлээх хариуцлагыг тодорхой болгох зэрэг ажлуудыг хийж, ажилтан нэг бүрийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан.

Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, карьерын (албан тушаал дэвших) зарчмаар томилогдоогүй байсан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын зохион байгуулалтын бүтцийн 91 нэгжийн дарга нарын ажлын байранд дүгнэлт гаргасан.

Хэрэгжилт –50%

158. Дэд бүлэг – 4.5

Зорилт – 4.5.5

Арга хэмжээ – 4.5.5.3 Гадаад, дотоод орчны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төсвийн байгууллага бүрийг өөрчлөн хөгжүүлэх замаар байгууллагын шинэ соёлыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл баталгааг хангах арга хэмжээ авна.

Биелэлт: "Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар 2009-2012 онд хэрэгжүүлэх хөтөлбөр"-ийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлан мөрдөн ажиллаж байна.

2010 онд 26 албан хаагчдад 20532,4 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгож, тэтгэвэрт гарсан 4 албан хаагчдад 36 сарын тэтгэмж болгож 61,7 сая төгрөгийг олгосон. Төрийн албан хаагчдын үр

дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээг харгалзан нийт ажилтнуудад 150.0-350.0 мянган төгрөгийн урамшуулал олгох ажилд 31,2 сая төгрөг зарцуулсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, дүрэмт хувцасаар хангахад 8,2 сая төгрөг, компьютеруудыг шинэчлэхээр 100,0 сая төгрөгийг зарцуулахаар үнэлгээний хороо байгуулагдаж тендер зарлан, гэрээ хийгдээд байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын албан хэрэгцээнд зориулж хэвлэх машин, скайнер, факсын аппарат, сейф, зөөврийн диск зэргийг худалдан авах, төрийн албан хаагчдын ажиллах ажлын байрны нөхцлийг сайжруулах засвар, үйлчилгээ хийхэд 50 гаруй сая төгрөгийг зарцуулаад байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдыг дипломын дараах сургалтуудад хамруулах, нийслэлд шаардлагатай нарийн мэргэжлийн инженерүүдийг бэлдэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын захирамжаар "Нийслэлд шаардлагатай нарийн мэргэжлийн боловсон хүчнийг өндөр хөгжилтэй орнуудад хотын захиалгаар сургах, суралцагсдыг шалгаруулах тухай журам" батлагдсан. Уг журамын дагуу БНСУ-ын Ёожугийн Их сургуульд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын 19 төрийн албан хаагч 45 хоногийн хугацаагаар хот төлөвлөлтийн чиглэлээр суралцсан. Мөн Австри, АНУ-д магистрийн сургалтанд 3 албан хаагчийг суралцуулахаар хөрөнгийн асуудлыг нь шийдвэрлээд байна.

Засгийн газрын тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулах тухай" журмын дагуу нийслэлд хуваарилсан квотод багтаж, шаардлага, шалгуурыг хангасан "4000" айлын орон сууц хөтөлбөрт 39 албан хаагч, "40000 орон сууц" хөтөлбөрт 25 төрийн албан хаагч нийт 64 төрийн албан хаагч орон сууцны зээлд хамрагдахаар болж материалыг ОССК-д хүлээлгэн өгөөд байна.

Хэрэгжилт –50%

159. Дэд бүлэг – 4.5

Зорилт – 4.5.5

Арга хэмжээ – 4.5.5.4 Төрийн албан дахь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлж, энэ чиглэлээр үйлчилж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

Биелэлт: "Монгол улсын Авлигын эсрэг хууль, Төрийн албаны тухай хууль болон Иргэний хуулийг үндэслэн ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах, ашиг сонирхлын зөрчилд орсон нөхцөл байдлыг зохицуулах зорилгоор 7 зүйл бүхий "Ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах гэрээ"-г 2010 оны 1 дүгээр улиралд нийслэлийн нутгийн захиргааны 28 байгууллагын төрийн захиргааны 1513 албан хаагч байгуулж ажилласан. Шинээр ажилд орсон 15 байгууллагын 75 албан хаагчтай нэмж гэрээ байгуулсан.

Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол маргааныг хянан дүгнэлт гаргаж, Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэх эрх бүхий орон тооны бус "Нийслэлийн Засаг даргын дэргэдэх ёс зүйн зөвлөл"-ийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

"Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрэм", "Нийслэлийн Засаг даргын дэргэдэх ёс зүйн зөвлөлийн дүрэм"-ийг боловсруулан, холбогдох хэлтсүүдээс санал авч нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэн нийслэлийн Засаг даргын захирамжаар батлан мөрдөгдөж байна.

Хэрэгжилт –70%

160. Дэд бүлэг – 4.5

Зорилт – 4.5.6

Арга хэмжээ – 4.5.6.6 Яамдын болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтнуудыг хяналт-шинжилгээ үнэлгээ өндөр хөгжсөн орнуудын туршлага судлуулах, энэ чиглэлээрх гадаад, дотоодын сургалтад ээлж дараатай хамруулах замаар ажилтнуудыг чадваржуулж төрийн захиргааны байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээний онол, арга зүйн түвшинг дээшлүүлнэ

Биелэлт: Нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн 4 мэргэжилтэн дараах сургалтуудад хамрагдсан. Үүнд: СЯ-с зохион байгуулсан хөрөнгө оруулалтын ажилд мониторинг хийх ажлын чиглэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтанд, ЗГХЭГ, Швейцарийн хөгжлийн агентлаг, Монголын Мянганы сорилтын сантай хамтран зохион байгуулсан "Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхийг дээшлүүлэх" сургалтанд хамрагдаж сертификат авсан.

Мөн Авилгалтай тэмцэх газраас зохион байгуулсан "Авилгын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтэнд хяналт тавих" сургалт-семинарт, ЗГХЭГ, Удирдлагын академийн сургуулиас зохион байгуулсан Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын талаар сургалтанд тус тус хамрагдсан.

Хэрэгжилт –50%

161. Дэд бүлэг – 4.5

Зорилт – 4.5.7

Арга хэмжээ – 4.5.7.3 Орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэн, нутгийн өмчийн тухай бие даасан хуультай болгож, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Биелэлт: Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой компаниудын үйл ажиллагааг өргөтгөх, өмч хөрөнгийг шинэчлэх, шинэ өмч бий болгох чиглэлээр үйл ажиллагаа чиглүүлж ажиллаа. Үүнд:

Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний салбарийн санхүү эдийн засгийн үйл ажиллагааг эрүүлжүүлэхэд чиглэгдэж Цахилгаан тээвэр компанийг хувьцаат компани болгон өөрчлөх бэлтгэл ажлыг хийсэн. Нийтийн тээврийн салбарт “Парк шинэчлэлт хөтөлбөр” хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын хөрөнгө оруулалтаар Автобус-1 компанид 120, Автобус-3 компанид 80, Цахилгаан тээвэр компанид 50, нийт 250 автобусыг төсвийн хөрөнгө оруулалтаар нэмэгдүүлсэнээр үйлчилгээний хүрээ сайжирч, өмчийн үр өгөөжийг дээшлүүлсэн ажил болсон.

“Дарцагт” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгаж, тухайн үйлдвэрийн газрын хөрөнгөнд түшиглэн ашигт ажиллагааг дээшлүүлэхэд чиглэсэн бүтцийн өөрчлөлтөнд оруулахаар 2 хувилбарыг сонгон судалгаа хийгдэж байна.

“Дохиолол хамгаалал”, Багахангай дүүргийн “Мах боловсруулах үйлдвэр” нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудыг менежментийн гэрээгээр ажиллуулахаар НИТХ-ын тогтоолоор хувьчлагдах хөрөнгийн жагсаалтанд оруулж, менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийн сонгон шалгаруулах журам, шалгарсан этгээдтэй байгуулах гэрээний төслийг боловсруулаад байна.

Орон сууцны санхүүжилтийн Корпораци ХХК-ний үйл ажиллагааг өргөтгөн, бүтцэд шинээр зээлийн хэлтсийг байгуулсан бөгөөд Засгийн газрын 2009 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчдын 4000 орон сууц” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан хаагчдад үнэ хямдтай орон сууц худалдах журам батлагдан, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, төрийн зээлийн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхлээд байна. Мөн корпорацийн дүрмийн санг 204,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх асуудлыг 2010 оны нийслэлийн төсвийн төсөлд тусгасан. Ингэснээр нийслэлийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх ажилд ахиц дэвшил гарсан байна.

Нийслэлийн өмчийн өгөөжийг дээшлүүлэх, үнэт цаасны зах зээлд идэвхтэй оролцуулах, шинээр хувьцаа, бонд гаргаж биржээр арилжих замаар нийслэлийн хөгжлийн бодлогод нийцсэн хөрөнгө оруулалтын томоохон төслүүд хэрэгжүүлэх зорилгоор “Санхүүгийн корпораци” байгуулахад чиглэсэн ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Монголын хөрөнгийн бирж хооронд “Шинэ зууны Улаанбаатар” хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн өөрөө удирдах болон нутгийн засаг захиргааны байгууллагуудыг үнэт цаас, хөрөнгийн зах зээлд идэвхитэй оролцуулах, шинэ хувьцаа, бонд гаргаж биржээр арилжих замаар нийслэлд томоохон төслүүд хэрэгжүүлэх, нийслэлийн өмчийн тодорхой хэсэгт хөрөнгийн зах зээлээр дамжуулан үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Монголын хөрөнгийн бирж хамтран ажиллахаар санамж бичиг үйлдсэн. Энэхүү санамж бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Монголын хөрөнгийн биржтэй хамтран 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан хийх ажлынхаа төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчилэх төсөлд “Санхүүгийн корпораци”-ийг байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, тайлагнах хэм хэмжээг тогтоох, бонд хувьцаа гаргах эрх хэмжээний талаарх зохицуулалтын саналыг тусгаад байна.

Сургуулийн өмнөх насны цэцэрлэгийн хүүхдийн хүнсний хангалт хариуцсан нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудад техникийн шинэчлэлтээр 54,0 сая төгрөгийн үнэ бүхий хөргөх болон хөлдөөх зориулалтын тоног төхөөрөмжийг суурилуулан, хүнсний бүтээгдэхүүний хадгалалт хамгаалалтын стандартыг хангах боломж нөхцлийг сайжруулсан.

Дээрх ажлууд нь нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг өргөтгөх сайжруулахад чухал үр дүн үзүүлж байна.

Хэрэгжилт –50%

162. Дэд бүлэг – 4.5

Зорилт – 4.5.8

Арга хэмжээ – 4.5.8.1

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж, дэмжин 2010 оны 4 дүгээр сард Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай

хуульд нэмэлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлсэн. УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороогоор УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлаар хэлэлцэхэд шаардлагатай тайлбар, судалгаа, тоо, баримтыг гаргаж өгсөн бөгөөд нийслэлийн удирдлагаас байнгын хорооны хуралдаанд оролцож тайлбар хийсэн.

Мөн хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд ХЗДХЯамаар дамжуулан саналаа өгсөн.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд тусгайлан оруулах нэмэлт, өөрчлөлт одоогоор байхгүй бөгөөд Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиар нийслэл хоттой холбоотой илүү нарийвчилсэн зохицуулалт хийхээр ажиллаж байна. УИХ-ын байнгын хороод, УИХ-ын ажлын хэсгийн хуралдаанаар хуулийн төсөл хэлэлцэгдэж байна. Тус хуулийн танилцуулга, үзэл баримтлал, гол гол зарчмын өөрчлөлтүүдийг нийслэл, дүүргийн удирдлага, Захирагчийн ажлын алба, ЗДТГ-ын мэргэжилтэнүүд, хороодын Засаг дарга нарт таниулан сурталчлахаас гадна Ulaanbaatar.mn веб сайтад тавьж, иргэдэд нээлттэй танилцуулсан. Нийслэлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тус хуулийн ач холбогдол, үзэл баримтлалын талаар тусгайлан сурвалжлагыг 5 удаа зохион явуулсан.

Хэрэгжилт –50%

163. Дэд бүлэг – 4.5

Зорилт – 4.5.10

Арга хэмжээ – 4.5.10.1 Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон сонгосон зарим салбарын нийтлэг болон туслах чиг үүргийг хамарсан стратегийн чиг үүргийн шинжилгээг тусгай төлөвлөгөөний дагуу хийж, чиг үүргийн давхардлыг арилгах, зохион байгуулалтын бүтэцийг боловсронгуй болгох, орон тоог цөөрүүлэх арга хэмжээ авна.

Биелэлт: Төрийн бус байгууллагаас гаргасан хүсэлтийг үндэслэн нийслэлийн Засаг даргын 103 дугаар захирамжаар нийгмийн түншлэлийн хүрээнд шийдвэр гарч Монголын хувийн хөдөлмөр эрхлэгчдийн холбоонд хуучин ашиглаж байсан 29 ус түгээх байрыг Өмч эзэмшлийн гэрээгээр шилжүүлсэнээр эдгээр байрны 9-ийг нь үндсэн зориулалтаар нь ашиглаж үлдсэн байруудад жижиг дунд бизнес эрхэлж, оёдол, ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. ТЗУХ

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудтай хамтарч ажиллах төрийн бус байгууллагуудын судалгаа гаргаж, нийслэлийн Хүний эрхийн хороо, Хурлын дэргэдэх Хүний эрхийн дэд хороотой хамтарч төрийн бус байгууллагуудын уулзалт зохион байгуулсан. Энэхүү уулзалтанд 21 байгууллагын 40 гаруй хүн хамрагдаж тус хурлаас нийслэлийн Иргэдийн Төлөөгчдийн хурлын дэргэд “Иргэний нийгмийн зөвлөл” байгуулахаар болж, тухайн зөвлөлийн ажиллах журмыг боловсруулж гаргах ажлын хэсгийг байгуулж, зөвлөл сар бүр уулзаж байх, хийх ажлын чиглэлээ гаргах, хамтарч ажиллах талаар ярилцаж тохирсон.

Нийслэлийн хороодод байгуулагдсан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх “Хамтарсан баг”-ийг бэхжүүлэх зорилгоор 9 дүүргийн хэмжээнд Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төв, Хүүхэд эрх хамгаалал төв, Хүүхдийг хүчирхийлэлээс хамгаалах төвтэй хамтарч сургалт зохион байгуулсан.

Архидалтын эсрэг үндэсний итгэл их хөдөлгөөн төрийн бус байгууллагад ажил гүйцэтгүүлэхээр нийслэлийн Засаг даргын захирамжаар 5 сая төгрөг олгож үйл ажиллагааг дэмжиж ажилласан.

Хэрэгжилт –50%

Бүлэг – Тав. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН ЗОРИЛТ

5.1 Гадаад бодлого

164. Дэд бүлэг – 5.1

Зорилт – 5.1.1

Арга хэмжээ – 5.1.1.14 ОХУ, БНХАУ, АНУ, Канад, Япон, ХБНГУ, БНСУ, БНКаз У-тай аймаг, хотуудын шууд харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: ОХУ-ын Эрхүү, Улаан-Үүд, БНХАУ-ын Эрээн, ӨМӨЗО-ны Хөх хот, БНСУ-ын Намьянжу хотуудын аялал жуулчлалын хэлтэс газруудтай холбоо тогтоон хамтран ажиллах тохиролцоонд хүрсэн.

2010 онд ОХУ-ын Эрхүү болон Улаан-Үүд хотуудад болсон үзэсгэлэн худалдаанд Монголын аж ахуйн нэгжүүдийг хамруулан оролцуулсан. ӨМӨЗО-ны Хөх хот, БНХАУ-ын Эрээн хотуудын Аялал жуулчлалын газартай холбоо тогтоон туршлага солилцох, аялал жуулчлалын компаниудыг холбох, боловсон хүчнүүдийг сургалтанд хамруулахаар тохиролцсоноос гадна Эрээн хоттой аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах “Санамж бичиг”-т гарын үсэг зурсан. Мөн БНСУ-ын Намьянжу хотын Монголын соёлын төв, Аялал жуулчлалын газартай холбоо тогтоон соёл урлагын өдөрлөг зохион байгуулахаар тохиролцсон.

ОХУ-ын Буриад Улсын нийслэл Элстэй хоттой Улаанбаатар хот Ах дүү хотууд болсон. Нийслэлийн Хануул дүүрэг БНСУ-ын Гёнсан мужийн Хаман сумтай холбоо тогтоосон. БНХАУ-ын Инчуан хоттой Улаанбаатар хот хамтарч ажиллах гэрээ байгуулсан.

Хэрэгжилт –50%

5.2 Батлан хамгаалах бодлого

165. Дэд бүлэг – 5.2

Зорилт – 5.2.7.

Арга хэмжээ – 5.2.7.1 Дайчилгааны 1,2-р зэргийн бэлтгэл үүргэтний сургалтын чанар оролцох бүрэлдэхүүнийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

Биелэлт: Дайчилгааны бэлтгэл нөөцийн бага мэргэжилтэн бэлтгэх сургалтыг Зэвсэгт хүчний 7 ангитай хамтран 7 мэргэжлээр явуулсан бөгөөд сургалтын дунд, төсгөлд ЗХЖШтабын холбогдох газар, хэлтсээс томилогдсон бүрэлдэхүүн шалгалт авч, үнэлэлт дүгнэлт өгсөн.

БХИСургуульд 2 мэргэжлээр 24 иргэ, бэлтгэл офицерын сургалтанд хамрагдан тангараг өргөж, ЗХЖШтабын даргын тушаалаар бэлтгэл дэслэгч цол олгосон. Сургалтын дүнд эзэмшсэн мэргэжлийн дагуу анги, командуудад оногдуулан данслагдаж, дайчилгааны даалгавараар хангагдаагүй дутуу байгаа нөөцтэй харьцуулсанаар бэлтгэл офицерыг 4,5 хувь, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн цэрэг, түрүүчийг 4 хувиар тус тус нэмэгдүүлсэн.

Хэрэгжилт –50%

5.3 Гамшгаас сэргийлэх, хор хөнөөлийг арилгах үндэсний чадавхи бэхжүүлэх бодлого

166. Дэд бүлэг – 5.3

Зорилт – 5.3.2

Арга хэмжээ – 5.3.2.3 Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт аврах гал унтраах нэгж шинээр нэмж байгуулна.

Биелэлт: Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар 2009 онд нийслэлийн Онцгой байдлын газрын Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн харъяа гуравдугаар зэрэглэлийн Аврах гал унтраах 29 дүгээр ангийг Агаар десантын отрядын хуучин барилгыг засварлан шинээр байгуулснаар 48 албан хаагч, 3 автомашинтайгаар ажиллаж байна. Уг ажилд Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсээс 8,9 сая төгрөг зарцуулсан.

Баянзүрх дүүргийн Гачуурт тосгонд баригдах Онцгой байдлын хэлтсийн II зэрэглэлийн Аврах, гал унтраах 35 дугаар ангийн барилга ажилд хяналт тавих ажлын хэсгийг баталсан. Тус барилгын гүйцэтгэлийн ажлыг хийхээр "Ган цамхаг" ХХК тендерт шалгарч ажлаа эхлүүлээд байна. Уг ажилд Улсын төсвөөс 916 сая төгрөг төсөвлөсөн.

Хэрэгжилт –50%

167. Дэд бүлэг – 5.3

Зорилт – 5.3.4

Арга хэмжээ – 5.3.4.2 Төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын материаллаг бааз, хүний нөөцийн чадавхийг сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, арга хэмжээ авна.

Биелэлт: Багаж аппаратуудын хэвийн үйл ажиллагааг хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

- Масс сонголтын детектортой хийн хроматограф GCMS-ийн аппаратаар тодорхойлох Масс сонголтын детектортой хийн хроматограф GCMS-ийн аппаратаар тодорхойлох хлорт органик пестицидүүд болон органик пестицидүүд нийт 23 пестицидийн жиших муруйг байгуулан тоон хэмжээнд тодорхойлдог болсон.
- Електрофорезийн аппаратан дээр Ундны усанд анион ба катионуудыг тодорхойлох капилляр электрофорезийн аргууд болох PH 5064-8206, PH 5064-8575 аргуудыг орчуулж байгууллагын стандарт болгон мөрдөж кальци, магни, аммиак, натрий, калий катионуудыг тодорхойлох шинжилгээг хийж гүйцэтгэж байна.
- "Медимпекс" ХХК-тай хамтран "Varian" компанийн сервис инженерийг 4-р сард нийслэлд урьж ирүүлэн 2001 онд суурилагдсан атом шингээлтийн спектрофотометр аппаратны графитийн системийг ажиллагаанд оруулж, программ хангамжыг нь шинэчлэн хүчин чадлыг нь сайжрууллаа. Мөн шинжээч-мэргэжилтнүүдэд 5 хоногийн сургалт зохион байгууллаа. Үүний үр дүнд хүнсний бүтээгдэхүүнд

агуулагдах хүнд, хорт металлуудын үлдэгдэл тодорхойлох шинжилгээг 10^{-9} зэрэг нарийвчлалтайгаар олон улсын түвшинд хийж гүйцэтгэж байна.

- Микробиологийн лабораторид шинжилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд өндөр мэдрэг VITEK, VIDAS зэрэг багажаар хангах, молекул биологийн лаборатори байгуулах 250.000 долларын өртөгтэй төслийг боловсруулан НИТХ болон Улаанбаатар "РОТАРИ" клубт хүргүүлсэн. Уг төслийг англи хэл дээр орчуулан "Дэлхийн зөн" болон төрийн бус, тусламжийн олон улсын бусад газруудад хүргүүлэхээр бэлтгэж байна.

Шинжээч-мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх ажлын хүрээнд :

- "Мед Импекс" ХХК-с зохион байгуулсан 14 хоногийн сургалтанд 1 химичийг хамруулж "Хроматографийн шинжилгээний ерөнхий ойлголт", "Калибровка хэрхэн хийх, онол" сэдвээр сургасан. Одоогоор багажны ерөнхий тохиргоо хийгдэж, цаашид зөгийн баланд сахароз, фруктоз, глюкоз, инверсийн чихэрлэг тодорхойлох шинжилгээг хийх туршилт явагдаж байна.
- 2010 оны 4-р сард "Мед Импекс" ХХК-тай хамтран "Varian" компаний мэргэжилтэн В.В.Михайлыг урьж ирүүлэн лабораторийн мэргэжилтнүүдийг ААС-ын багажин дээр ажиллуулж сургах 5 хоногийн сургалт зохион байгууллаа. Энэ сургалтаар лабораторийн 5 шинжээчид "Varian" фирмийн сургалтын албан ёсны сертификат олгогдсон.
- Микробиологийн лабораторийн шинжээчийг БНСУ-ын "Хүнсний эрдэм шинжилгээний хүрээлэн"-нд "Мал амьтны гаралтай бүтээгдэхүүний чанарын хяналт" сэдэвт 10 хоногийн сургалтанд хамруулсанаас гадна Энэтхэг улсын "Усны эрдэм шинжилгээний хүрээлэн"-нд Усны микробиологийн шинжилгээ 2 сарын лабораторийн практик сургалтанд хамруулж байна.

Хэрэгжилт –50%

168. Дэд бүлэг – 5.3

Зорилт – 5.3.5

Арга хэмжээ – 5.3.5.4 Хүнсний бүтээгдэхүүни аюулгүй байдлын үзүүлэлтүүд, норм нормативыг шинэчлэн боловсруулна.

Биелэлт: Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлтүүд норм, нормативийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, нормыг шинэчлэн боловсруулсан төслөө хэлэлцүүлж, санал, зөвлөмжийг тусган саналаа ЭМШУИС, ЭМЯ-нд хянан засварлуулахаар өгөөд байна.

МХЕГ-аар даргын баталсан тушаалын дагуу "Хүнсний тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөх ажлын хэсэгт орж ажилласан. "Бараа түүхий эдийн биржийн тухай" хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл, "Хүнсний тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал боловсруулж ХХААХҮЯ-нд Дүрэм журам норм нортамив шинээр боловсруулах 2 төсөл, нэмэлт өөрчлөлт оруулах 4 санал, стандартад нэмэлт өөрчлөлт оруулах 3 санал хүргүүлсэн.

"Үндэсний тохирлын тэмдэг хэрэглэх, эрх олгох журам", "Бялууны төрлийн бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага" MNS:0464 стандартын төсөлд, "Жимсний чанамал" MNS 462:77 стандартад өөрчлөлт оруулах ажлын хүрээнд MNS 0462:77, MNS 1054:85, MNS 2697:79, MNS CAC 79:96 болон ОХУ, Европын Холбооны Улсын холбогдох стандартуудыг судалж, стандартын төслийг боловсруулан МХЕГ-т хүргүүлсэн.

Хэрэгжилт –70%

169. Дэд бүлэг – 5.3

Зорилт – 5.3.5

Арга хэмжээ – 5.3.5.5 Үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаанд тавигдах эрүүл ахуйн чиглэлийн стандартуудыг шинэчилж, эрсдэлд суурилсан хяналт тавих аргыг нэвтрүүлнэ.

Биелэлт: МХЕГ-ын 2010 оны төлөвлөгөөний дагуу хүнсний үйлдвэрлэлийн 5 чиглэлээр "Техникийн ерөнхий шаардлага болон хяналтын хуудас" боловсруулах ажлын хэсгийг байгуулан МХЕГ-ын дэд даргаар удидамж, төлөвлөгөөг батлуулсан. Үүний дагуу ажлын хэсгүүд "Техникийн ерөнхий шаардлага болон хяналтын хуудас" боловсруулан 3 удаагийн нэгдсэн хэлэлцүүлгийг ЭМЯ, ХХААХҮЯ, Стандарт хэмжил зүйн газар, ШУТИС, ЭМШУИС, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн эрдэмтэн, мэргэжилтнүүдийг оролцуулан хийлээ. Хүнсний үйлдвэрлэлийн үндсэн 4 чиглэлээр хийсэн "Техникийн ерөнхий шаардлага болон хяналтын хуудас"-ыг МХЕГ-т хүргүүлж, орон нутаг дах Мэргэжлийн хяналтын байгууллагуудаас санал авч, нэгтгэн дараагийн хэлэлцүүлэх уулзалтанд танилцуулахаар бэлэн болсон.

"Үс засах үйлчилгээ", Ерөнхий шаардлага MNS 5160:2002 стандарт, НИТХ-ын тэргүүлэгчдийн 71 тоот "Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам", НИТХ-ын тэргүүлэгчдийн 72 тоот "Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний нийтлэг журам"-д, "Монгол

гэрийн эсгий. Техникийн шаардлага” MNS 296:2008 стандарт, “Монгол гэрийн бүрээс хөшиг. Техникийн шаардлага” MNS 414:86 стандартад, “Бага оврын цэвэрлэх байгууламж”-ийн стандарт, “Авто үйлчилгээ. Ангилал. Ерөнхий шаардлага” MNS 5025:2001 улсын стандартад, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, эмийн сангийн стандарт, “Мал эмнэлэг үржлийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа” стандартад, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулж МХЕГ-т хүргүүлсэн.

Хэрэгжилт –70%

ТОВЧИЛСОН НЭРСИЙН ТАЙЛБАР

1. ЗГХЭГ – Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
2. УИХ – Улсын Их хурал
3. БОАЖЯ – Байгаль орчин, аялал жуулчлалын яам
4. БСШУЯ – Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
5. ЗТБХБЯ – Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам
6. НХХЯ – Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
7. ХХААХҮЯ – Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
8. ХЗДХЯ – Хууль, зүй дотоод хэргийн яам
9. ЭБЭХЯ – Эрдэс баялаг, эрчим хүчний яам
10. ГХЯ – Гадаад хэргийн яам
11. СЯ – Сангийн яам
12. ЭСЯ – Элчин сайдын яам
13. ХХҮГ – Хөдөлмөр халажмийн үйлчилгээний газар
14. ЦЕГ – Цагдаагийн ерөнхий газар
15. МХЕГ – Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
16. ГЕГ – Гаалийн ерөнхий газар
17. ОБЕГ – Онцгой байдлын ерөнхий газар
18. ҮХШХ – Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо
19. ЗХЖШ – Зэвсэгт хүчний жанжин штаб
20. ХӨСҮТ – Халдварт өвчин судлалын үндэсний төв
21. МҮХАҮТ – Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
22. МХГ – Мэргэжлийн хяналтын газар
23. ЖДҮГ – Жижиг дунд үйлдвэрийн газар
24. ШУА – Шинжлэх ухааны академи
25. РТХЭГ – Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
26. МҮОНТ – Монголын үндэсний олон нийтийн телевиз
27. ОССК – Орон сууцны санхүүжилтийн корпорац
28. ОСНААУГ – Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар
29. МАЖХ – Монголын аялал жуулчлалын холбоо
30. АХБ – Азийн хөгжлийн банк
31. НҮБ – Нэгдсэн үндэсний байгууллага
32. ДЭМБ – Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
33. ДЗМОУБ – Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага
34. МХСС – Мянганы хөгжлийн сорилтын сан
35. НИТХ – Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчидийн хурал
36. ЗДТГ – Засаг даргын тамгын газар
37. ЗЦГ – Замын цагдаагийн газар
38. ЗЦТ – Замын цагдаагийн тасаг
39. ОУБ – Олон улсын байгууллага
40. ЖДҮДС – Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
41. УБ ЦТС – Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ

42. УБ ДШС – Улаанбаатар дулааны шугам сүлжээ
43. ЭХГ – Эрчим хүчний газар
44. УҮГ – Улсын үйлдвэрийн газар
45. ЭНЭШТ – Эх нялхасын эрдэм шинжилгээний төв
46. ЭМН – Эрүүл мэндийн нэгдэл
47. ХӨСҮТ – Халдварт өвчин судлалын үндэсний төв
48. ШУТИС – Шинжлэх ухаан, технологийн их сургууль
49. БХИС – Батлан хамгаалахын их сургууль
50. ОУБ – Олон улсын байгууллага
51. ТЭЗҮ – Техник, эдийн засгийн үндэслэл
52. ЕБС – Ерөнхий боловсролын сургууль
53. СӨБ – Сургуулийн өмнөх боловсрол
54. ТББ – Төрийн бус байгууллага
55. НААСТ – Нийтийн аж ахуйг сайжруулах төсөл
56. ААНБ – Аж ахуйн нэгж, байгууллага
57. НӨҮГ – Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар
58. НЭ – Нэгдсэн эмнэлэг
59. ШТС – Шатахуун түгээх станц
60. ХЭДС – Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
61. ЖДҮДС – Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
62. ХБНГУ – Холбооны бүгд найрамдах Герман улс
63. БНСУ – Бүгд найрамдах Солонгос улс
64. ОХУ - Оросын холбооны улс
65. БНХАУ – Бүгд найрамдах Хятад ард улс

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР